



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх  
журам, заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 8.1.24 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах журам"-ыг нэгдүгээр, "Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хянах журам"-ыг хоёрдугаар, "Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулах журам"-ыг гуравдугаар, "Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний бүртгэл мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний журам"-ыг дөрөвдүгээр, "Сүрьеэгийн дэгдэлтийг тандах, хянах, хариу арга хэмжээг зохион байгуулах журам"-ыг тавдугаар, "Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөний журам"-ыг зургаадугаар, "Сүрьеэгийн эм бэлдмэл, урвалж бодис, халдварын сэргийлэлт, хяналтын хэрэгслийн ханган нийлүүлэлтийн журам"-ыг долоодугаар, "Сүрьеэгийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар"-ыг наймдугаар, "Бүртгэлийн маягтууд"-ыг есдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж, сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа)-д, харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, батлагдсан журам, зааврыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С. ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
01 сарын 29 өдрийн 38 тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт

## Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах журам

### 1. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах, сүрьеэгийн тусламж, үйлчилгээний үндсэн зарчим, чиглэл, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтооход оршино.

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай" А/528 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай" А/609 дугаар тушаалыг хэрэгжүүлэхээр зохион байгуулна.

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний удирдлага зохион байгуулалт нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны Монгол Улсын стандарт, Эрүүл мэндийн сайд(ЭМС)-ын 2018 оны А/485 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх жагсаалт, журам", ЭМС-ын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Сум, тосгоны эрүүл мэндийн төвд тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, жагсаалт", ЭМС-ын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт", болон бусад тусламж, үйлчилгээний зохицуулалтын чиглэлээр гарсан тушаал шийдвэрийг тус тус мөрдлөг болгон үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж ажиллана.

### 2. Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний үндсэн зарчим

#### 2.1 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зарчим

- Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, тэдний сонголтод тулгуурласан,
- Үйлчлүүлэгчийг сонсох, итгэлцлийг бий болгох харилцаа хандлагатай,
- Ялгаварлан гадуурхалтаас ангид байж хүний эрхийг дээдэлсэн,
- Санхүүгийн дарамт учруулахгүй, ил тод, ойлгомжтой зохицуулалттай,
- Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангасан,
- Салбар дундын үр дүнтэй хамтын ажиллагаанд тулгуурласан байна.

#### 2.2 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний үнэт зүйлс

- Эрүүл мэндээ хамгаалуулах тэгш эрх
- Олон нийтийн аюулгүй байдал
- Эв нэгдэл, харилцан ойлголцол, хүндлэл
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах, хадгалах
- Хүний эмзэг мэдээллийг хамгаалах, хадгалах
- Эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, хадгалах

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, эрүүл мэндийн сайн дурын ажилтан дээрх зарчмыг адил мөрдөж, үйлчлүүлэгчийн хүний эрхийг дээдлэн ажиллана.

Дэлхий нийтээр хэрэгжүүлж буй "Сүрьеэг устгах стратеги"-ийн үндсэн тулгуур болох үйлчлүүлэгч төвтэй сүрьеэгийн тусламж үйлчилгээг сүрьеэгээр өвчилсөн, оношлогдоогүй, халдвар авах өндөр эрсдэлтэй гэр бүлийн гишүүд, ойрын хавьтал болон сүрьеэгийн улмаас нийгэм сэтгэлзүй, санхүүгийн дарамтад өртсөн гэр бүлийн хүүхдэд хүний эрхийг дээдлэн хүргэнэ.

### **3. Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний төрөл, хэлбэр**

Эрүүл мэндийн байгууллага сүрьеэгийн тусламж, үйлчилгээг дараах төрлөөр үзүүлэхдээ энэхүү журам, үйл ажиллагааны заавар, эмнэлзүйн заавар, тэдгээрийг хэрэгжүүлэхээр төрөлжсөн мэргэшлийн эрх бүхий эрүүл мэндийн байгууллагаас баталсан түгээмэл үйлдлийн стандарт аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

#### **3.1 Сүрьеэгийн чиглэлээр үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:**

- Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа
- Урьдчилан сэргийлэх, илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо
- Тандалт судалгаа, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээ
- Дархлаажуулалт, сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
- Тусгаарлан эмчлэх тусламж, үйлчилгээ
- Дэгдэлтийн үеийн тусламж, үйлчилгээ

#### **3.2 Эрүүл мэндийн анхан шатлалд үзүүлэх сүрьеэгийн тусламж, үйлчилгээний төрөл:**

- Амбулаторийн үзлэг, оношилгоо, хяналт
- Эрүүл мэндийн мобайл үйлчилгээ
- Шууд хяналттай өдрийн эмчилгээ, хяналт
- Цахим хяналттай гэрийн эмчилгээ, хяналт
- Ойрын болон алсын түргэн тусламжийн үйлчилгээ
- Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ
- Гэрийн эргэлт, хөнгөвчлөх эмчилгээ
- Идэвхтэй илрүүлэлт
- Сорьц цуглуулах, тээвэрлэх
- Өрхийн болон ойрын хавьтлын үзлэг, хяналт

#### **3.3 Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад үзүүлэх сүрьеэгийн тусламж, үйлчилгээний төрөл:**

- Амбулаторийн тусламж, үйлчилгээ
- Шууд хяналттай өдрийн эмчилгээ
- Цахим хяналттай гэрийн эмчилгээ
- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ
- Хөнгөвчлөх эмчилгээ
- Явуулын амбулаторийн үйлчилгээ
- Тусгаарлан эмчлэх тусламж, үйлчилгээ
- Өрхийн болон ойрын хавьтлын үзлэг шинжилгээ
- Алсын дуудлага, яаралтай тусламж
- Телемедициний зөвлөгөө өгөх үйлчилгээнээс бүрдэнэ.

### **4. Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг**

#### **4.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв**

4.1.1 Сүрьеэг устгах стратеги, халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх, арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд сүрьеэгийн чиглэлээр дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, үр дүнг тооцон сайжруулах ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.

4.1.2 Сүрьеэгийн төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж үйлчилгээг үндэсний хэмжээнд үзүүлж, энэ чиглэлээр төр, хувийн хэвшлийн бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн нэгдсэн арга зүйгээр тасралтгүй ханган дуудлагаар болон телемедицинээр зөвлөгөө өгөх, цахим зөвлөгөөнийг зохион байгуулах замаар хамтран ажиллана.

4.1.3 Сүрьеэгийн эмнэлзүйн тусламж, үйлчилгээнд мөрдөх түгээмэл үйлдлийн стандарт аргачлал, үйл ажиллагааны зааврыг дараах чиглэлээр боловсруулах, шинэчлэх, эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах тасралтгүй сургалтыг зохион байгуулна. Үүнд:

- Шинжлэгдхүүнийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, илгээх аргачлал
- Түрхцийн шинжилгээ хийх, хариуг дүгнэх, мэдээлэх аргачлал
- Молекулын шинжилгээ хийх, хариуг дүгнэх, мэдээлэх аргачлал
- Өсгөвөрлөх шинжилгээ хийх, хариуг дүгнэх, мэдээлэх аргачлал
- Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний аргачлал
- Сүрьеэгийн сүлжээ лабораторийн гадаад, дотоод чанарын хяналт хийх, дүгнэх, эргэн мэдээлэх аргачлал
- Сүрьеэгийн халдварыг илрүүлэх лабораторид суурилсан шинжилгээ хийх, хариу дүгнэх
- Эмчилгээний хяналт, хяналтын шинжилгээнд хамруулах аргачлал
- Эмчилгээний явцын болон төгсгөлийн үр дүнг тооцох аргачлал
- Сүрьеэтэй өвчтөн түүний гэр бүлд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх аргачлал
- Эмчилгээ тасалж байгаа өвчтөнтэй ажиллах аргачлал
- Богино хугацааны эмчилгээний горимыг хэрэглэх аргачлал
- Хэт ягаан туяаны гэрлийг ашиглах, хянах аргачлал
- Механик агааржуулалтын системийг ашиглах, хянах аргачлал
- Хувийн хамгаалах хэрэгслийг сонгох, зөв хэрэглэх, устгах аргачлал
- Сүрьеэгийн халдвараас сэргийлэх орчны халдваргүйтгэл хийх аргачлал
- Сүрьеэ илрүүлэх рентген шинжилгээ хийх, унших, дүгнэх аргачлал
- Сүрьеэгийн тохиолдлыг мэдээлэх хуудсыг хөтлөх аргачлал
- Сүрьеэгийн тайлан мэдээ гаргах аргачлал
- Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системийг (TUBIS) ашиглах аргачлал
- Хавьтлын үзлэг шинжилгээний аргачлал
- Сүрьеэгийн эм, лабораторийн урвалж, бодис, оношлуурын захиалга, зарцуулалт, ханган нийлүүлэлтийн аргачлал
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал гэх мэт

4.1.4 Сүрьеэгийн өвчлөлийн хөдлөл зүй, чиг хандлага, тархалт, нас баралт, эмчилгээний үр дүнг тандан судалж, сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системийн (TUBIS) нэгдсэн сан үүсгэж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэж, нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулах, сүрьеэгийн тусламж үйлчилгээний үр дүн, үр нөлөө, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг гаргаж олон улс, аймаг, нийслэлийн ЭМГ болон холбогдох бусад байгууллагад улирал, жил тутам эргэн мэдээлнэ.

4.1.5 Улсын хэмжээнд хийгдэж буй сүрьеэгийн лабораториудын шинжилгээнд чанарын гадаад хяналтыг тогтмол хийнэ.

4.1.6 Лабораторийн шинжилгээний гүйцэтгэл, илрүүлэлтийн байдал, эмэнд тэсвэржилтийн мэдээллийг нэгтгэн дүгнэж, хариу арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.1.7 Хүн амын дунд эргэлтэд байгаа сүрьеэгийн үүсгэгчийн хэвшинж, дэд хэвшинжийг системтэй тандан судлах, хувилбарын тандалт хийх авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.1.8 Өвчний шинж тэмдэг илэрснээс эдгэрэх хүртэлх зураглалыг гаргаж, сүрьеэгийн тусламж үйлчилгээнд тулгарч буй асуудлыг хувь хүн, бүлэг, тогтолцооны түвшинд үнэлж холбогдох арга хэмжээ авна.

4.1.9 Үндэсний сүлжээнд ашиглаж байгаа сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системийг (TUBIS) үе шаттай хөгжүүлж, тохиолдолд суурилсан цахим бүртгэл, тандалтын тогтолцоог улсын хэмжээнд нэвтрүүлэн, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай байлгах,

бусад цахим системтэй уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

4.1.10 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системд (TUBIS) цугларч буй тандалтын тогтолцооны мэдээ, мэдээлэл, сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын оношилгоо, шинжилгээ, сүрьеэгийн тохиолдол болон хавьтлын бүртгэл, мэдээлэл, эмчилгээ хяналт, урьдчилан сэргийлэлт, эм, урвалжийн орлого, зарлага, тайлан мэдээнд өдөр тутам тандалт, үнэлгээ, дүн шинжилгээ хийж заавар зөвлөмжийг тухай бүр нь өгч ажиллана.

4.1.11 Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, халдвар хяналтын хэрэгсэл, эм, урвалж бодис, оношлуур захиалах, хүлээн авах, хадгалах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1.12 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургах, чадавхжуулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, үндэсний хэмжээнд зөвлөлдөх уулзалт, чуулган, зөвлөгөөн, сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

4.1.13 Хүн амын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулна.

4.1.14 Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын дэмжих бүлэг, хэвлэл мэдээллийн төлөөлөл, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, өвчтөний дэмжих бүлэг, шашны төлөөллийн дунд ухуулга нөлөөлөл, яриа, хэлэлцэл явуулах, зөвшилцлийг бий болгох замаар олон нийт, бусад оролцогч талуудын харилцааг бэхжүүлнэ.

4.1.15 Хяналт шинжилгээ, үнэлгээг сүрьеэгийн нэгж байгууллага болон холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад газар дээр нь хийхээс гадна тогтмол гардаг тайлан мэдээнд нь дүгнэлт хийх байдлаар гүйцэтгэнэ.

4.1.16 Олон улсын төсөл хөтөлбөрийг боловсруулах, хамтран хэрэгжүүлэх, түүний үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

4.1.17 Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хамтран хэрэгжүүлэх, хурал уулзалт зохион байгуулна.

4.1.18 ДЭМБ болон олон улсын байгууллагуудтай хамтран Сүрьеэгийн үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтэд 5 жил тутам хамтарсан үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.1.19 Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт зохион байгуулж буй байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, эрсдэлт бүлгийг эрэмбэлж, өгөгдлийн нэгдсэн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээлэх, өртөг-үр ашгийг дээшлүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

4.1.20 "Хиймэл оюун ухаан"-нд суурилсан дижитал рентген, компьютер томографийн оношилгоог нэвтрүүлж, эмч мэргэжилтний рентген зураг уншилт, оношилгооны чадавхийг сайжруулж ажиллана.

4.1.21 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн сүрьеэгийн тусламж үйлчилгээний тогтвортой байдлын хангах бодлого, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллана.

4.1.22 Сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг тандан судалж, дэгдэлтийн үеийн арга хэмжээг удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

## **4.2 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв**

4.2.1 Хүн амд сүрьеэ өвчнөөс сэргийлэх мэдлэг, хандлага, дадал төлөвшүүлэх, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах ач холбогдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааг тасралтгүй зохион байгуулж эрүүл мэндийн боловсрол олгоно.

4.2.2 Иргэний нийгмийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагыг сүрьеэгээс сэргийлэх, хянах үйл ажиллагаанд татан оролцуулж, мэргэжил арга зүйгээр хангана.

4.2.3 Сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд хамрагдах талаар эрсдэлт бүлгийн хүн амд сургалт, сурталчилгаа зохион байгуулах нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллана.

4.2.4 Дэмжлэгт орчин бүрдүүлэх зорилгоор шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, ажил олгогч, хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, өвчтөний дэмжих бүлэг, шашны төлөөллийг хамруулж, зөвшилцөл, хэлэлцүүлэг, нөлөөллийн уулзалт зохион байгуулна.

4.2.5 "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүн амын мэдлэг, хандлага, дадал, зан үйлийн өөрчлөлтийг янз бүрийн бүлгийн дунд судлан сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, үр дүнг үнэлэх, судалгаа шинжилгээг хамтран зохион байгуулна.

4.2.6 Сүрьеэд нөлөөлж буй нийгэм, зан үйл, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг тогтоох, үнэлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтарсан судалгаа хийх, үр дүнг олон нийтэд болон холбогдох байгууллага, шийдвэр гаргагч нарт мэдээлэх, ухуулан сурталчлах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

### 4.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

4.3.1 Аймаг, нийслэлийн хэмжээнд Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх, арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд сүрьеэгийн чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.3.2 "Сүрьеэгүй аймаг, сум, дүүрэг, хороо болох" хөдөлгөөн өрнүүлж, цар хүрээг өргөжүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлж, хэрэгжүүлнэ.

4.3.3 Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, сорьц тээвэрлэлт, халдварын сэргийлэлт хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалт, сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

4.3.4 Хүн амд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

4.3.5 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээ авч байгаа өвчтөнүүдийн дунд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт хийх арга хэмжээг зохион байгуулна.

4.3.6 Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, хэвлэл мэдээллийн төлөөлөл, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, сүрьеэтэй өвчтөний дэмжих бүлгийн дунд хэлэлцүүлэг явуулах, зөвшилцлийг бий болгох замаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.3.7 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сүрьеэгийн чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах, хүний нөөцийг бэлтгэх, чадавжуулах тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрны халдварын сэргийлэлт хяналт, аюулгүй ажиллагааг хангаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сүрьеэгээр өвчлөхөөс урьдчилан сэргийлж ажиллана.

4.3.8 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, сүрьеэгийн сорьц тээвэрлэх тогтолцоонд хяналт тавьж ажиллана.

4.3.9 Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ, хяналтын ажилд заавар, журам, удирдамжийг мөрдүүлж, хэрэгжилтэд дотоодын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.

4.3.10 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний журам, зааврыг хэрэгжүүлэхэд орон нутгийн бодлогын зохицуулалт, удирдлагаар ханган ажиллана.

- 4.3.11 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн тасаг, алба/диспансерын сүрьеэгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг "Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт"-д заасан бүрэн орон тоогоор ажиллуулах ажлыг зохион байгуулна.
- 4.3.12 Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай, эмчилгээ таслах зэргээр сүрьеэгийн халдварыг олон нийтэд тараах эрсдэлтэй иргэний эмчилгээний тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага, асрамжийн газар, хүүхэд хамгааллын төвүүдтэй хамтран ажиллах санамж, гэрээ, хамтарсан тушаалыг гаргаж хэрэгжүүлнэ.
- 4.3.13 Сүрьеэгийн дэгдэлтийг цаг алдахгүй мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлэх, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, орон нутгийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.
- 4.3.14 Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд ханган нийлүүлсэн тоног төхөөрөмж, халдварын сэргийлэлт хяналтын хэрэгсэл, эм, урвалж бодис, оношлуур, туберкулины арьсны сорил гэх мэт захиалгыг хүлээн авч байгууллагын орлогод бүртгэж авч зарцуулалтад хяналт тавина.
- 4.3.15 Өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийг даатгалд хамруулж, урсгал зардал, засвар үйлчилгээг төлөвлөн ажиллаж тогтвортой ажиллагааг хангана.
- 4.3.16 Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй хамтран сүрьеэтэй өвчтөний хавьтлын илрүүлэлт, үзлэг хяналтыг зохион байгуулж, холбогдох тайлан мэдээг гаргаж мэдээлнэ.
- 4.3.17 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн шинэчлэн гаргасан сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгааны дагуу идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулж тайланг улирал тутам ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд мэдээлнэ.
- 4.3.18 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр очиж буй албан тоот, дэмжлэгт хяналтын зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тайлант хугацаанд нь эргэн мэдээлнэ.

#### **4.4 Аймаг, дүүргийн бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв**

- 4.4.1 Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны Монгол Улсын стандартын дагуу аймаг, дүүргийн сүрьеэгийн тасаг, диспансерын нэгжийг бүрэн орон тоогоор ажиллуулж, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж, эрх бүхий газарт тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.4.2 Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж, эм, хэрэгсэл, урвалж бодис, оношлуур, халдварын сэргийлэлт, хяналтын хэрэгслийг захиалах, хадгалах, хуваарилах, түгээх, зарцуулалтын асуудлыг холбогдох хууль тогтоол, тушаал зааврын дагуу зохион байгуулна.
- 4.4.3 Үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг идэвхтэй тандалтаар эрт илрүүлж, холбогдох үзлэг шинжилгээг зохион байгуулна.
- 4.4.4 Сүрьеэгийн тасаг, алба/диспансерын үйл ажиллагаа, ажлын байранд халдварын сэргийлэлт, хяналт, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн, дотоод хяналт тавьж ажиллана.
- 4.4.5 Бүртгэгдсэн өвчтөний сүрьеэгийн эрчимт болон үргэлжлэх шатны эмчилгээг эмнэлзүйн зааварт заагдсан арга технологиор хийж, эмчилгээний явцын хяналт, хөдөлмөрийн чадвар түр алдалтын асуудлыг зохицуулна.
- 4.4.6 Сүрьеэгүй аймаг, дүүрэг болох хөдөлгөөн өрнүүлж, иргэн олон нийтийг татан оролцуулна.
- 4.4.7 Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай, эмчилгээ таслах сүрьеэгийн халдварыг олон нийтэд тараах эрсдэлтэй иргэний сүрьеэгийн эмчилгээний тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага,

асрамжийн газар, хүүхэд хамгааллын төвүүдтэй хамтран ажиллах санамж, гэрээ, хамтарсан тушаалыг гаргаж хэрэгжүүлнэ.

4.4.8 Сүрьеэгийн эрт илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулах, сүрьеэгийн эмчилгээний хяналтад иргэний нийгмийн байгууллага, сүрьеэгийн дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах санамж, гэрээ, хамтарсан тушаал гаргаж хэрэгжүүлнэ.

4.4.9 Идэвхтэй үзлэг шинжилгээгээр илэрсэн сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх зорилгоор эмчилгээ эрхэлсэн орлогч, сүрьеэгийн эмч, тархвар судлаач, хүүхэд, дотор, дүрс оношилгоо, мэс засал, лабораторийн эмч мэргэжилтнээс бүрдсэн эмнэлзүйн багийг томилж, ажиллуулна.

4.4.10 Жирэмсэн, төрсний дараах үеийн сүрьеэг эрт илрүүлэх, эмчлэх, хянах арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.4.11 Эмнэлзүйгээр оношлогдсон сүрьеэ, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, хяналтын асуудлыг сүрьеэгийн эмч нарын зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

4.4.12 Сүрьеэгийн дэгдэлтийг илрүүлэх, цаг алдахгүй мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлэх, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.4.13 Олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд ханган нийлүүлсэн эм, урвалж бодис, оношлуур, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, зарцуулалтын тайланг ХӨСҮТ-д тогтсон хугацаанд нь мэдээлнэ.

4.4.14 Эрүүл мэндийн ажилтны дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр сургалт тогтмол зохион байгуулж, дотоод хяналт үнэлгээ хийж, хүний нөөцийг чадавхжуулна.

4.4.15 Сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийн гишүүдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

4.4.16 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр очиж буй албан тоот, дэмжлэгт хяналтын зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тайлант хугацаанд нь эргэн мэдээлнэ.

#### **4.5 Сүрьеэгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний тасаг, алба /диспансер/**

4.5.1 Сүрьеэг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сургалт сурталчилгааг нийт хүн ам, зорилтот бүлэг болон үйлчлүүлэгчдэд тогтмол зохион байгуулна.

4.5.2 Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, олон нийтийг татан оролцуулах, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх чиглэлээр манлайлан ажиллана.

4.5.3 Аймаг, нийслэлийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон орон нутгийн засаг захиргааны нэгж байгууллагуудтай хамтран идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулж сүрьеэгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.5.4 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг байгууллагын түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

4.5.5 Идэвхтэй илрүүлэлтийн тайланг улирал тутам ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд мэдээлж, илэрсэн тохиолдлыг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д тухай бүр бүртгэнэ.

4.5.6 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хувийн эмнэлэг, бусад эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн болон өөрөө ирж үйлчлүүлж буй сүрьеэтэй байж болзошгүй иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулан онош тодруулна.

4.5.7 Эмч сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг оношлох шинжилгээний хүсэлтийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори болон ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторид илгээнэ.



Шинжилгээний хүсэлт илгээгдсэн өвчтөний сорьцыг аймаг, дүүргийн болон Сүрьеэгийн үндэсний лавлагаа лаборатори хүлээн авч шинжилгээг хийж, хариуг цаг тухайд нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэж баталгаажуулна.

4.5.8 Сүрьеэгийн оношлогдсон тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг алдалгүй бүртгэж тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн хөгжлийн төвд холбогдох журмын дагуу мэдээлнэ.

4.5.9 Тандалтын тогтолцоонд цугларч буй мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ХӨСҮТ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эргэн мэдээлэл, тайлан, дүн шинжилгээ, зөвлөмжийг аймаг, нийслэл, орон нутгийн шийдвэр гаргагч, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж хариу арга хэмжээ авч ажиллана.

4.5.10 Сүрьеэ оношлогдсон дарууд өвчний үе шат, халдвар ялгаруулалт, хавсарсан эмгэг, эмчилгээ таслах эрсдэлийг үнэлж, тусламж, үйлчилгээний төрөл, эмчилгээний хэлбэрийг сонгоно.

4.5.11 Өвчний шинж тэмдэг илэрснээс эдгэрэх хүртэлх зураглалыг гаргаж, сүрьеэгийн тусламж үйлчилгээнд тулгарч буй асуудлыг хувь хүн, бүлэг, тогтолцооны түвшинд үнэлж, холбогдох арга хэмжээг авна.

4.5.12 Өвчтөн төвтэй тусламж, үйлчилгээг үзүүлж, өвчтөн, түүний гэр бүлтэй хамтран эмнэлзүйн зааварт заасан эмчилгээний хяналт тавих арга хэлбэрээс сонгож, шууд хяналттай эмчилгээг хийнэ.

4.5.13 Эмнэлзүйн зааварт заасан шалгуурын дагуу батлагдсан орны тоонд нийцүүлэн хэвтүүлэн эмчлэх болон амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

4.5.14 Сүрьеэтэй өвчтөнд эмнэлзүйн үечилсэн дүгнэлт гаргаж холбогдох шинжилгээнд цаг хугацаанд нь хамруулна.

4.5.15 Сүрьеэгийн эмчилгээний шууд хяналтыг сайн дурын ажилтан, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, бусад мэргэшлийн тасаг нэгжийн эрүүл мэндийн ажилтнаар гүйцэтгүүлэхэд үйлчлүүлэгч тус бүрээр гурвалсан гэрээ байгуулж, хяналт тавьж буй ажилтныг эмчилгээ эхлэхээс өмнө сургалтад хамруулсан байна.

4.5.16 Сүрьеэгийн эмчилгээний шууд хяналтыг үйлчлүүлэгчийн хүсэлт, эмнэлзүйн заалтаар гуравдагч төлөөллөөр гүйцэтгүүлэх нь тухайн аймаг, дүүргийн сүрьеэгийн алба/диспансерын тухайн тохиолдлыг хариуцсан эмчлэгч эмчийн эрх, үүргийг хязгаарлах, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.5.17 Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, төвийн тархвар судлаач, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй хамтран сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзлэг, шинжилгээг зохион байгуулж сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг тухайд нь бүртгэж мэдээлнэ.

4.5.18 Сүрьеэтэй өвчтөний болон сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд орж буй тохиолдлын эмчилгээний горим, явцын хяналт, эмийн орлого, зарлага, үр дүнгийн мэдээллийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг тухайд нь бүртгэж, эмчилгээг хяналттай хийнэ.

4.5.19 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. Мөн жил, улирал, сарын тайлан мэдээнд дүгнэлт хийж авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.5.20 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн ажилтанд сүрьеэтэй өвчтөний эмийг эмчилгээ хяналтын картын хуулбарын хамт хүлээлгэн өгч мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

4.5.21 Сүрьеэтэй өвчтөний эмийг эмчилгээ хяналтын картын хуулбарын хамт эмчилгээний шууд хяналтыг хийх сайн дурын ажилтанд хүлээлгэн өгч мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

4.5.22 Сүрьеэгийн илрүүлэлт болон сүрьеэгийн эмчилгээний хяналтад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах санамж, гэрээ, хамтарсан тушаал гаргаж хэрэгжүүлнэ.

4.5.23 Эмнэлзүйн багийн эмч нарын хурлаар идэвхтэй илрүүлэлтийн тохиолдлуудыг тогтмол хэлэлцэж, шийдвэрлэнэ.

4.5.24 Сүрьеэгийн эмчилгээг таслах эрсдэлийг үнэлж, эмчилгээний хяналт алдагдахаас урьдчилан сэргийлэх, эмчилгээ тасалсан өвчтөнийг эмчилгээнд дахин хамруулах, бүрэн төгс эмчлэх арга хэмжээг холбогдох цагдаагийн болон халамжийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.5.25 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс дэгдэлт байж болзошгүй нөхцөлийг тогтмол тандаж, сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

4.5.26 Сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийн гишүүдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

#### **4.6 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв**

4.6.1 Сүрьеэг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сургалт сурталчилгааг нийт хүн амд зохион байгуулж сүрьеэгүй өрх, сум, хороо болох хөдөлгөөнийг өрнүүлж, олон нийтийг татан оролцуулна.

4.6.2 Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, сүрьеэгийн алба/диспансер болон орон нутгийн засаг захиргааны нэгж байгууллагуудтай хамтран идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулна.

4.6.3 Илрүүлэлт явагдахаас 2-3 хоногийн өмнө эрсдэлт бүлгийн хүн амд илрүүлэлтийн тухай, хугацаа, байршил, холбоо барих утас зэрэг мэдээллийг хүргэнэ. Илрүүлэлтийн хамралтыг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт арга хэмжээ (утсаар холбогдон дуудах, гэрт нь очиж дуудах гэх мэт)-г авч хэрэгжүүлнэ. Илрүүлэлтийн хамралтыг 90%-ээс дээш гүйцэтгэнэ.

4.6.4 Сүрьеэгийн халдварын тархалтыг хянах, сэргийлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг идэвхтэй тандалтаар эрт илрүүлэн, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн төвд онош тодруулахаар илгээнэ.

4.6.5 Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын оношилгооны болон сүрьеэтэй өвчтөний эмчилгээний хяналтын цэрний сорьцыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу сүрьеэгийн диспансерт илгээж, хариуг авна.

4.6.6 Сүрьеэтэй өвчтөний эмийг шаардлага хангасан нөхцөлд стандартын дагуу хадгалан сүрьеэгийн болон урьдчилан сэргийлэх шууд хяналттай өдрийн болон цахим хяналттай гэрийн эмчилгээг гэрээ байгуулан хийнэ.

4.6.7 Эрүүл мэндийн ажилтан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд сүрьеэгийн эмчилгээ хийлгэх өвчтөний эмийг эмчилгээ хяналтын картын хуулбарын хамт хүлээн авч шууд хяналттай эмчилгээг тасралтгүй хийж, эмнэлзүйн үечилсэн дүгнэлт, хяналтын шинжилгээний хамралтыг хангаж ажиллана.

4.6.8 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний анхан шатны бүртгэл маягыг хөтөлж, сорьц тээвэрлэлт болон бусад тайланг харьяа сүрьеэгийн диспансерт илгээнэ.

4.6.9 Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, төв, сүрьеэгийн алба/диспансертэй хамтран сүрьеэтэй өвчтөний өрхийн болон ойрын хавьтлын судалгааг гаргаж үзлэг, шинжилгээнд хамруулна.

4.6.10 Сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийн гишүүд мэдээлэл авах, санал солилцох нээлттэй орчин бүрдүүлж, тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох замаар эерэг зан үйлийг төлөвшүүлнэ.

4.6.11 Эрсдэлт бүлгийн хүн ам, сүрьеэтэй өвчтөн, түүний гэр бүлийг төрөөс үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээ болон бусад тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хоол, хүнс, унааны мөнгө, түлээ нүүрс гэх мэт халамж дэмжлэгт хамруулна.

4.6.12 Хяналт алдагдсан тохиолдлын шалтгааныг тодруулж, дахин эмчилгээнд хамруулах, бүрэн төгс эмчлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.6.13 Сүрьеэгийн цахим тандалт, бүртгэл мэдээллийг байгууллагын түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

4.6.14 Сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцины урвал, хүндрэлийн байдалд холбогдох тушаал зааврын дагуу хяналт хийж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг зохих журмын дагуу мэдээлж, арга хэмжээ авна.

4.6.15 Сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийн гишүүдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

#### **4.7 Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд зориулсан “Энэрэл” эмнэлэг, түүнтэй адилтгах эрүүл мэндийн байгууллага**

4.7.1 Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, санал солилцох нээлттэй орчин бүрдүүлж тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох замаар эерэг зан үйлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.7.2 Орон гэргүй иргэдийн дунд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулах ажлыг манлайлж оролцоно.

4.7.3 Орон гэргүй, тэнэмэл, нэн ядуу, хаягийн бүртгэлгүй, бичиг баримтгүй, асран хамгаалагчаа алдсан иргэдийн дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг илрүүлэн, оношийг тодруулж сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.7.4 Сүрьеэтэй өвчтөнд эрсдэлийн үнэлгээ хийж, хяналт алдагдах магадлалтай өвчтөнийг эмчилгээний хугацаа бүрэн дуустал хэвтүүлэн эмчилнэ. Бусад тохиолдолд эрчимт шатанд хэвтүүлж, үргэлжлэх шатны эмчилгээг амбулатори болон төрийн бус байгууллага, сайн дурын ажилтны оролцоонд суурилан шууд хяналттай хийнэ.

4.7.5 Хяналт алдагдсан тохиолдлыг дахин эмчилгээнд хамруулах, бүрэн төгс эмчлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.7.6 Өвчтөний ойрын хавьтлуудын дунд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4.7.7 Сүрьеэгийн оношлогдсон тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг алдалгүй бүртгэж тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн хөгжлийн төвд холбогдох журмын дагуу мэдээлнэ.

4.7.8 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг байгууллагын түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

4.7.9 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс дэгдэлт байж болзошгүй нөхцөлийг тогтмол тандаж, сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

4.7.10 Ханган нийлүүлэгдсэн эм, урвалж бодис, оношлуур, хамгаалах хэрэгслийн нөөц, зарцуулалтын тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд мэдээлнэ.

4.7.11 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр очиж буй албан тоот, дэмжлэгт хяналтын зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тайлант хугацаанд нь эргэн мэдээлнэ

4.7.12 Сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

#### **4.8 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусгай эмнэлэг**

4.8.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон хорих ангийн эмнэлгийн нэгж/хэсэг нь сүрьеэгийн чиглэлээр нийтийн эрүүл мэндийн, эмнэлгийн анхан шатлалын болон мэргэшсэн тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлнэ.

4.8.2 Сүрьеэг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

4.8.3 Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, орон нутаг дахь цагдан хорих байр нь шинээр ирж буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч бүрд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг хийж, цаашид 6 сар тутам давтан үзлэгт хамруулна. 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг болон Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, цагдан хорих байр нь хоригдлыг хорих анги руу хуваарилахын өмнө сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулна.

4.8.4 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг болон 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь төвлөрсөн хорих анги, Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх газарт сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж идэвхтэй илрүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ.

4.8.5 Хорих ангийн эмнэлгийн нэгж/хэсэг нь сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын оношилгооны сорьцыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, Цагдан хорих 461 дүгээр ангийн Нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон орон нутгийн сүрьеэгийн алба/диспансерт илгээж, хариуг авна. Сорьц тээвэрлэх зардлыг төсөвт тусган ажиллана.

4.8.6 Хорих ангид оношлогдсон сүрьеэтэй хоригдол өвчтөнийг эрх бүхий байгууллагын хоригдол шилжүүлэх заавар журмыг баримтлан 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлж, шууд хяналттай эмчилгээ хийнэ.

4.8.7 Цагдан хорих ангид сүрьеэ өвчин оношлогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өвчтөнийг харьяа дүүргийн сүрьеэгийн диспансерт мэдээлэн Цагдан хорих 461 дүгээр ангийн Нэгдсэн эмнэлэгт шилжүүлж, шууд хяналттай эмчилгээ хийнэ.

4.8.8 Сүрьеэгийн оношлогдсон тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг алдалгүй бүртгэж тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн хөгжлийн төвд холбогдох журмын дагуу мэдээлнэ.

4.8.9 Орон нутгийн цагдан хорих байранд хоригдож буй сүрьеэтэй өвчтэй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрчимт шатны эмчилгээг орон нутгийн сүрьеэгийн тасагт хэвтүүлж халдваргүй болтол хийх ба үргэлжлэх шатны халдваргүй хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээг тухайн цагдан хорих, баривчлах байрны эмчийн шууд хяналтад хийнэ.

4.8.10 Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдол нь сүрьеэгийн эмчилгээний явцад суллагдсан тохиолдолд өвчтөн шилжүүлэх маягтын дагуу харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн алба/диспансерт шилжүүлэн, эмчилгээ үргэлжилж буй эсэх талаар мэдээлэл солилцоно.

4.8.11 Сүрьеэтэй өвчтөн эмчилгээний явцад шүүхээр хорих ялаар шийтгэгдсэн, цагдан хоригдсон тохиолдолд тухайн аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер нь өвчтөн шилжүүлэх

маягтаар Цагдан хорих 461 дүгээр ангийн Нэгдсэн эмнэлэг, цагдан хорих байр болон 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт, баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн халдваргүй тохиолдолд баривчлах байранд эмчилгээг үргэлжлүүлнэ.

4.8.12 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт эмчлэгдэж байхдаа сүрьеэ өвчин оношлогдсон тохиолдолд эмнэлзүйн зааварт заасан шалгуурын дагуу эрх бүхий байгууллагын хоригдол шилжүүлэх заавар журмыг баримтлан 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлэн сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.8.13 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт эмчлэгдэж байхдаа оношлогдсон өвчтөний биеийн байдал хүнд, тээвэрлэх боломжгүй, хавсарсан хүнд өвчтэй тохиолдолд халдвар ялгаруулж байгаа эсэхээс үл хамааран биеийн байдал тогтворжтол тухайн эмнэлэгт сүрьеэгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Биеийн байдал тогтворжсоны дараа тусламж үйлчилгээний чиглэлийн дагуу ХӨСҮТ болон 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчилгээг үргэлжлүүлэн хийнэ.

4.8.14 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчлэгдэж буй өвчтөн нь хавсарсан эмгэгийн улмаас биеийн байдал дунд, сүрьеэ өвчний бус мээ засал бусад төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ шаардлагатай тохиолдолд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт шилжүүлж эмчилнэ.

4.8.15 Сүрьеэгийн төрөлжсөн мэргэшлийн мээ засал хийх шаардлагатай, бусад халдварт өвчинтэй хавсарсан хоригдол, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өвчтөний биеийн байдал хүнд тохиолдолд эмнэлзүйн зааварт заасан шалгуурын дагуу эрх бүхий байгууллагын хоригдол, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг шилжүүлэх заавар журмыг баримтлан ХӨСҮТ-д шилжүүлэн эмчилнэ.

4.8.16 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт эмчлэгдсэн эмэнд мэдрэг сүрьеэгийн эмчилгээний дараах хяналтыг эдгэрсэн болон эмчилгээ дуусгаснаас хойш 2-4 сар, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ амжилттай дуусгасны дараах хяналтыг эмчилгээ дууссанаас хойш 4-6 сарын хугацаанд тухайн ангид хийж цаашид биеийн байдал, рентген, бусад шинжилгээг үндэслэн журмын дагуу хуваарилагдсан хорих ангид шилжүүлнэ.

4.8.17 Сүрьеэтэй тохиолдол илэрсэн хорих ангид сүрьеэгийн хавьтлын өргөжүүлсэн үзлэг, шинжилгээ хийж халдвар авсан тохиолдлыг тухайн ангийн эмнэлгийн нэгж/хэсгийн хяналтад сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд оруулж, орон нутгийн сүрьеэгийн алба/диспансер хяналт тавьж эмчилгээний горим, явцын хяналт, эмийн орлого, зарлага, эмчилгээний үр дүнгийн мэдээллийг цаг тухайд нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэж үр дүнг тооцно.

4.8.18 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг, Цагдан хорих 461 дүгээр ангийн нэгдсэн эмнэлэг, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

4.8.19 Сүрьеэгийн мэдээ, тайлан болон хугацаанаас өмнө суллагдсан сүрьеэтэй өвчтөний мэдээллийг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд хугацаанд нь мэдээлж, шилжиж очсон газарт эмчилгээг үргэлжлүүлэн үр дүнг эргэж тооцно.

4.8.20 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс дэгдэлт байж болзошгүй нөхцөлийг тогтмол тандаж, сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

4.8.21 Ханган нийлүүлэгдсэн эм, урвалж бодис, оношлуур, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, зарцуулалтын тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанд мэдээлнэ.

4.8.22 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр очиж буй албан тоот, дэмжлэгт хяналтын зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тайлант хугацаанд нь эргэн мэдээлнэ.

4.8.23 Сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

#### **4.9 Амаржих газар, эмнэлгийн төрөх тасаг**

4.9.1 Нярайг төрсний дараа 24 цагийн дотор сүрьеэгийн эсрэг БЦЖ вакциныг тусгай бэлтгэгдсэн сувилагч хийж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.

4.9.2 Сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцинд хамруулах дүгнэлтийг нярайн эмч гаргана.

4.9.3 Сүрьеэгийн эсрэг БЦЖ вакцин хийгдээгүй тохиолдолд шалтгааныг эрүүл мэндийн дэвтэрт тодорхой тэмдэглэнэ.

4.9.4 Үйлчлүүлэгчдийн дунд уушгины сүрьеэтэй өвчтөн оношлогдсон тохиолдолд халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ (тусгаарлах, амны хаалт хэрэглэх, агааржуулалт, хэт ягаан туяаны гэрэл гэх мэт)-г авч хэрэгжүүлнэ.

4.9.5 Цэрний түрхцийн шинжилгээ сөрөг болон үргэлжлэх шатны эмчилгээтэй зэрэг халдвар ялгаруулахгүй хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнийг харьяа амаржих газар, эмнэлгийн төрөх тасагт төрүүлнэ.

4.9.6 Сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлж, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллана.

4.9.7 Амаржих газрын тархвар судлаач нь вакцины төлөвлөлт, захиалга, хадгалалт, зарцуулалт, хийх арга техник, аюулгүй дархлаажуулалтын заавар журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

4.9.8 Халдваргүй хэлбэрийн сүрьеэ, уушгины бус сүрьеэтэй өвчтөнд сүрьеэгийн мэргэшсэн эмчээс зөвлөгөө авч эмчилгээг яаралтай эхлэх, үргэлжлүүлэх, гаж нөлөөг хянах зэрэг сүрьеэгийн тусламж үйлчилгээг тасалдуулахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### **4.10 Төр, хувийн хэвшлийн бусад эрүүл мэндийн байгууллага**

4.10.1 Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, санал солилцох нээлттэй орчин бүрдүүлж тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох замаар эерэг зан үйлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.10.2 Сүрьеэгийн халдварын тархалтыг хянах, сэргийлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг идэвхтэй тандалтаар эрт илрүүлж, холбогдох үзлэг шинжилгээг хийнэ.

4.10.3 Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын оношилгооны цэрний сорьцыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу өөрийн болон харьяа орон нутгийн сүрьеэгийн лаборатори, Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторид илгээж хариуг авна.

4.10.4 Сүрьеэгийн онош эргэлзээтэй тохиолдолд мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч ялган оношилгоо хийнэ.

4.10.5 Үйлчлүүлэгчдийн дунд уушгины сүрьеэтэй өвчтөн оношлогдсон тохиолдолд тусгаарлах, амны хаалт хэрэглэх, агааржуулалтыг сайжруулах зэрэг халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.10.6 Халдварын сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхахаас сэргийлж, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллана.

4.10.7 Сүрьеэгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлэг нь сүрьеэгийн оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар, журам, эрх бүхий байгууллагаас гарсан стандарт үйлдлийн батлагдсан аргачлалын дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.10.8 Сүрьеэтэй тохиолдлыг анх илрүүлж оношилсон бүх шатны төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч нь онош батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох журмын дагуу цахимаар мэдээлнэ.

4.10.9 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг байгууллагын түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллана.

4.10.10 ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас ирүүлсэн тандалтын тайлан, эргэн мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авч эргэн мэдээлнэ.

#### **4.11 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв**

4.11.1 Сүрьеэг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

4.11.2 Сүрьеэгийн халдварын тархалтыг хянах, сэргийлэх зорилгоор үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг идэвхтэй тандалтаар эрт илрүүлж, холбогдох үзлэг шинжилгээг хийнэ.

4.11.3 Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын цэрний сорьцыг өөрийн болон Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторид илгээж хариуг үндэслэн оношийг тодруулна.

4.11.4 Удаан хугацаагаар эмчлэгдэх шинээр ирж буй өвчтөнд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг хийж, цаашид 6 сар тутам давтан үзлэгт хамруулна.

4.11.5 Сүрьеэгийн оношлогдсон тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д цаг алдалгүй бүртгэж тайланг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Эрүүл мэндийн хөгжлийн төвд холбогдох журмын дагуу мэдээлнэ.

4.11.6 Сэтгэцийн өөрчлөлттэй сүрьеэтэй өвчтөнийг тусгаарлан шууд хяналттай эмчилнэ.

4.11.7 Тусгаарлан хэвтүүлэх, эмчлэх үеийн халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлж, эмнэлгээс шалтгаалсан халдвар гарахаас сэргийлж ажиллана.

4.11.8 Тандалтын тогтолцоонд цугларч буй мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ХӨСҮТ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эргэн мэдээлэл, тайлан, дүн шинжилгээ, шийдвэр гаргагч, байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулж хариу арга хэмжээ авч ажиллана.

4.11.9 Сүрьеэтэй өвчтөнд эмнэлзүйн үечилсэн дүгнэлт гаргаж холбогдох шинжилгээнд цаг хугацаанд нь хамруулна.

4.11.10 Өвчтөний ойрын хавьтлуудын дунд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4.11.11 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс дэгдэлт байж болзошгүй нөхцөлийг тогтмол тандаж, сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээг авах багийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажилтаны дунд сүрьеэгийн дэгдэлт гарахаас сэргийлэх, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг чанд мөрдөж ажиллана.

4.11.12 Сүрьеэгийн чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрны халдварын сэргийлэлт хяналт, аюулгүй ажиллагааг хангаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сүрьеэгээр өвчлөхөөс урьдчилан сэргийлж ажиллана.

4.11.13 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чиглэлээр очиж буй албан тоот, дэмжлэгт хяналтын зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тайлант хугацаанд нь эргэн мэдээлнэ.

4.11.14 Сүрьеэтэй өвчтөн, тэдний гэр бүлийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэн ажиллана.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллагын сурьезгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны чиглэл

№	Үйл ажиллагаа	ХӨСҮТ	НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМТ	Аймаг, дүүргийн БОСТ, НЭ, ЭМТ	Сурьезгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээний тасаг, алба /диспансер/	Амаржих газар	Өрх, сүм, тосгоны ЭМТ	Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	ШУТЕГ-ын харьяа тусгай эмнэлэг	СЭМҮТ, Энэрэл эмнэлэг	ТББ* (Хамтын гэрээгээр гүйцэтгэх)
1	Урьдчилан сэргийлэлт, дархлаажуулалт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
2	Мэдээлэл сургалт сурталчилгаа	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
3	Илрүүлэлт	+		+	+	+	+	+	+	+	+	+
4	Сорьц тээвэрлэлт	+		+	+	+	+	+	+	+	+	+
5	Сурьезгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)	+		+	+	+	+	+	+	+	+	+
6	Оношилгоо	+			+	+	+	+	+	+	+	
7	Шууд хяналттай эмчилгээ	+			+	+	+	+	+	+	+	+
8	Эмчилгээний хяналт			+	+	+		+	+	+	+	+
9	Халдварын хяналт, сэргийлэлт	+		+	+	+	+	+	+	+	+	+
10	Хавьтлын үзлэг, хяналт			+	+	+		+	+	+	+	+
11	Эрсдэлт бүлэгт чиглэсэн идэвхтэй илрүүлэлт	+		+	+	+		+	+	+	+	+
12	Ханган нийлүүлэлт	+		+	+	+		+	+	+	+	
13	Сургалт, семинар	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
14	Эрдэм шинжилгээ судалгаа	+	+									+
15	Бүртгэл, тайлан мэдээ	+		+	+	+	+	+	+	+	+	+
16	Лабораторийн гадаад, дотоод хяналт	+			+	+	+	+	+	+	+	
17	Эмчилгээний чанарын хяналт	+		+	+	+		+	+	+	+	+
18	Дэгдэлтийн хариу арга хэмжээ	+		+	+	+		+	+	+	+	+

Тайлбар: \*ЭМЯ нь тухайн үйл ажиллагааг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр бол хамтын гэрээ байгуулж ажиллана.



## 5. Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд иргэд, хамт олон, олон нийтийн чиг үүрэг, хамтын ажиллагаа

Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, илрүүлэх, хянах, үр дүнтэй оношилж эмчлэхэд эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн, түүний гэр бүл, хамт олон, сайн дурын ажилтан, бусад эрүүл мэндийн ажилтан, нийгмийн хамгаалал болон хууль сахиулах байгууллагын олон талт хамтын ажиллагаанаас шууд хамаарна. Иймд энэхүү тусламж, үйлчилгээнд оролцогч талууд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### 5.1 Үйлчлүүлэгчийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах үйл ажиллагаа

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний үйлчлүүлэгч гэдэгт урьдчилан сэргийлэх, зрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамрагдаж байгаа иргэн, сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол, өвчний учир сүрьеэгийн амбулаториор үйлчлүүлж буй иргэн, сүрьеэгийн хавьтал иргэн, сүрьеэтэй өвчтөнийг хамааруулан ойлгоно.

5.1.1 Үйлчлүүлэгчид "Эрүүл мэндийн тухай" хуульд заасан иргэний эрх, үүрэг, түүний хариуцлагатай холбоотой заалтыг заавал танилцуулсан байна. Үүнд:

43.1.4.халдварт өвчнөөс бусад тохиолдолд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийлгэхээс татгалзах;

43.2.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох;

43.2.3.халдварт өвчин тархахаас сэргийлж, хөл хорионы дэглэмийг сахиж мөрдөх;

43.2.6.халдварт өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох;

46.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.1.2 Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ сүрьеэгийн талаар холбогдох мэдээллийг үйлчлүүлэгчдэд заавал тайлбарлаж, танилцуулсан байна. Үүнд:

1. Сүрьеэ гэж ямар өвчин болох, хэрхэн тархдаг, эдгэрдэг тухай;
2. Сүрьеэгийн эмчилгээний горим, үргэлжлэх хугацаа, эмийг шууд хяналттай уухын ач холбогдлын талаар тайлбарлах;
3. Бусдад халдвар тараахаас сэргийлэх зорилгоор ханиах, найтаах үед ам хамраа таглах, амны хаалт зүүх, эмчилгээг бүрэн дуусгах;
4. Яагаад олон эмийг нэг зэрэг уух хэрэгтэй ба эм бүрийг уух нь эмчилгээний үр дүнд маш чухал болохыг;
5. Биеийн байдал сайжирсан ч заасан хугацаанд эмчилгээг төгс үр дүнд хүрэхийн тулд эмээ үргэлжлүүлэн ууж дуусгах ёстойг;
6. Эмийн тэсвэржилт гэж юу болох, ямар хор уршигтай болохыг;
7. Эм уухад гарч болох гэж нөлөө, түүний шинж тэмдэг, зовуурь илэрвэл эмчид яаралтай мэдэгдэхийг тайлбарлаж өгөх;
8. Гэр бүлийн гишүүдээ ямар хугацаанд, хаана үзлэг шинжилгээнд хэрхэн хамруулах талаар;
9. Эмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж, түүнтэй холбоотой ямар тушаал журам байдаг талаар;
10. Эмчилгээний хугацаанд нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар;

5.1.3. Үйлчлүүлэгчдэд дээрх аман мэдээллийг тасралтгүй үе шаттайгаар өгөхөөс гадна мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх хэвлэмэл материал өгөх;

5.1.4. Үйлчлүүлэгчийг хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжид хамруулахад дэмжлэг үзүүлэх;

## 5.2 Үйлчлүүлэгчийн чиг үүрэг

Үйлчлүүлэгч сүрьеэг ирүүлэх, халдвараас сэргийлэх, хянах, сүрьеэгийн эмчилгээг бүрэн төгс хийлгэх үйл ажиллагаанд оролцохдоо дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.2.1 Сүрьеэ өвчин тархахаас сэргийлж, шаардлагатай тохиолдолд идэвхтэй илрүүлэлтийн үзлэг шинжилгээнд орж, шаардлага гарсан тохиолдолд хөл хорио, тусгаарлалтын дэглэмийг сахиж мөрдөх,

5.2.2 Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх эрүүл мэндийн даатгалын багц үзлэг шинжилгээ, аж ахуйн нэгж байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар тогтоосон журмын дагуу оролцох,

5.2.3 Сүрьеэтэй байж болзошгүй болон хавьтал болсон тохиолдолд өөрөө болон гэр бүлийнхнээс нь урьд өмнө сүрьеэгээр өвчилсөн, нас барсан, эмчилгээ хийлгэсэн эсэх талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх;

5.2.4 Сүрьеэтэй өвчтөн нь өөрийн ойрын хавьтал байж болох өрхийн гишүүд, найз нөхөд, хамт оныхоо талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

5.2.5 Сүрьеэтэй өвчтөн өөрийн ажлын газар, сургууль, амьдрах орчны талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх;

5.2.6 Эмчийн өгсөн зөвлөмжийн дагуу сүрьеэгийн эмчилгээг шууд хяналттай хийлгэх;

5.2.7 Өвчтөн эмчилгээний явцад эмийн гаж нөлөө, хүндрэл ажиглагдсан бол нэн даруй эмчлэгч эмчид үнэн зөв мэдэгдэх;

5.2.8 Өвчтөн эмчилгээний явцад ямар нэг шалтгааны улмаас сүрьеэгийн эмийг бүрэн хэрэглээгүй, тасалсан бол эмчлэгч эмчид даруй мэдэгдэх;

5.2.9 Өвчтөн эмчилгээний явц, үр дүнг хянах зорилготой хяналтын шинжилгээг тогтоосон хугацаанд тогтмол өгөх;

5.2.10 Өвчтөний ойрын хавьтал гэж тогтоосон хүмүүсийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах;

5.2.11 Үйлчилгээ авахдаа эрүүл мэндийн ажилтан, сайн дурын ажилтантай хүндэтгэлтэй харилцаж, соёлтой үйлчлүүлэх;

5.2.12 Сүрьеэгийн эмчилгээний зааврыг чандлан мөрдөж, эмчилгээг бүрэн дуусгах;

5.2.13 Тохирсон газар, цагт очиж сүрьеэгийн эмчилгээнд тасралтгүй хамрагдах;

5.2.14 Сүрьеэгийн эмчилгээний талаар буруу ташаа мэдээлэл тараахгүй байх;

5.2.15 Халдвар ялгаруулж буй хугацааны туршид амны хаалт зүүх, цэр нусаа ил задгай хаяхгүй, бусдын өөдөөс харж ханиаж найтаахгүй байх;

5.2.16 Бусад үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, эмчилгээгээ бүрэн дуусгахад нь бусдад үлгэр дуурайл болох;

5.2.17 Үйлчлүүлэгч нь зөвхөн өөрийн төлөө бус гэр бүл, нийтийн эрх ашгийн төлөө хариуцлага хүлээж буйг ойлгох, түүнд ойр байгаа хүмүүст халдвар тараахгүй байх;

## 5.3 Үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүдийн оролцоо

Сүрьеэгийн хавьтал болсон, сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол, эсхүл эмчлүүлж байгаа өвчтөний өрхийн гишүүд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.3.1 Үйлчлүүлэгчийн өрхийн бүх гишүүд эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдах;

5.3.2 Гэр бүлийн гишүүдийн хяналттай эмчилгээг явуулах гэрээний биелэлт, эмчилгээний тасралтгүй байдлыг хангах;

5.3.3 Сүрьеэ өвчин нь удаан хугацаанд эмчилгээ хийлгэж, бүрэн эдгэрдэг гэдгийг гэр бүлийн бүх гишүүд ойлгож, өвчтөнийг дэмжих;

5.3.4 Сүрьеэгийн шинж тэмдэг илэрсэн үед эмчид хандаж, үзлэг шинжилгээнд хамрагдах үүрэгтэй;

5.3.5 Өвчин дамжин тархах зам, өвчний тавилан, эмийн тун бүрийг хэрэглэхийн ач

холбогдол, эмэнд тэсвэртэй сүрьеэ үүсэх шалтгаан зэргийн тухай мэдээлэл, ойлголттой болсон байх;

5.3.6 Гэр бүл салалт, ялгаварлан гадуурхалт нь өвчтөний эмчилгээний үр дүнд сөрөг нөлөөлнө гэдгийг мэдэж байх;

5.3.7 Эмчилгээний үр дүнд гэр бүлийн дэмжлэг, туслалцаа нэн чухал болохыг ойлголцсон байх;

#### **5.4 Олон нийт, хамт олны оролцоо, дэмжлэг**

Сүрьеэгийн чиглэлээр мэдээлэл сурталчилгаа, хавьтал илрүүлэх, хянах, тусгаарлах үйл ажиллагаанд оролцож байгаа төр, хувийн хэвшлийн байгууллага, сүрьеэ байж болзошгүй тохиолдол, эсхүл өвчтөний хамт олон, ажил олгогч нар дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.4.1 Сүрьеэтэй холбоотой олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгаа, баннер, постер, видео зэргийн агуулга, дүрслэлийг ялгаварлан гадуурхалт үүсэхээс сэргийлсэн байдлаар хийх;

5.4.2 Тархвар судлалын заалтаар сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах;

5.4.3 Халдварын сэргийлэлт, хяналтын бүх арга хэмжээнд оролцохдоо үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн нууцыг хамгаалах, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэхээр зохион байгуулах;

5.4.4 Олон нийтийг сүрьеэгийн халдварын аюул, эрсдэлээс хамгаалах зорилгоор хийгдэх мэдээлэл, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, дэгдэлтийн үед голомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь хувь хүн (үйлчлүүлэгч, түүний гэр бүл), албан байгууллага (сургууль, цэргийн анги, хорих анги, асрамжийн газар гэх мэт) -ын нэр, хаяг, байршлыг нууцалсан байх;

5.4.5 Сүрьеэгийн халдвартай болох нь тогтоогдсон, сүрьеэгээр өвчилж эмчлүүлж байгаа болон эдгэрсэн хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байж, ажлын байрыг хадгалах, өрхийн орлогоо хамгаалахад нь санхүүгийн болон сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх;

#### **5.5 Үйлчлүүлэгчтэй харилцах үйл ажиллагаа**

Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хүлээн авах, оношилж, эмчлэх, эмнэлгээс гаргахад мэдээлэл, зөвлөгөө өгөх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

5.5.1 Ханиалгаж байгаа үйлчлүүлэгчдийг амны хаалт зүүхийг шаардах, сүрьеэгийн сэжигтэй гэж үзсэн бол тусгай өрөөнд хүлээлгэж, дугаар харгалзахгүй үйлчлэх;

5.5.2 Цэрний шинжилгээг өгөх зааварчилгааг энгийн ойлгомжтой тайлбарлаж, шинжилгээний хариуг цахимаар болон цаг товлох үйлчилгээ, байршлын талаар мэдээлэл өгөх;

5.5.3 Өвчтөний гэр бүлийн гишүүдэд ямар мэдээллийг хэзээ хэрхэн өгөх талаар өөртэй нь урьдчилж зөвшилцөх;

5.5.4 Эрүүл мэндийн тухай хуульд заасан иргэний эрхийн дагуу нууцыг чандлан хадгалах, зөвхөн түүний зөвшөөрлөөр гэр бүл, хамаатан садан болон шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгөх боломжтой болохыг урьдчилан тайлбарлах;

5.5.5 Үйлчлүүлэгчийг гэр бүл, нийгэмд ялгаварлан гадуурхагдахаас сэргийлэх арга хэмжээ авах;

5.5.6 Сүрьеэ, ХДХВ, ДОХ болон бусад халдварт, халдварт бус өвчинтэй хавсарсан өвчтөний оношилгоо, эмчилгээний асуудлыг тухайн чиглэлийн эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран зөвлөлдөх замаар оношилгоо, шинжилгээ, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх;

5.5.7 Сэтгэцийн өөрчлөлттэй, архи, мансууруулах бодисын донтох эмгэгийн улмаас эмчилгээг бүрэн төгс хийлгэх боломжгүй, эмчилгээ таслах эрсдэлтэй хүмүүсийг сэтгэцийн эмчтэй хамтран сүрьеэгийн болон сэтгэцийн эмчилгээг хослуулан хийх;

5.5.8 Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдолд сүрьеэгийн үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ хийх явцад үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн нууцыг чанд хадгалах;

5.5.9 Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай үйлчлүүлэгчийн хүнсний бүтээгдэхүүн, эмнэлэгт ирэх унааны зардал олгох зэрэг нийгмийн халамж үйлчилгээнд хамруулахад холбогдох эрүүл мэндийн нууцыг чанд хадгалах;

## **5.6 Сүрьеэгийн эмчилгээг тасалсан үед авах арга хэмжээ**

Сүрьеэгийн эмчилгээ нь хэдэн сараар тасралтгүй үргэлжилж байж үр дүн гардаг, эмчилгээ тасалснаас болж эмэнд тэсвэртэй сүрьеэ үүсэх, эмчилгээ үр дүнгүй болох, нас барах эрсдэлтэй байдаг тул эмчилгээг таслуулахгүй байх зорилгоор шууд хяналтыг тавьдаг. Хэрэв ямар нэг шалтгаанаар эмчилгээг тасалсан бол дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.6.1 Сүрьеэтэй өвчтөн эмчилгээнээс татгалзах үед хэрхэн холбоо тогтоох арга замыг сонгох, эрсдэл гаргах үеийн арга хэмжээг урьдчилан төлөвлөх; (утсаар холбоо барих, цахим шуудан, цахим зурвас илгээх, хэрэв 2 долоо хоногоос дээш хугацаа эсвэл давтан эмчилгээ тасалсан үед гэрт нь болон байгаа газарт нь эмнэлгийн ажилтан очих болно гэдгийг урьдчилан сануулах)

5.6.2 Эмчилгээ тасалсан болон эмчилгээний дэглэмийг бүрэн дагаж мөрдөхгүй байгаа өвчтөнтэй холбоо тогтооход тэдний хувийн амьдралд аль болох бага оролцохыг эрмэлзэх;

5.6.3 Өвчтөний гэр, ажлын газар эсвэл байгаа газарт нь сүрьеэгийн байгууллагын таних тэмдэггүй унаа машин болон энгийн хувцастай хүрэлцэн очих;

5.6.4 Өвчтөний эмчилгээ тасалсан шалтгааныг олж мэдэх, нөхцөл байдлын талаар ярилцаж, эмчилгээгээ таслалгүй үргэлжлүүлэхийг ятгах;

5.6.5 Өвчтөнтэй уулзах үедээ эмийн өдрийн тунг авч очоод харж уулгах;

5.6.6 Өвчтөнийг эмчилгээнд ирэхэд нь саад болж байгаа өөр хавсарсан өвчин, гэр бүлийн байдал, ажлын нөхцөл гэх мэт шалтгаан байгаа эсэхийг тодруулж, шийдвэрлэхэд нь туслах;

5.6.7 Өвчтөний гэр бүлийн гишүүдтэй ярилцаж, эмчилгээгээ үргэлжлүүлэхэд тусалж, дэмжих шаардлагатай талаар болон эмчилгээг бүрэн дуусгахын ач холбогдлыг дахин тайлбарлах;

5.6.8 Өвчтөнийг олж чадаагүй бол аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар цагдаагийн албанд мэдэгдэх;

5.6.9 Өвчтөн халдвар ялгаруулж байгаа үедээ эмчилгээ тасалж, олдохгүй байгаа бол Эрүүл мэндийн тухай хууль, Зөрчлийн хуульд заасны дагуу халдварт өвчнийг олон нийтэд тараах зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяалах сум, хорооны цагдаагийн албанд мэдэгдэх;

5.6.10 Хорих ангиас суллагдаж эмчилгээ тасалсан өвчтөнийг эрж олоход сум, хорооны цагдаагийн байгууллага, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд мэдэгдэж хамтран ажиллах;

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
01 сарын 29-нд өдрийн зоотоот  
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

## Сүрьеэгийн халдварын сэргийлэлт, хяналтын журам

### 1. Нийтлэг үндэслэл

Сүрьеэгийн чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулж буй бүх байгууллагууд энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Халдварын сэргийлэлт, хяналт (цаашид ХСХ гэх) нь эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны хэм хэмжээ юм.

### 2. Нэр томъёоны тодорхойлолт

Сүрьеэгийн халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээ нь удирдлагын хяналт, орчны хяналтын болон амьсгалын эрхтний хувь хүний хамгаалалт гэсэн гурван шатлалтай байна.

**2.1 Удирдлага хяналтын арга хэмжээ:** Сүрьеэгийн халдварт өртөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн менежментийн арга хэмжээг хэлнэ. Удирдлагын хяналтын арга хэмжээнд эрэмбэлэн ангилалт, урсгалыг зохицуулах аргууд хамаарна. Эмнэлгээр үйлчлүүлэгчдийн дунд сүрьеэ болон амьсгалын замын халдварын шинж тэмдгийн тандалт, илрүүлэлт хийх, халдварын шинж тэмдэгтэй хүнд амны хаалт зүүлгэх, эрэмбэлэн ангилах (триаж), зохион байгуулсан үзлэгийн хэсэгт хүргэх, чиглүүлэх, шаардлагатай тохиолдолд тусгаарлана.

**2.2 Эрэмбэлэн ангилах (Триаж):** Эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээ авахаар ирсэн үйлчлүүлэгчдээс сүрьеэгийн шинж тэмдгийг шуурхай илрүүлэх, оношлох, цаашид халдвар дамжих нөхцөлийг бууруулах арга хэмжээ;

**2.3 Тусгаарлалт:** Сүрьеэтэй өвчтөнөөс тусламж үйлчилгээ авах гэж буй бусад эрүүл үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилчдад сүрьеэгийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах арга хэмжээ;

**2.4 Орчны хяналтын арга хэмжээ:** Сүрьеэгийн халдвар агаараар дамжин тархахаас сэргийлэхэд орчны хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлнэ. Халдвартай хэлбэрийн сүрьеэгийн батлагдсан болон болзошгүй тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх хэсэг, сүрьеэгийн лаборатори, тусгаарлах, цэр цуглуулах, бронхоскопийн өрөө, хүлээлгийн танхим зэрэг сүрьеэгийн халдвар тархах өндөр эрсдэлтэй газарт орчны хяналтын аргуудыг өргөн хэрэглэнэ. Албан байгууллага, олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар, орон сууц зэрэг хүн амын хөл хөдөлгөөн, бөөгнөрөл ихтэй барилга байшингийн өрөө тасалгаанд гаднаас цэвэр агаарыг оруулж, бохир агаарыг гаргах агааржуулалтын системийг төлөвлөж, хэрэгжүүлдэг байх ёстой.

**2.5 Байгалийн агааржуулалт:** Гаднах болон доторх агаарын даралтын зөрүү, салхины хүчийг ашиглан барилгын өрөө тасалгааг агааржуулах;

**2.6 Механик агааржуулалт:** Агааржуулах тоног төхөөрөмж, соруулах сэнс ашиглан барилгын өрөө тасалгааг агааржуулах;

**2.7 Холимог агааржуулалт:** Байгалийн болон механик агааржуулалтыг хамтад нь ашиглан барилгын өрөө тасалгааг агааржуулах;

**2.8 Сөрөг даралт:** Механик агааржуулалтын системийн тусламжтай соруулж буй агаарын урсгал нь оруулж буй агаарын урсгалаас их байх, өрөөний агаарын даралт бага байх;

**2.9 Эерэг даралт:** Механик агааржуулалтын системийн тусламжтай оруулж буй агаарын урсгал нь соруулж буй агаарын урсгалаас их байх, өрөөний агаарын даралт их байх;

**2.10 НЕРА шүүлтүүр:** 0.3 мкм хэмжээтэй хэсгүүдийг шүүх хүчин чадал 99.97%-аас багагүй агаарын шүүлтүүр;

**2.11 Хэт ягаан туяа:** Үзэгдэх гэрлээс богино, рентген туяанаас урт долгионы урттай цахилгаан соронзон цацраг юм. Долгионы урт нь 100-400 нм байх ба UVC буюу 254 нм долгионы урттай хэт ягаан туяа нь бичил биетнийг идэвхгүй болгох, устгах үйлчилгээтэй;

**2.12 Амьсгалын эрхтний хувь хүний хамгаалалтын арга хэмжээ:** Сүрьеэгийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй нөхцөлд амьсгалын замын хамгаалалтын хэрэгслийг ашиглах арга хэмжээ;

**2.13 N95 шүүлтүүртэй амны хаалт:** 0.3 мкм хэмжээтэй дусал (тосонд тэсвэргүй)-ыг 95% ба түүнээс дээш хувиар шүүх амны хаалт;

**2.14 FFP2 шүүлтүүртэй амны хаалт:** 0.4 мкм хэмжээтэй дусал (тос болон тосон биш)-ыг 94% ба түүнээс дээш хувиар шүүх амны хаалт;

### **3. Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хяналтын үйл ажиллагаа**

#### **3.1 Нийтлэг арга хэмжээ:**

3.1.1 ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллуулна.

3.1.2 Эрүүл мэндийн байгууллагын түвшинд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог ханган ажиллана.

3.1.3 Халдварын сэргийлэлт хяналтын алба, баг нь эрүүл мэндийн ажилтанд илрүүлэг, тандалт хийх, ЭТҮХХ-ын тандалт судалгаа хийж, халдварыг эрт илрүүлэн мэдээлж, хариу арга хэмжээ авна.

3.1.4 Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авна.

#### **3.2 Удирдлага хяналтын арга хэмжээ**

3.2.1 Эрүүл мэндийн байгууллагууд халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хяналтын арга хэмжээг заавал тусгасан байна.

3.2.2 Сүрьеэгийн халдварын сэргийлэлт, хяналтад шаардлагатай тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслийн тооцоог гаргаж, жил бүр байгууллагын төсөвт тусган санхүүжүүлнэ.

3.2.3 Эрүүл мэндийн ажилтны ажлын байрны халдварын эрсдэл, тусламж үйлчилгээтэй холбоотой сүрьеэгийн халдвар тархах эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр халдварын сэргийлэлт, хяналтын алба/багийн хурлаар хэлэлцүүлж, асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.4 Эрүүл мэндийн ажилтан сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд халдварын сэргийлэлт, хяналтын алба/багийн хурлаар хэлэлцэх, мэргэжлээс шалтгаалсан эсэхийг тодорхойлох, ажлын байрны аюулгүй байдал, орчин нөхцөлийг сайжруулна.

3.2.5 Эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн дунд шинж тэмдэг (14 хоногоос дээш хугацаагаар ханиалгаж байгаа эсэх)-ийн тандалтыг хийж, сүрьеэгийн болзошгүй тохиолдлыг тусгаарлаж, илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулж, оношлогдсон тохиолдлыг мэдээлж, эмчилгээнд хамруулна.

3.2.6 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний тасаг нэгжид шинэ ажилтан, дадлагажигчийг ажлын байранд гарахын өмнө халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамруулж, мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар баримжаа олгох сургалтад хамруулсан байна.

3.2.7 Лабораторийн шинэ ажилтныг биоаюулгүй ажиллагааны журмын дагуу тусгайлсан биоаюулгүй ажиллагаа, биохамгаалалтын сургалтад хамруулж, үнэлгээ хийсэн байна.

- 3.2.8 Эрүүл мэндийн ажилтнуудад сүрьеэгийн тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналтын сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.
- 3.2.9 Эрүүл мэндийн ажилтныг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа хамруулна.
- 3.2.10 Сүрьеэгийн тасаг, алба/диспансерын хэсгийг эмнэлгийн тусламж үйлчилгээний бусад хэсгүүдээс тусдаа нэвтрэх хаалгатай, хүлээлгийн хэсэгтэй байхаар зохион байгуулна.
- 3.2.11 Сүрьеэгийн амбулаторийн хэсэг нь эмчийн үзлэг хийх, туберкулины сорил тавих, өдрийн эмчилгээ хийх, эм уулгах, эм хадгалах зэрэг 4-5 өрөөтэй байна.
- 3.2.12 Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж байгаа эрүүл мэндийн үзлэг, жирэмсний хяналт, эрт илрүүлэг зэрэг үзлэг шинжилгээг сүрьеэгийн амбулаторийн үзлэгээс тусад нь зохион байгуулна.
- 3.2.13 Түрхэц/Жене эерэг халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнүүдийг, түрхэц сөрөг өвчтөнүүдтэй хавьтал болохоос сэргийлж, сүрьеэгийн амбулаториор үйлчлүүлэх цагийн хуваарьт зохицуулалт хийж тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 3.2.14 Эрүүл мэндийн ажилтан нь сүрьеэтэй өвчтөн халдвар ялгаруулж буй хугацаанд эмчилгээний туршид амны хаалт тогтмол зүүхийг зөвлөх, зөв ханиаж, найтаах дадлыг сургах, хэрэглээнд хяналт тавин ажиллана.
- 3.2.15 Сүрьеэтэй оношлогдсон тохиолдол бүрийн эмчилгээг эрт эхлүүлж, хавьтлуудыг бүртгэж хяналтад авна.
- 3.2.16 Ханиалгаж байгаа үйлчлүүлэгчид амны хаалт зүүлгэж, эмчийн үзлэгт дугаар харгалзахгүй хамруулна.
- 3.2.17 Тусгаарлах арга хэмжээ нь сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байхаар зохион байгуулагдана.
- 3.2.18 Шинэ болон давтан эмчлэгдэж буй халдвар тараах эрсдэлтэй өвчтөн, эмэнд тэсвэртэй нь лабораториор батлагдсан өвчтөнг эмнэлэгт тусгаарлан хэвтүүлж эмчилнэ.
- 3.2.19 Хүнд хэлбэрийн сүрьеэтэй, амбулаториор эмчилгээ хийлгэх боломжгүй, нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай, эмчилгээ таслах эрсдэлтэй, сэтгэцийн болон бусад хавсарсан эмгэгтэй өвчтөнүүдийн эрчимт шатны эмчилгээг сүрьеэгийн тасагт хийнэ.
- 3.2.20 Сүрьеэгийн эмчилгээг хяналттай хийх боломжтой, гэр бүлдээ халдвар тараах эрсдэл багатай нян ялгаруулж буй өвчтөнг амбулаториор эмчилж болно.
- 3.2.21 Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэх сүрьеэгийн тасаг нь халдварын зэрэг, эмэнд тэсвэржилтийн байдал зэрэгт тохирсон халдварын тархах эрсдэлгүй байх нөхцөлийг хангасан зохион байгуулалттай байна.
- 3.2.22 Сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлж буй халдваргүй өвчтөнг халдвартай өвчтөнтэй холилдохгүй, байхаар тусгаарлан эмчилж, аль болох өрөө бүр дотроо ариун цэврийн өрөөтэй байна.
- 3.2.23 Эмэнд мэдрэг болон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хэвтэн эмчлүүлэх тасгийн хэсгүүд хоорондоо холилдохгүй байхаар тусгаарлаж, аль болох өрөө бүр дотроо ариун цэврийн өрөөтэй байхаар зохион байгуулна.
- 3.2.24 Тасагт нийтийн ариун цэврийн өрөөтэй тохиолдолд эмэнд мэдрэг, эмэнд тэсвэртэй өвчтөний үйлчлүүлэх суултуур тус тусдаа байхаар зохицуулалт хийсэн байна. Өвчтөн ариун цэврийн өрөөгөөр үйлчлүүлэх үед амны хаалт зүүнэ.
- 3.2.25 Ариун цэврийн өрөөг 20 эмэгтэй тутамд 1 суултуур, 12 эрэгтэй тутамд 1 шээлгүүр байхаар төлөвлөсөн байна.
- 3.2.26 Эрүүл мэндийн ажилтан болон хэвтэн эмчлүүлэгч тус тусдаа усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 3.2.27 Тусламж үйлчилгээний онцлогоос хамааран удаан хугацаанд хэвтэн эмчлүүлэгчдийн хувцасыг угаах тусдаа угаалгын машинтай байна.
- 3.2.28 Хэвтэн эмчлүүлэгчийн ор дэрний цагаан хэрэглэл, хөнжил, гудас зөөлөн эдлэлийг эмнэлгийн нэгдсэн угаалгад халдваргүйжүүлсэний дараа угаана.

3.2.29 Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай өвчтөнийг үндсэн тусламж үйлчилгээний тасагт нь тусгаарлаж холбогдох журам зааврын дагуу хавьтлын сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

3.2.30 Сүрьеэгийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тасаг, хэсэг нь агааржуулалт хийх боломжтой байгалийн болон механик агааржуулалтын системтэй, таазанд нь хэт ягаан туяаны гэрэл суурилуулсан, өрөө бүр аль болох дотроо ариун цэврийн өрөөтэй байна.

3.2.31 Өвчтөний цэрний түрхэц, өсгөврийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн тусгаарлалтыг зогсоох, эмнэлгээс гаргах эсэхийг шийдвэрлэн, үргэлжлэх шатны эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

3.2.32 Сүрьеэгийн лаборатори нь ДЭМБ-ын сүрьеэгийн лабораторийн биоаюулгүй ажиллагааны удирдамжид заасан стандартыг мөрдөж ажиллана.

3.2.33 Түрхэц болон молекулбиологийн түргэвчилсэн шинжилгээ хийж буй сүрьеэгийн лаборатори нь нэг чигийн урсгалтай түрхэц бэлтгэх, шинжилгээ хийх, баримт бичиг хөтлөх бүхий 3 өрөөтэй байна. Лаборатори нь гар угаах угаалтуур, лабораториас гарах шингэн хог хаягдалыг зайлуулах бохирын хоолой бүхий суултууртай байна. Хэрэв биоаюулгүйн шүүгээ хэрэглэж байгаа бол II ангилалын А2 төрлийг хэрэглэнэ.

3.2.34 Сүрьеэгийн лавлах лаборатори нь өсгөврөөс түрхэц бэлтгэх, ялган дүйх, эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ, эмэнд-тэсвэржилтийг молекулын аргаар илрүүлэх шинжилгээнд өсгөвөр боловсруулах зэрэг шинжилгээг хийж, ДЭМБ-с зөвлөмж болгож буй аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.

3.2.35 Лабораторийн тоног төхөөрөмж, биоаюулгүйн шүүгээний хэвийн үйл ажиллагаанд инженерийн хяналт тогтмол хийнэ.

3.2.36 Лабораторийн ажилтан нь биоаюулгүй ажиллагааны журмыг чанд баримтлан ажиллаж, энэ чиглэлээр тусгайлан сургагдсан байна.

### **3.3 Орчны хяналтын арга хэмжээ**

3.3.1 Сүрьеэтэй өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх тасаг, амбулаторийн үзлэгийн өрөө, хүлээлгийн хэсэг нь байгалийн болон HEPA шүүлтүүртэй механик агааржуулалтын системтэй, агаарын солилцоо сайтай байна.

3.3.2 Сүрьеэгийн амбулаторийн үзлэгийн өрөө, хүлээлгийн хэсэг, лабораторийн өрөөнд хэт ягаан туяаны гэрэл суурилуулна.

3.3.3 Агааржуулалт ба бусад инженерийн байгууламжийн суурилуулалт, засвар үйлчилгээ, үйл ажиллагаанд нь тоног төхөөрөмжийн инженер тогтмол хяналт тавина.

3.3.4 Агааржуулалтын системийн гүйдэл, хүчдэлийн хэвийн үйл ажиллагаа, шүүлтүүрийн ажиллагааг тоног төхөөрөмжийн инженер улирал тутамд хэмжилт хийж хянана.

3.3.5 Сүрьеэгийн хэвтэн эмчлүүлэх хэсэг, амбулаторийн тусламж үйлчилгээний хэсэгт цагт хамгийн багадаа 6-аас доошгүй удаа агаарын солилцоо хийнэ.

3.3.6 Хэвтэн эмчлүүлэх хэсэгт агаарын сөрөг, эмнэлгийн ажилтны хэсэг болон хоорондын тусгаарлалтын хэсэгт агаарын эерэг даралттай байна.

3.3.8 Сүрьеэгийн нянг устгах, халдваргүйтгэх зорилгоор нээлттэй эсвэл хаалттай хэт ягаан туяаны гэрлийг ашиглана. Хэт ягаан туяаны гэрэл нь 180-254 нм долгионы урттай, UV-C үзүүлэлттэй байна.

3.3.9 Хэт ягаан туяаны гэрлийг 18-20м<sup>2</sup> талбай тутамд 1 ширхгийг суурилуулна. Хэт ягаан туяаны гэрлийн долгионы уртыг зориулалтын хэмжигч багажаар жил бүр хэмжиж, үнэлэлт өгч ажиллана.

3.3.10 Сүрьеэгийн нянг устгах, халдваргүйтгэх зорилгоор нээлттэй эсвэл хаалттай хэт ягаан туяаны гэрлийг ашиглана.

3.3.11 Өрөөний дээд болон доод хэсгийн агаарын хөдөлгөөнийг сайжруулах төхөөрөмжийн хамт өрөөний таазанд тогтоодог хэт ягаан туяаны гэрлийг хэрэглэвэл илүү үр дүн сайн.



3.3.12 Хэт ягаан туяаны стандарт үзүүлэлт 20%-аас буурахад гэрэл ашиглах хугацаа дууссан гэж тооцно.

3.3.13 Хэт ягаан туяаны гэрлийн ламп харласан, долгион гүйсэн, үнэр ялгаруулсан тохиолдолд ашиглахгүй.

3.3.14 Хэт ягаан туяанд өртсөн тохиолдолд нүд, арьс цочрох тул техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.

#### **4. Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналт**

##### **4.1 Гар угаах, халдваргүйжүүлэх**

4.1.1 Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, шингэн саван, гар арчих зориулалтын нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

4.1.2 Гарын эрүүл ахуй сахих 5 заалтыг хэрэгжүүлж ажиллана.

4.1.3 Гар угаах дарааллыг бүрэн гүйцэтгэж, гар угаах хугацаа 1 минут, халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс багагүй байна.

##### **4.2 Хувийн хамгаалах хэрэгсэл:**

4.2.1 Сүрьеэгийн тусламж үйлчилгээний хэсэгт хэрэглэх хамгаалах хувцас, хэрэгсэлд нэг удаагийн малгай, халад, шүүлтүүртэй амны хаалт, бээлий, гутал хэрэглэнэ.

4.2.2 Шүүлтүүртэй амны хаалт нь нүүрэнд битүүмж үүсгэн зай завсах гаргахгүй, зөв тохируулан зүүхэд тоосонцор болон бичил биетнийг шүүдэг. Эрүүл мэндийн ажилтанд амьсгалын замын халдвар дамжих эрсдэлийг бууруулна. Ажилбарын үед хэрэглэнэ.

4.2.3 Загвар нь хүний нүүрний онцлогт тохирсон, битүүмжлэл үүсгэх боломжтой, ярих, амьсгалах, үед ам руу татагдаж, хонхойдоггүй байна.

4.2.4 Эрүүл мэндийн байгууллага нь олон улсын стандартын шаардлага хангасан болон өөрсдийн хэрэглээнд тохирсон шүүлтүүртэй амны хаалт (N95, FFP2, FFP3)-аар хангаж, ашиглалт-хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

4.2.5 Эрүүл мэндийн ажилтан нь сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шүүлтүүртэй амны хаалтыг хэрэглэнэ.

4.2.6 Хэвтэн эмчлүүлэгч болон амбулаторийн үйлчлүүлэгч нь нэг удаагийн эсвэл даавуун амны хаалт тогтмол зүүж хэрэглэнэ.

4.2.7 Өвчтөн ханиах найтаах үедээ ердийн алчуур буюу цаасаар ам хамраа дарах, тохойн нугалсан хэсгийг ашиглана.

4.2.8 Шүүлтүүртэй амны хаалтыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэх ба чийг, тоос, шороо зэргээр бохирдох, хэв алдагдахаас сэргийлж хадгална.

4.2.9 Уушгины түрхэц/Жене эерэг, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнд тусламж үзүүлэхдээ эмнэлгийн ажилтан, сахиур шүүлтүүртэй амны хаалт зүүнэ.

4.2.10 Цэр цуглуулах болон ханиалгалт үүсгэх ажилбар, гуурсан хоолой, ходоод дурандах, мэс засал, задлан шинжилгээ, уушгины багтаамж хэмжих үед, сүрьеэтэй байж болзошгүй өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх үед шүүлтүүртэй амны хаалт зүүнэ.

##### **4.3 Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт**

4.3.1 Эрүүл мэндийн байгууллага бүр байгууллагын онцлогт тохирсон цэвэрлэгээ хийх журам, цэвэрлэгээний хуваарийг ХСХ-ын алба, багаар хянаж, батлуулсан байна.

4.3.2 Цэвэрлэгээ хийх үед ахуйн бээлий, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.

4.3.3 Эрүүл мэндийн байгууллага нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, шаардлага хангасан халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

4.3.4 Халдваргүйжүүлэлтэд тасаг, алба/диспансер, нэгжийн эмч, сувилагч хяналт тавина.

4.3.5 Эрсдэл багатай хэсгээс ихтэй хэсэг рүү чиглэсэн урсгалтай байх бөгөөд цэвэрлэгээний хэсгийг тусад нь зохион байгуулж, цэвэрлэгээний хэрэгслийг тус бүрт байршуулна.

#### **4.4 Хог хаягдлын менежмент:**

4.4.1 Сүрьеэгийн тасаг, алба (диспансер), нэгжид өвчтөний тагтай саванд цуглуулсан цэрэнд гуравны нэгтэй тэнцэх хэмжээний халдваргүйжүүлэх уусмалыг хийж, бодисын үйлчлэх хугацааг баримтлан халдваргүйжүүлсний дараа бохир усны шугам, шаардлага хангасан бохирын цооногт хийнэ.

4.4.2 Сүрьеэгийн лабораториос гарч буй өсгөвөр, тэжээлт орчин, цэрний сорьцын материал зэрэг халдвартай хог хаягдлыг автоклаваар халдваргүйжүүлсний дараа аюултай хог хаягдал түр хадгалах байр руу зөөвөрлөнө.

4.4.3 Цэрний халдваргүйтгэлд фенол болон хлор агуулсан бодисоос сонгон хэрэглэнэ. Халдваргүйжүүлэлтэд тасаг, алба/диспансер, нэгжийн эмч, сувилагч хяналт тавина.

4.4.4 Сүрьеэгийн мэс ажилбар, задлан шинжилгээний явцад тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, ихэс, зулбадас гэх мэт эмгэг хог хаягдлыг шингэн нэвчдэггүй, бат бөх зориулалтын уут бүхий таглаатай саванд цуглуулж хог хаягдал устгалын төвлөрсөн байгууламжид хүлээлгэн өгнө. Орон нутагт эхсийн нүхэнд хийнэ.

4.4.5 Хог хаягдлын материалын төрөл, хэмжээ зэргээс хамааран автоклавт 121°C-ийн хэмд 20 минут, 134°C-ийн хэмд 10 минутын хугацаанд халдваргүйжүүлнэ.

4.4.6 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежментийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зааврын дагуу сүрьеэгийн лаборатори болон тасаг, нэгжээс гарч буй аюултай хог хаягдлын менежментээр зохицуулагдана.

## Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулах журам

### 1. Нийтлэг үндэслэл

Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зорилго нь сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, оношилгоо болон эмчилгээний хожимдлыг багасгах улмаар хувь хүмүүсийн эмчилгээний таагүй үр дагавар, сүрьеэгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад оршино.

Зөвхөн эрүүл мэндийн байгууллагад хандсан хүмүүсийн дунд буюу идэвхгүй аргаар сүрьеэтэй бүх хүмүүсийг илрүүлэх боломжгүй тул сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын дунд илрүүлэлтийг нэмэгдүүлж, сүрьеэг идэвхтэй аргаар илрүүлэх шаардлагатай.

### 2. Нэр томъёоны тодорхойлолт

Сүрьеэгийн илрүүлэлтэд дараах нэр томъёог хэрэглэнэ. Үүнд:

#### 2.1 Идэвхтэй илрүүлэлт

Асуумж, цээжний рентген болон молекулын түргэвчилсэн шинжилгээг ашиглан эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг илрүүлэх явуулын багийн арга хэмжээ юм.

#### 2.2 Идэвхгүй илрүүлэлт

Сүрьеэгийн шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгч эрүүл мэндийн байгууллагад хандах үед эрүүл мэндийн ажилтан сүрьеэтэй байж болзошгүй байдлыг үнэлж, сүрьеэгийн оношилгоонд хамруулах арга хэмжээ юм.

#### 2.3 Хиймэл оюун ухаанд суурилсан илрүүлэлт (CAD)

Тусгай компьютер программыг ашиглан цээжний рентген зураг дахь хэвийн бус байдлыг илрүүлэх арга юм. Идэвхтэй илрүүлэлт болон триаж ашиглана.

#### 2.4 Давтан илрүүлэлт

Тодорхой хугацаанд сүрьеэгийн эрсдэлт бүлэгт илрүүлэлтийг давтан зохион байгуулахыг хэлнэ.

#### 2.5 Илрүүлэлтэд хамрагдвал зохих хүний тоо

Идэвхтэй илрүүлэлтээр хамгийн багадаа сүрьеэтэй нэг тохиолдлыг илрүүлэхэд шаардлагатай хүний тоог хэлнэ. (Хамрагдвал зохих хүний тоо=1/эрсдэлт бүлгийн сүрьеэгийн тархалт)

#### 2.6 Эрсдэлт бүлэг

Нийт хүн амтай харьцуулахад сүрьеэгийн тархалт болон өвчлөл өндөртэй бүлэг хүн амыг хэлнэ.

#### 2.7 Идэвхтэй сүрьеэ

Сүрьеэгийн микобактерийн халдварын улмаас тухайн хүнд үүссэн эмгэг байдал юм. Энэ үед сүрьеэгийн шинж тэмдэг, өөрчлөлтүүд илэрдэг учир сүрьеэгийн халдварлагдсан байдлаас ялгаатай.

### 3. Идэвхтэй илрүүлэлтийн зорилго, зарчим

#### 3.1 Идэвхтэй илрүүлэлтийн зорилго

Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, оношлох, эмчилгээний хожимдлоос сэргийлж улмаар хувь хүний эмчилгээний таагүй үр дагавар болон нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад оршино. Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амын дунд идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулна. (Хүснэгт 2).

### 3.2 Илрүүлэлтэд хамрагдвал зохих хүний тоо

Дараах томъёогоор илрүүлэлтэд хамрагдвал зохих хүний тоо (ИХЗХТ)-г тодорхойлно.

### 3.3 ИХЗХТ=1/эрсдэлт бүлгийн сүрьеэгийн тархалт

Асуумж, эмнэлзүйн үзлэг болон цээжний рентген шинжилгээг хамтад нь зохион байгуулах үед идэвхтэй илрүүлэлтээр илрүүлбэл зохих тохиолдлын тоог дараах байдлаар тооцоолно. Сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй үндсэн бүлгийн 100 хүн тутамд 3-5 сүрьеэгийн тохиолдол, сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй бусад бүлгийн 100 хүн тутамд 1-2 сүрьеэгийн тохиолдол гэж тооцно.

### 3.4 Идэвхтэй илрүүлэлтийн зарчим

3.4.1 Илрүүлэлт зохион байгуулахын өмнө илрүүлэлтээр илэрсэн сүрьеэтэй өвчтөнд үзүүлэх оношилгоо, эмчилгээний чадавхыг бүрдүүлсэн байх ёстой.

3.4.2 Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний чадавхыг бүрэн бүрдүүлсэн үед идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулна.

3.4.3 Идэвхтэй илрүүлэлтэд сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулна.

3.4.4 Ёсзүйн хэм хэмжээ, хүний эрхийг дээдлэх ба илрүүлэлтийн явцад хувь хүнд таагүй байдал, ялгаварлан гадуурхалтыг үүсгэхгүй байхаар зохион байгуулна.

3.4.5 Идэвхтэй илрүүлэлтийн алгоритмыг ашиглана.

3.4.6 Илрүүлэлт хийх аргачлал нь бусад эрүүл мэндийн болон нийгмийн халамж дэмжлэгийн үйл ажиллагаатай уялдах буюу хамтран хийх боломжтой байна.

3.4.7 Идэвхтэй илрүүлэлтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

3.4.8 Идэвхтэй илрүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангана.

**Хүснэгт 1. Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамруулбал зохих эрсдэлт бүлгүүд, шинжилгээний төрөл, давтамж, хариуцах байгууллага**

№	Бүлэг	Эрсдэлт бүлэг	Шинжилгээний төрөл	Давтамж	Хариуцах байгууллага,
	Сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй үндсэн бүлэг	Сүрьеэтэй өвчтөний эрхийн болон ойрын хавьтал***	<ul style="list-style-type: none"> <li>Эмнэлзүйн үзлэг</li> <li>Асуумж</li> <li>Цээжний рентген шинжилгээ</li> <li>Молекулын түргэвчилсэн шинжилгээ (Xpert MTB/RIF)</li> </ul>	6 сар тутамд	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, Дүүргийн ЭМТ, өрх/сум, тосгоны ЭМТ
		Цахиурын тоосжилтод өртөж буй уул уурхайн хүмүүс			ХӨСҮТ-ийн ДОХ, БЗДХ алба, ТББ
		ХДХВ-ийн халдвартай хүмүүс			ШШГЕГ, харьяа хорих байгууллага
		Хорих ангийн хоригдлууд ба албан хаагчид			
	Сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй бусад бүлэг	Эрүүл мэндийн тусламж	<ul style="list-style-type: none"> <li>Эмнэлзүйн үзлэг</li> <li>Асуумж</li> <li>Цээжний рентген шинжилгээ</li> <li>Молекулын түргэвчилсэн шинжилгээ</li> </ul>	6 сар тутамд	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, Дүүргийн ЭМТ, бусад байгууллага
		Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой эмзэг бүлгийн хүн ам		Жилд 1 удаа	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, Дүүргийн ЭМТ өрх/сум, тосгоны ЭМТ

ал байдал	Шилжин суурьшигч	(Xpert MTB/RIF)		
Эрүүл мэндийн шалтгаантай	Сэтгэцийн эмгэгтэй		6 сар тутамд	СЭМҮТ
	Цээжний рентген шинжилгээнд фиброз өөрчлөлттэй		Жилд 1 удаа	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, Дүүргийн ЭМТ өрх/сум, тосгоны ЭМТ
	Тураалтай			
	Чихрийн шижинтэй			
	Өмнө нь сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан			
	Амьсгалын замын архаг өвчтэй			
	Уушгины хатгаатай хүмүүс			
	Ходоод тайруулах мэс засал хийлгэсэн			
	Бөөрний архаг дутагдалтай			
	Дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж хийлгэж байгаа			
	Ахмад настай (60 ба түүнээс дээш)			
Архи согтууруулах ундаа болон мансууруулах бодис				
Ажлын байр, өвөрмөц орчин	Эрүүл мэндийн ажилтан		Жилд 1 удаа	Тухайн эрүүл мэндийн байгууллага
	Бусад уул уурхайн ажилчид		Жилд 1 удаа	Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, Дүүргийн

		Асрамжийн газарт байгаа хүмүүс		Жилд 1 удаа	ЭМТ өрх/сум, тосгоны ЭМТ
		Сүрьеэгийн дэгдэлт бүртгэгдсэн бусад ажлын байр (сургууль, цэцэрлэг, дотуур байр, цэргийн анги, гэх мэт)		6 сар тутамд	

\*\*\*Индекс-тохиолдол бүртгэгдсэнээс хойш 14 хоногийн дотор, давтан үзлэгийг эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний хавьтал жилд 1, нийт 3 удаа, эмэнд тэсвэртэй сүрьеэ 6 сар тутам, нийт 5 удаа хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдана.

#### 4. Идэвхтэй илрүүлэлтийн зохион байгуулалт, алгоритм

Сүрьеэгийн илрүүлэлтийг Засгийн газрын Эрт илрүүлгийн үйл ажиллагаатай аль болох уялдуулах, илрүүлэлт зохион байгуулахаас өмнө Хүснэгт 2-д заагдсан сүрьеэгийн эрсдэлт бүлгийн судалгааг нарийвчлан Маягт 1-д бүртгэж, хариуцах байгууллагууд хамтран чанартай зохион байгуулна.

Маягт 1-д бүртгэгдсэн эрсдэлт бүлгийн хүний 85%-с дээш хувийг идэвхтэй илрүүлэлтэд хамруулна. Идэвхтэй илрүүлэлтээр сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлуудыг тухайн аймаг дүүргийн сүрьеэгийн тасаг, алба /диспансер/-ны эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж, илэрсэн тохиолдлуудыг бүртгэж, эмчилгээнд бүрэн хамруулна.

Идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулахад бэлтгэл үе, ажлын талбар, тайлан гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.

##### 4.1 Идэвхтэй илрүүлэлтийн бэлтгэл үе

4.1.1 Идэвхтэй илрүүлэлтээс өмнө хамрагдах хүмүүсийн мэдээллийг Маягт 1-д бүртгэсэн байна.

4.1.2 Илрүүлэлт эхлэхээс 7-10 хоногийн өмнө хариуцах байгууллага нь өрх, сум, тосгоны ЭМТ, хорооны холбогдох хүмүүстэй очиж уулзана. Илрүүлэлтийн ач холбогдол, өрх, сум, тосгоны ЭМТ болон сум, хорооны үүрэг оролцоо, үзлэгийн хуваарь болон үзлэгт хамрагдах хүн амын талаар мэдээлэл өгнө.

4.1.3 Илрүүлэлт зохион байгуулах орон байр, талбайг сонгож, тухайн хороо, өрх, сум, тосгоны ЭМТ-ийн удирдлагуудтай тохиролцож баталгаажуулна.

4.1.4 Илрүүлэлт зохион байгуулах товыг гаргаж хүний нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, илрүүлэлтийн зарыг хүргэнэ.

##### 4.2 Идэвхтэй илрүүлэлтийн ажлын талбар

Илрүүлэлт явуулах өрөө тасалгаа болон аппарат тоног төхөөрөмж, үзлэг шинжилгээний хэсгийг **нэг урсгалтай** байхаар зохион байгуулна. Илрүүлэлт явагдах орон байр, талбайд идэвхтэй илрүүлэлтийг эмх цэгцтэй хийх үүднээс дараах байдлаар зохион байгуулна.

4.2.1 Бүртгэлийн хэсэг: Энэ хэсэгт илрүүлэлтэд оролцохоор ирсэн хүний нэрийг Маягт 1 буюу идэвхтэй илрүүлэлтэд хамрагдах хүмүүсийн бүртгэлд байгаа эсэхийг шалгаж, ирсэн тухай тэмдэглэлийг хөтөлнө. Асуумжид бүртгэлийн дугаар болон ерөнхий мэдээллийг бөглөж оролцогчид өгнө. Бүртгэлийг өрх, сум, тосгоны ЭМТ эсвэл сум, хорооны аль нэг мэргэжилтэн хийнэ.

4.2.2 Асуумж ярилцлагын хэсэг: Энэ хэсэгт илрүүлэлтэд оролцогч бүрээс Маягт 2 буюу сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний асуумжийг асууна. Асуумжид сүрьеэгийн шинж тэмдэг, хавьтал судлал, өмнөх эмчилгээний түүхийн талаар асууж ярилцлага хийнэ.

Ярилцлагыг 2 хүн асуух үед хоорондын суудлын зайг 2 метрээс багагүй байхаар төлөвлөнө. Асуумжийг өрх, сум, тосгоны ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн авна.

4.2.3 Цээжний рентген шинжилгээ (CAD): Асуумж ярилцлагын дараа цээжний рентген зураг авч, хиймэл оюун ухааны технологиор уншуулна. Рентген техникч "Цацрагийн аюулгүй байдлын дүрэм"-ийг баримталж ажиллана. Маягт 3 буюу цээжний рентген шинжилгээний бүртгэлийг хөтөлнө.

4.2.4 Эмнэлзүйн болон хяналтын хэсэг: Асуумж ярилцлага, рентген зургийн дүгнэлтийг үндэслэн эмнэлзүйн үзлэг болон цэрний шинжилгээнд хамруулах шаардлагатай хүнийг тодорхойлно. Уушгины бус сүрьеэгийн үед зонхилон тохиолдох өөрчлөлтүүдийг илрүүлнэ. Цэрний шинжилгээнд хамрагдах шаардлагатай оролцогч буюу сүрьеэтэй байж болзошгүй хүнийг илрүүлж, цэрний сорьц цуглуулах хэсэгт илгээнэ. Сүрьеэгийн эмч зөвлөгөө өгч эмнэлзүйн үзлэгийн Маягт 4 бүртгэлийг хөтөлнө.

4.2.5 Цэрний сорьц цуглуулах хэсэг: Цэрний сорьц авах шаардлагатай оролцогчоос тухайн үеийн цэрний сорьцыг сувилагч ба/эсвэл лаборант авах бөгөөд цэр цуглуулах кабин байхгүй нөхцөлд гадаа орчинд авна. Маргааш өглөөний сорьцыг авчирч өгөхийг оролцогчид тайлбарлана. Илрүүлэлтэд ирж чадахгүй хэвтрийн хүнийг гэрт нь очиж, асуумж авч, цэрний сорьц цуглуулна. Сувилагч эсвэл лаборант Маягт 5 буюу цэрний сорьцын бүртгэлийг хөтөлнө.

4.2.6 Цэрний сорьц тээвэрлэх, хүргэх: Цуглуулсан цэрний сорьцыг холбогдох журмын дагуу хадгалж, өрх, сум, тосгоны ЭМТ нь харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори, шаардлагатай үед ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн үндэсний лавлах лаборатори (СҮЛЛ)-д тээвэрлэн хүргэнэ.

4.2.7 Нян судлалын шинжилгээ: Харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори нь молекулын түргэвчилсэн (Xpert MTB/RIF гэх мэт) шинжилгээг хийж, оношийг баталгаажуулна. Молекулын түргэвчилсэн (Xpert MTB/RIF гэх мэт) шинжилгээгээр рифампицинд тэсвэртэй илэрсэн үед ХӨСҮТ-ийн СҮЛЛ-д 2-р эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох болон өсгөвөрлөх шинжилгээнд илгээнэ.

#### **4.3 Идэвхтэй илрүүлэлтийн тайлан, мэдээ**

Маягт 6 буюу сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулсан тухай тоон тайланг гаргаж, аймаг, дүүргийн сүрьеэгийн тасаг, алба/диспансерт илрүүлэлт дууссанаас хойш 7 хоногийн дотор мэдээлнэ. Аймаг, дүүргийн сүрьеэгийн алба /диспансер нь идэвхтэй илрүүлэлтийн тайланг нэгтгэж, Маягт 7 буюу идэвхтэй илрүүлэлтийн тайланг ХӨСҮТ-ийн СТСА-нд улирал тутам мэдээлнэ.

#### **4.4. Идэвхтэй илрүүлэлтийн дараах хяналт**

Илэрсэн сүрьеэгийн тохиолдлын цаашдын оношилгоо, эмчилгээ, хяналтыг энэхүү тушаалын холбогдох оношилгоо эмчилгээний зааврын дагуу зохион байгуулна. Илэрсэн тохиолдлууд эмчилгээнд хамрагдсан байдалд илрүүлэлтийг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллага хяналт тавина. Мөн цээжний рентген зурагт идэвхтэй сүрьеэгийн өөрчлөлттэй боловч цэрний шинжилгээгээр онош батлагдаагүй (цэрний шинжилгээнээс татгалзсан гэх мэт) хүмүүсийг нэрсийг гаргаж, өрх, сум, тосгоны ЭМТ эсвэл сүрьеэгийн алба/диспансерын хяналтад авна.

## **2. Идэвхтэй илрүүлэлтийн арга, шинжилгээ**

Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд асуумж, цээжний рентген шинжилгээ (хиймэл оюунд суурилсан технологи бүхий), ДЭМБ-ын зөвлөмж болгосон молекулын түргэвчилсэн шинжилгээ (XpertMTB/RIF(ultra) гэх мэт)-г хийж гүйцэтгэнэ. Дараах аргуудыг дан дангаар нь хэрэглэх нь мэдрэг, өвөрмөц чанар багатай тул хамтад нь хэрэглэх аргыг Хүснэгт 3-т тайлбарлав.

### **Хүснэгт 2. Илрүүлэлтийн аргын мэдрэг болон өвөрмөц чанар**

Арга	Мэдрэг чанар %	Өвөрмөц чанар %
Ханиалга (>2 долоо хоног)	42	94
Ханиалгах	51	88
Аль нэг шинж тэмдэг	71	64
Рентген (хэвийн бус байдал)	94	89
Рентген (сүрьеэгийн эмгэг)	85	96
ДЭМБ-аас зөвлөмж болгож буй молекулын түргэвчилсэн шинжилгээ (XpertMTB/RIF(ultra) гэх мэт)	69	99

### 5.1 Асуумж

14 хоногоос дээш хугацаанд ханиалгах шинж тэмдгийн асуумж нь сүрьеэгийн халдвар тараах магадлалтай хүмүүсийг илрүүлэх өвөрмөц чанар өндөр боловч мэдрэг чанар багатай арга тул сүрьеэгийн тохиолдлын 50%-г илрүүлэх боломжтой. Цустай цэр гарах, халуурах, шөнө хөлрөх, турах зэрэг бусад шинж тэмдэг илрэх нь өвөрмөц чанар багатай.

### 5.2 Цээжний рентген шинжилгээ

Уушгины сүрьеэгийн оношилгооны үр дүнтэй арга бөгөөд бусад уушги, цээжний бусад эмгэгийг илрүүлэх боломжтой. Сүрьеэгийн шинж тэмдэг илэрч буй эмгэгийн үед мэдрэг чанар нь 85% болон өвөрмөц чанар 96% байна. Идэвхтэй илрүүлэлтэд зөөврийн дижитал рентген аппарат ашиглах нь бага тунгаар цацраг ялгаруулдаг бөгөөд дамжуулах чадвар өндөр, боловсруулах хугацаа богино, орчинд үзүүлэх цацрагийн нөлөөлөл багатай. Дижитал зургийг архивлах, сэргээх, хуулах, шилжүүлэх, зайнаас мэдээлэх боломжтой. Цацрагийн аюулгүй байдлын холбогдох дүрмийг баримтлан ажиллана.

### 5.3 Хиймэл оюун ухааны технологи

Дижитал рентген зурагт дүн шинжилгээ хийж, сүрьеэгийн магадлалыг 1-ээс 100-ын хоорондох үзүүлэлтээр илэрхийлнэ. Сүрьеэгийн илрүүлэлтэд дижитал рентген зураг бүрийг хиймэл оюун ухааны технологийн программыг ашиглан уншуулах нь илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй. Сүрьеэгийн өөрчлөлт илэрсэн хүмүүсээс цэрний сорьцыг цуглуулна.


### 5.4 Молекулын түргэвчилсэн шинжилгээ

Сүрьеэгийн микобактери комплекс болон рифампициний тэсвэржилт илрүүлэх хурдан, мэдрэг чанар өндөртэй арга юм. Хэрэв өвчтөн хангалттай хэмжээний цэр ялгаруулахгүй, цэрний сорьцод нянгийн ачаалал маш бага эсвэл сорьцын чанар хангалтгүй үед молекулын түргэвчилсэн шинжилгээгээр (XpertMTB/RIF(ultra) гэх мэт) сөрөг байж болно. Энэ тохиолдолд сүрьеэг үгүйсгэхгүй.

### 5.5 Илрүүлэлтийн алгоритм

Сүрьеэгийн илрүүлэлтэд дараах алгоритмыг хэрэглэнэ. Идэвхтэй илрүүлэлтийн үед хүн бүрийг асуумж-ярилцлага, цээжний рентген шинжилгээнд хамруулна. (Зураг 1).





Зураг 1. Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амд хийх сүрьеэгийн илрүүлэлтийн алгоритм

### 3. Идэвхтэй илрүүлэлтийн хяналт шинжилгээ, үнэлгээ

#### 6.1 Идэвхтэй илрүүлэлтийн явцын хяналт

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр идэвхтэй илрүүлэлтийн зохион байгуулалт, эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтыг Хүснэгт 4 дэх хяналтын хуудасны дагуу үнэлнэ.

#### Хүснэгт 3. Идэвхтэй илрүүлэлтийн хяналтын хуудас

Үзүүлэлт	Оноо	Үзүүлэлт	Оноо
<b>Бэлтгэл, нөөц</b>			
Эрсдэлт бүлгийн судалгаа Маягт 1 хөтөлсөн эсэх		Өмнөх өдрийн үзлэгийн тоо мэдээг тайлангаар гаргасан эсэх	
Явуулын баг ажиллаж байгаа эсэх, бүрэлдэхүүн		Гар халдваргүйтгэх нөхцөл бүрдүүлсэн эсэх	
Үзлэгийг нэг урсгалтай зохион байгуулж буй эсэх		Сорьцын сав хүрэлцээтэй эсэх	
Илрүүлэлт эхлэхээс 2-3 хоногийн өмнө оролцогчдод хугацаа, байршил мэдэгдсэн эсэх		Молекулын түргэвчилсэн шинжилгээний оношлуур хүрэлцээтэй эсэх	
<b>Бүртгэлийн хэсэг</b>			
Маягт 1 дагуу эрсдэлт бүлгийн судалгаанд бүртгэгдсэн хүмүүсийн хамрагдалт, хувь		Үзлэгийн хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор утсаар холбогдсон эсэх	
Бүртгэл хариуцсан хүн нэг удаагийн халад, амны хаалт хэрэглэж буй эсэх		Агаар сэлгэлт хангалттай юу	
<b>Асуумж ярилцлагын хэсэг</b>			
Ярилцагчийн тоо тохиромжтой эсэх		Асуумж-ярилцлагад оролцогчдын хоорондын зай хангалттай эсэх	
Асуултыг зөв, тодорхой авч буй эсэх		Ярилцагч нар нэг удаагийн халад, амны хаалт хэрэглэж буй эсэх	
<b>Цээжний рентген шинжилгээ - Цацрагийн аюулгүй байдал</b>			
Цацрагийн аюулгүй байдлын тэмдэглэгээ, анхааруулгыг хаалга, хананд байрлуулсан эсэх		Цээжний рентген шинжилгээний бүртгэлийн маягыг ашиглаж буй эсэх	
Оролцогчид хэрэглэх хормогч, бамбайн хаалт байгаа эсэх		Цацрагийн тун хэмжигч хэрэглэж буй эсэх	
Рентген аппарат ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөл байгаа эсэх		Рентген аппаратыг зөв байрлуулсан эсэх/ Анхдагч туяаны чиглэлийг хүнгүй хэсэгт чиглүүлэх	
Зөөврийн тугалган хаалтыг байрлуулсан эсэх		Хамгаалалтын хөшиг байрлуулсан эсэх	

<b>Эмнэлзүйн болон хяналтын цэг</b>			
Эмнэлзүйн болон хяналтын цэгт сүрьеэгийн эмч ажиллаж байгаа эсэх		Сорьц өгөх шаардлагатай оролцогчийг бүртгэж буй эсэх	
<b>Цэрний сорьцын хэсэг</b>			
Тухайн үеийн сорьцыг сүрьеэтэй байж болзошгүй хүн бүрээс цуглуулж буй эсэх		Сорьц хадгалах хөргөгчийн температур 2-8 <sup>o</sup> C байгаа эсэх	
Сорьц тээвэрлэх саванд термометр бий эсэх		Сорьцын бүртгэл хөтөлж буй эсэх	
Өглөөний сорьц ирээгүй үед авах арга хэмжээг авсан эсэх		Сорьцыг 1-3 хоногийн дотор лабораторид зөөвөрлөж хүргэсэн эсэх	

Хяналтын хуудсыг авбал зохих 32 оноогоор дүгнэнэ. 90-100% хангалттай, 80-89% анхаарах шаардлагатай, 70-79% хангалтгүй, арга хэмжээг шуурхай авах, 69%-с доош үргэлжлүүлэх боломжгүй.

## **6.2 Идэвхтэй илрүүлэлтийн шалгуур үзүүлэлт**

6.2.1 Илрүүлэлтэд хамрагдвал зохих хүний тоо (эрсдэлт бүлэг бүрээр)-нийт эрсдэлт бүлгийн 300-500 хүн

6.2.2 Илрүүлэлтэд хамрагдсан хүний тоо- 85%-с дээш

6.2.3 Сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо-нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 20%-с дээш

6.2.4 Сүрьеэтэй байж болзошгүй хүнээс молекулын түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан хүний тоо-100%

6.2.5 Сүрьеэ илэрсэн хүний тоо- 100 хүн тутамд тооцооллын дагуу 1-5 тохиолдол

6.2.6 Эмчилгээнд орсон хүний тоо- батлагдсан нийт тохиолдлыг 100% хамруулах

6.2.7 Эмчилгээ дуусгасан хүний тоо- эмчилгээний амжилт 95%-с дээш

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
01 сарын 29 өдрийн /34 тоот  
тушаалын дөрөвдүгээр хавсралт

## Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний бүртгэл мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний журам

### 1. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай өгөгдлийг улсын хэмжээнд тасралтгүй системтэйгээр цуглуулах, мэдээлэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргагч нарыг нотолгоонд суурилсан мэдээ мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагад эргэн мэдээлэл, зөвлөмжийг боловсруулж, хүргүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Сүрьеэгийн тандалтын тогтолцоо нь бусад тандалтын тогтолцоотой нягт уялдаатай ажиллаж, харилцан мэдээ мэдээллийг солилцон хамтран ажиллана.

Хяналт шинжилгээ нь сүрьеэтэй тэмцэх ажилд тулгарч буй асуудлуудыг илрүүлэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлж үнэлгээ нь сүрьеэгийн тусламж үйлчилгээний журам, зааварт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд гарсан нөлөөллийг тооцох арга хэмжээ байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээг сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажлын байранд нь очиж хяналт, шинжилгээг хийхээс гадна тогтмол гардаг тайлан мэдээнд дүгнэлт хийх байдлаар гүйцэтгэнэ. Хяналт, шинжилгээ, үнэлгээг сар, улирал, жилээр төлөвлөн зохион байгуулна.

### 2. Нэр томъёоны тодорхойлолт

#### 2.1 Сүрьеэгийн тандалтын тогтолцоо

Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хянах зорилгоор сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээллийн өгөгдлийг системтэйгээр, тасралтгүй цуглуулан нэгдсэн дүн шинжилгээ, тайланг боловсруулан шийдвэр гаргагч нар болон эрүүл мэндийн байгууллагыг нотолгоонд суурилсан мэдээ мэдээллээр хангах үндэсний нэгдсэн тогтолцоо юм.

#### 2.2 Хяналт шинжилгээ

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний журам, заавар, бодлогын бичиг баримтын хэрэгжилт, хөтөлбөрийн зорилго, зорилтдоо хүрэх явц/үйл ажиллагааг байнгын системтэйгээр хянах, ахиц дэвшил, явцыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хянах, дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, мэдээлэх тасралтгүй үйл явц юм.

#### 2.3 Үнэлгээ

Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлэх үйл явц юм.

### 3. Сүрьеэгийн тандалтын тогтолцооны үндсэн хэрэглэгдэхүүн

3.1 Тохиолдолд суурилсан цахим бүртгэл, тандалтын тогтолцоог сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч бүх шатны төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд хэрэгжүүлж, мэдээллийн аюулгүй, тасралтгүй, найдвартай байдлыг ханган ажиллана.

3.2 Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын эмч, тархвар судлаач, эм зүйч, лаборант, сувилагч, бага эмч, дүн бүртгэгч зэрэг нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж оношилгоо, эмчилгээ, хяналтын шинжилгээ, эмийн орлого зарлага, эмчилгээний хяналт, үр дүн, хавьтлын үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх эмчилгээ зэрэг бүх мэдээллийг цаг хугацаанд нь бүртгэнэ.

3.3 Эмч сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлыг оношлох шинжилгээний хүсэлтийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори болон ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторид илгээнэ. Шинжилгээний хүсэлт илгээгдсэн өвчтөний сорьцыг аймаг, дүүргийн болон Сүрьеэгийн үндэсний лавлагаа лаборатори хүлээн авч шинжилгээг хийж, хариуг цаг тухайд нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэж баталгаажуулна.

3.4 Сүрьеэтэй тохиолдлыг анх илрүүлж оношилсон бүх шатны төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч нь онош батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох журмын дагуу цахимаар мэдээлнэ.

3.5 Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийг байгууллагын түвшинд хэрэгжүүлж бүртгэл мэдээллийн үнэн бодит, бүрэн гүйцэт, цаг хугацаандаа мэдээлэх байдлыг ханган ажиллаж дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргагч нар болон эрүүл мэндийн байгууллагыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.

3.6 Сүрьеэгийн бүртгэл мэдээлэл хариуцсан дүн бүртгэгч нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийн мэдээллийг холбогдох цаасан бүртгэлийн маягтад хуулан баталгаажуулна.

3.7 Сүрьеэгийн тандалтын тогтолцооны үндсэн хэрэглэгдэхүүн болох бүртгэл тайлангийн маягтууд нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS) болон цаасан хэлбэрээр байх ба мэдээллүүд нь хоорондоо тохирч байна.

#### **Хүснэгт 4. Сүрьеэгийн тандалтын тогтолцооны бүртгэл, тайлангийн маягтууд**

Зорилт	Бүртгэл			Тайлан		Тайлбар
	Маягт	Хэрэглэгч	Тайлбар	Маягт	Давтамж	
1 Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол	СҮ-10	Өрх, сумын эмч	Сүрьеэтэй байж болзошгүй болон цэрний сорьц тээвэрлэсэн тохиолдлын бүртгэл	Сорьц тээвэрлэлтийн тайлан	Улирал бүр	Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч нь өрх сумын ЭМТ-ийн сорьц тээвэрлэлтийн тайлан мэдээнд үндэслэн сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын мэдээг улирал тутам нэгтгэн гаргаж дүн шинжилгээ хийнэ.
		Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч	Эмчийн үзлэгийн цахим бүртгэлд "өвчний учир амбулаторид анх удаа" үзүүлсэн тохиолдлын тоо. Өдөр тутам, тухай бүр цахим бүртгэлд оруулна.	Үзлэгийн цахим мэдээ	Сар бүр	Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч нь амбулаторийн үзлэгийн цахим мэдээнд үндэслэн сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын мэдээг улирал тутам гаргаж дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээг авч ажиллана.
	ХӨСҮТ-ийн үзлэгийн эмч	Эмчийн үзлэгийн цахим бүртгэлд "өвчний учир амбулаторид анх удаа" үзүүлсэн тохиолдлын тоо. Сүрьеэгийн тохиолдол оношлогдвол холбогдох журмын дагуу цахимаар мэдээлнэ	Үзлэгийн цахим бүртгэл мэдээ	Сар бүр	ХӨСҮТ-ийн үзлэгийн эмч нь үзлэгийн цахим мэдээнд үндэслэн сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын мэдээг улирал тутам гаргаж дүн шинжилгээ хийж СТСА-нд мэдээлж байна.	
2 Мэдрэг сүрьеэгийн тохиолдол	СҮ-1	Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч	Эмчилгээнд хамрагдсан эсэхээс үл хамааран илэрсэн тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн СҮ-1 маягт хөтлөнө.	СҮ-7, СҮ-8, СҮ-9,	Сар бүр, улирал тутам	Сүрьеэгийн тохиолдлын сүрьеэгийн цахим мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.
		Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч, Өрх сумын эмч, Бусад ЭМБ-ын эмч	Мэдрэг сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн СҮ-2 маягт хөтлөнө. Тухайн өвчтөн өрх сум, бусад ЭМБ-ын хяналтанд эмчлэгдэх тохиолдолд СҮ-2 картыг хувилж тухайн эмчлэх эмчид хүлээлгэн өгнө.			Сүрьеэгийн тохиолдлын үр дүнгийн СҮ-8, сөрөгт шилжилтийн СҮ-9 тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.

3	<p>Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол</p>	<p>ЭТС-1</p>	<p>Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч</p>	<p>Эмчилгээнд хамрагдсан эсэхээс үл хамааран илэрсэн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн ЭТС-1 маягт хөтлөнө.</p>	<p>ЭТС-ийн /ИТ, РТ, ОЭТС, МОЭТС-ийн урьдал, МОЭТС/ бүртгэгдсэн тохиолдлын ЭТС-7 тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.</p>
3	<p>Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдол</p>	<p>ЭТС-2</p>	<p>Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч, Өрх сумын эмч, Бусад ЭМБ-ын эмч</p>	<p>Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн ЭТС-2 маягт хөтлөнө. Тухайн өвчтөн өрх сум, бусад ЭМБ-ын хяналтанд эмчлэгдэх тохиолдолд ЭТС-2 картыг хувилж тухайн эмчлэх эмчид хүлээлгэн өгнө.</p>	<p>Улирал тутам</p>
4	<p>Хавьтал хяналт, урьдчилан сэргийлэх эмчилгээ</p>	<p>СҮ-11</p>	<p>Тархвар судлаач, сүрьеэгийн эмч, дүн бүртгэгч, өрх сумын эмч</p>	<p>Сүрьеэтэй өвчтөний хавьтал нэг бүрийг бүртгэн авч, үзлэг шинжилгээг цаг тухай бүрд нь сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн СҮ-11 маягт хөтлөнө.</p>	<p>Сүрьеэтэй өвчтөний хавьталын үзлэгийн тайлан СҮ-12 тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.</p>
4	<p>Хавьтал хяналт, урьдчилан сэргийлэх эмчилгээ</p>	<p>СҮ-20</p>	<p>Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч, Өрх сумын эмч</p>	<p>Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд орсон тохиолдлын үзлэг шинжилгээ, үр дүнгийн мэдээллийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн СҮ-20 маягт хөтлөнө.</p>	<p>Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээний үр дүнгийн тайлан УСЭ-8 тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.</p>
4	<p>Хавьтал хяналт, урьдчилан сэргийлэх эмчилгээ</p>	<p>УСЭ-2</p>	<p>Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч, Дүн бүртгэлийн бага эмч, Өрх сумын эмч, Бусад ЭМБ-ын эмч</p>	<p>Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан тохиолдол бүрийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэн урьдчилан сэргийлэх эмчилгээ хяналтын карт УСЭ-2 маягт хөтлөнө.</p>	<p>Улирал тутам</p>

				Тухайн тохиолдол өрх сум, бусад ЭМБ-ын хяналтанд эмчлэгдэх тохиолдолд УСЭ-2 картыг хувилж тухайн эмчлэх эмчид хүлээлтэн өгнө.				
				Биологийн шингэнд сүрьеэгийн үүсгэгч үзүүлэхээр илгээж буй эмч сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д СҮ-3 маягтыг бөглөж, лабораторид илгээнэ.	СҮ-3	Тухай бүрт	Шинжилгээ хийсэн эмч, лабораторийн техникч сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д үр дүнг бичиж, шаардлагатай бол цаасаар давхар мэдээлж болно.	
				Эмэнд мэдрэг чанар тодорхойлох болон өсгөврөлх шинжилгээнд илгээж байгаа бол СҮ-4 маягтыг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бөглөж, лабораторид илгээнэ.	СҮ-4	Тухай бүрт		
				Сүрьеэгийн шинжилгээ өгсөн үйлчлүүлэгчийг хүсэлтийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс хайж шинжилгээний үр дүнг бүртгэнэ.	СҮ-6 СҮ-15	Сар тутам	Түрхцийн болон молекулын шинжилгээний тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.	
				Өсгөврөлх шинжилгээ өгсөн үйлчлүүлэгчийн хүсэлтийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс хайж, шинжилгээний үр дүнг бүртгэнэ.	СҮ-17	Улирал тутам	Өсгөврөлх шинжилгээний гүйцэтгэлийн тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.	
				Сүрьеэгийн шинжилгээ өгсөн үйлчлүүлэгчийн хүсэлтийг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээс хайж, шинжилгээний үр дүнг бүртгэнэ.	ЭТС-5	Улирал тутам	Эмэнд тэсвэртэй илэрсэн тохиолдын бүртгэлийн тайлан сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ээр мэдээлэгдэнэ.	
5	Лабораторийн бүртгэл тайлан							



	Интерферон-гамма тодорхойлох шинжилгээний хуудас, бүртгэл	Сүрьеэгийн халдвар илрүүлэхээр илгээж буй эмч, лабораторийн эмч, мэргэжилтэн	Сүрьеэгийн халдвар илрүүлэхээр илгээж буй эмч маягтыг цаасан ба/эсвэл цахим бөглөж лабораторид илгээнэ. Шинжилгээ хийсэн эмч, лабораторийн техникч үр дүнг бичиж, шинжилгээ илгээсэн эмчид цаас ба/эсвэл цаасан мэдээлнэ.	Интерферон-гамма тодорхойлох шинжилгээний тайлан	Тухай бүрт	Шинжилгээ хийсэн эмч, лабораторийн техникч үйлчлүүлэгчийн мэдээлэл шинжилгээний үр дүнг тухай бүрт нь лабораторийн бүртгэлд бүртгэнэ.
	Аденозиндеамин аза тодорхойлох шинжилгээний хуудас, бүртгэл	Биологийн шингэнд АДА ферментийн идэвхжил тодорхойлуулахаар илгээж буй эмч, лабораторийн эмч, мэргэжилтэн	Шинжилгээнд илгээж буй эмч маягтыг цаасан ба/эсвэл цахим бөглөж лабораторид илгээнэ. Шинжилгээ хийсэн эмч, лабораторийн техникч үр дүнг бичиж, шинжилгээ илгээсэн эмчид цаас ба/эсвэл цахимаар мэдээлнэ.	Аденозиндеами наза тодорхойлох шинжилгээний тайлан	Тухай бүрт	Сар бүрийн орлого зарлагыг тооцож, эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалган сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Тайланг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS) болон цаасаар мэдээлэгдэнэ.
6 Эмийн бүртгэл тайлан	СҮ-23	Аймаг дүүргийн эм зүйч, сүрьеэгийн эмч, ХӨСҮТ-ийн эмзүйч, эм хариуцсан мэргэжилтэн	Сарын дундаж өвчлөлд үндэслэн захиалгыг хийнэ. (Аймаг улиралд 1 удаа) ХӨСҮТ-ийн эмзүйч эмч тухайн аймгийн өвчлөлд үндэслэн эмийн захиалгад хяналт хийж, баталгаажуулж эмийг олгоно. Эмийн орлого, зарлагыг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д өдөр тутам хөтөлнө	СҮ-26	Сар бүр	Сар бүрийн орлого зарлагыг тооцож, эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалган сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Тайланг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS) болон цаасаар мэдээлэгдэнэ.
	СҮ-24	Аймаг дүүргийн эм зүйч, сүрьеэгийн эмч, ХӨСҮТ-ийн эмзүйч, эм хариуцсан мэргэжилтэн	Эмчилгээтэй байгаа болон эмчилгээнд орж байгаа тохиолдол бүрт 1-3 сараар эмийг тооцоолж захиална. Өвчтөн бүрийн биеийн жин, эмчилгээний горимыг зайлшгүй бичнэ. Эмийн орлого, зарлагыг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д өдөр тутам хөтөлнө	СҮ-27	Сар бүр	Сар бүрийн орлого зарлагыг тооцож, эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалган сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Тайланг сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS) болон цаасаар мэдээлэгдэнэ.

7	<p>СҮ-13</p>	<p>СКЗ-ийн эмч, аймаг дүүргийн сүрьеэгийн эмч</p>	<p>ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникт өвчтөн хэвтэхэд цахим болон цаасаар нээх ба эмнэлгээс гарахад нь цаасан болон цахим шилжүүлгийг харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт илгээнэ.</p>	<p>АМ-4</p>	<p>Ажлын 5 хоногийн дотор</p>	<p>Сүрьеэгийн оношлогдсон тохиолдол бүрийг тухайн оношилсон ЭМБ болон эмч нь ажлын 5 хоногт багтаан "Сүрьеэгийн тохиолдлыг мэдээлэх хуудас АМ-4" маягтын дагуу цахимаар бүртгэн мэдээлнэ. Харьяа сүрьеэгийн диспансерт нь мэдээлнэ.</p>
Бусад	<p>СҮ-21</p>	<p>Аймаг дүүргийн сүрьеэгийн эмч</p>	<p>Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байх явцад өвчтөн шилжих тохиолдолд сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэж шилжин очих аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт мэдээлнэ.</p>	<p>ЭМТ-302</p>	<p>Жилд</p>	<p>Жилийн үйл ажиллагааны тайланг аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч эмч нар жилийн эцсээр тасалбар болгон гаргаж дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик мэдээллийн алба (СМА)-нд, аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик мэдээллийн алба нь 1 дүгээр сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн СТСА-нд, ХӨСҮТ-ийн СТСА нь 2 дугаар сарын 15-ны дотор ЭМХТ-д хүргүүлнэ.</p>

#### **4. Хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа**

4.1 Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч ажиллагсад, чанарын алба, баг нь тогтмол хийж хянахаас гадна, төлөвлөгөөтэйгөөр хагас жил тутамд хийж гүйцэтгэнэ.

4.2 Гадаад хяналт, шинжилгээ, үнэлгээг улсын хэмжээнд ХӨСҮТ-ийн СТСА, орон нутгийн түвшинд аймаг дүүргийн сүрьеэгийн алба/диспансер, эрүүл мэндийн анхан шатлалд /багийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд/ сумын болон өрхийн ЭМТ-ийн хяналт үнэлгээний баг төлөвлөгөөтэйгөөр тогтмол хийж гүйцэтгэнэ.

4.3 Хяналт шинжилгээ, үнэлгээгээр гүйцэтгэх үйл ажиллагаанд хамаарах асуудал нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заагдсан эрүүл мэндийн байгууллагуудын "Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах журам"-д заагдсан үйл ажиллагаанаас бүрдэнэ.

4.4 Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн эх сурвалжаар энэхүү журмын "Сүрьеэгийн тандалтын тогтолцоонд хэрэглэгдэх бүртгэл, мэдээллийн маягтууд"-ыг ашиглана. Мөн эрүүл мэндийн үйлчилгээний талаарх мэдээлэл, байгууллагад суурилсан судалгааны үр дүн, сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем (TUBIS)-ийн мэдээллийг ашиглана.

4.5 Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын явцад сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн ажилтнууд болон өвчтөнтэй уулзаж ярилцах, ажлын байрны сургалт хийснээр хүний нөөц, зохион байгуулалт, эрүүл мэндийн ажилтнууд болон өвчтөний сүрьеэ өвчний талаарх мэдлэг, үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.

4.6 Хяналт шинжилгээ, үнэлгээг тодорхой удирдамжийн дагуу хийж гүйцэтгэх ба тусгай хяналтын хуудсыг боловсруулан ашиглана.

4.7 Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт, алба/диспансерын бүтэц, хүний нөөц, багаар ажиллах чадвар, төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж буй байдал зэрэгт хяналт тавина.

4.8 Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл, ололт амжилт, дутагдалтай талуудыг илрүүлэн дүгнэлт, зөвлөмж өгөх, бүртгэгдсэн өвчтөний болон эмчилгээний үр дүнгийн тайланд тархвар судлалын үзүүлэлтүүдийг тооцон харьцуулж дүгнэлт хийнэ.

4.9 Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, цуглуулсан мэдээлэл, тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, шийдвэр гаргахад ашиглана.

4.10 Хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтийн биелэлт, үр дүн, зөвлөмжийг тухайн нэгжийн удирдлага, чанарын алба, холбогдох эмч, эмнэлгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн хэрэгжилтэд тодорхой хугацаатайгаар хяналт тавьж, эргэх холбоотой ажиллана.

#### **5. Хяналт шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд**

Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь сүрьеэ өвчнөөс сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг тооцох зэрэг үйл ажиллагааг үнэлэхэд ашиглах хэрэглүүрийн нэг юм.


**Хүснэгт 5. Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал**

№	Шалгуур, зорилт	Тооцох арга	Эх сурвалж	ХШҮ-ний түвшин		
				ХӨСҮТ	НЗ, ЭМТ	Өрх сумын ЭМТ
<b>Зарчим-1: Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол бүрийг илрүүлж, үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж, бүртгэх, мэдээлэх</b>						
1	Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын түвшин, 10000 хүн амд	<b>Хүртвэр:</b> Сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо <b>Хуваарь:</b> Жилийн дундаж хүн амын тоо	CY-10 (TUBIS)	+	+	+
2	Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын нян судлалын шинжилгээнд хамрагдсан байдал (хувь) - >95%	<b>Хүртвэр:</b> Нян судлалын шинжилгээнд хамрагдсан сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо <b>Хуваарь:</b> Сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо	CY-10 CY-5 (TUBIS)	+	+	-
3	Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын нян судлалын шинжилгээ (түрхэц, Хpert, өсгөвөр) эерэг гарсан хувь – 5-15%	<b>Хүртвэр:</b> Нян судлалын шинжилгээ эерэг илэрсэн сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо <b>Хуваарь:</b> Нян судлалын шинжилгээнд хамрагдсан сүрьеэтэй байж болзошгүй хүний тоо	CY-10 CY-5 (TUBIS)	+	+	-
<b>Зарчим-2: Сүрьеэгийн тохиолдол бүрийг илрүүлж, бүртгэх</b>						
4	Бүх хэлбэрийн шинэ сүрьеэгийн бүртгэгдсэн түвшин, 10000 хүн амд	<b>Хүртвэр:</b> Бүртгэгдсэн бүх хэлбэрийн шинэ сүрьеэгийн тоо <b>Хуваарь:</b> Жилийн дундаж хүн амын тоо	CY-7 (TUBIS)	+	+	+
5	Шинээр илэрсэн уушгины сүрьеэгийн бүртгэгдсэн түвшин, 10000 хүн амд	<b>Хүртвэр:</b> Бүртгэгдсэн шинэ уушгины сүрьеэгийн тоо <b>Хуваарь:</b> Жилийн дундаж хүн амын тоо	CY-7 (TUBIS)	+	+	+
6	Нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэгийн бүртгэлд авсан хувь – 100%	<b>Хүртвэр:</b> Бүртгэлд авсан цэрний нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэтэй өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Нян судлалаар батлагдсан уушгины сүрьеэтэй нийт өвчтөний тоо	CY-7 CY-1 (TUBIS) CY-5	+	+	-
7	Уушгины сүрьеэтэй өвчтөний нян судлалын шинжилгээнд хамрагдсан хувь (5-аас дээш нас) – 100%	<b>Хүртвэр:</b> Цэрний нян судлалын шинжилгээнд хамрагдсан уушгины сүрьеэтэй өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Уушгины сүрьеэтэй нийт өвчтөний тоо	CY-1 CY-5 (TUBIS)	+	+	-
8	Илрүүлэлтийн түвшин - >95%	<b>Хүртвэр:</b> Бүх хэлбэрийн шинэ сүрьеэгийн бүртгэгдсэн тоо <b>Хуваарь:</b> Тооцоолсон өвчлөлийн тоо	CY-7 (TUBIS)	+	+	-

№	Шалгуур, зорилт	Тооцох арга	Эх сурвалж	ХШҮ-ний түвшин		
				ХӨСҮТ	НЭ, ЭМТ	Ерх сумын ЭМТ
Зарчим-3: Өвчтөн бүрд сүрьеэгийн эмчилгээг дэмжлэгтэй, хяналттай (эрүүл мэндийн ажилтан, сургагдсан СДА болон гэр бүлийн гишүүд)-аар өдөр бүр хийх						
9	ЭМА-ны хяналтад эмчлэгдсэн өвчтөний эзлэх хувь – 70%	<b>Хүртвэр:</b> ЭМА-ны хяналттай эмчлэгдсэн өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Бүртгэгдсэн өвчтөний тоо	CY-1 CY-2 CY-8* (TUBIS)	+	+	+
10	Сургагдсан СДА болон гэр бүлийн гишүүдийн хяналттай эмчлэгдсэн өвчтөний эзлэх хувь - >30%	<b>Хүртвэр:</b> Сургагдсан СДА болон гэр бүлийн гишүүдийн хяналттай эмчлэгдсэн өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Бүртгэгдсэн өвчтөний тоо	CY-1 CY-2 CY-8* (TUBIS)	+	+	+
Зарчим-4: Бүх өвчтөн амжилттай эмчлэх, тэдний эмчилгээний үр дүнг тохиолдлын тодорхойлолтын дагуу бүртгэх.						
11	Эмчилгээний амжилт – >90%	<b>Хүртвэр:</b> Эдгэрсэн+эмчилгээ дууссан өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	+
12	Эдгэрэлтийн түвшин - >85%	<b>Хүртвэр:</b> Эдгэрсэн өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Нян судлалаар батлагдсан уушгины шинэ сүрьеэтэй, эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	+
13	Эмчилгээ дуусгасан түвшин – 90% 1.Эмнэлзүйгээр оношлогдсон бүх тохиолдол, 2.Нян судлалаар батлагдсан уушгины шинэ тохиолдолд хяналтын шинжилгээ гүйцэт хийгдээгүй)	<b>1.Хүртвэр:</b> Эмнэлзүйгээр оношлогдсон тохиолдлоос эмчилгээ дуусгасан өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Эмнэлзүйгээр оношлогдон эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо <b>1.Хүртвэр:</b> Нян судлалаар оношлогдон, <u>эмчилгээ дуусгасан</u> уушгины сүрьеэтэй өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Нян судлалаар оношлогдон <u>эмчилгээнд хамрагдсан</u> уушгины сүрьеэтэй өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	-
14	Эмчилгээ үр дүнгүй болсон түвшин – 0%	<b>Хүртвэр:</b> Эмчилгээ үр дүнгүй болсон өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	-
15	Хяналтаас алдагдсан түвшин – 0%	<b>Хүртвэр:</b> Эмчилгээний явцад хяналтаас алдагдсан өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	+
16	Эмчилгээний өмнө болон явцад нас барсан өвчтөний эзлэх хувь – 0%	<b>Хүртвэр:</b> Эмчилгээний явцад нас барсан өвчтөний тоо + эмчилгээний өмнө нас барсан өвчтөний тоо	CY-1 CY-8* (TUBIS)	+	+	+

№	Шалгуур, зорилт	Тооцох арга	Эх сурвалж	ХШҮ-ний түвшин		
				ХӨСҮТ	НЭ, ЭМТ	Өрх сумын ЭМТ
		<b>Хуваарь:</b> Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо				
17	Үр дүнг тооцоогүй өвчтөний эзлэх хувь (шилжсэн, тодорхойгүй) – 0%	<b>Хүртвэр:</b> Эмчилгээний төгсгөлд үр дүнг тооцоогүй өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	СҮ-1 СҮ-8* (TUBIS)	+	+	+
<b>Зарчим-5 Сүрьеэтэй тохиолдол (шинэ болон өмнө эмчлэгдсэн) бүрийг ЭМЧТШ-нд хамруулах</b>						
18	Шинээр бүртгэгдсэн тохиолдлын ЭМЧТШ-нд хамрагдсан хувь – 100%	<b>Хүртвэр:</b> ЭМЧТШ-нд хамрагдсан шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо <b>Хуваарь:</b> Шинээр бүртгэгдсэн цэрний түрхэц эерэг тохиолдлын тоо	СҮ-1 СҮ-2 СҮ-5 (TUBIS)	+	+	-
19	Өмнө нь эмчлэгдсэнээр бүртгэгдсэн тохиолдлын ЭМЧТШ-нд хамрагдсан хувь – 100%	<b>Хүртвэр:</b> ЭМЧТШ-нд хамрагдсан өмнө эмчлэгдсэнээр бүртгэгдсэн тохиолдлын тоо <b>Хуваарь:</b> Өмнө эмчлэгдсэнээр бүртгэгдэж эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо	СҮ-1 СҮ-2 СҮ-5 (TUBIS)	+	+	-
<b>Зарчим-6: Сүрьеэгийн халдвартай тохиолдол бүрийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулж, бүртгэх</b>						
20	Өрхийн хавьтал хүмүүсийн туберкулины арьсны сорил эсвэл IGRA шинжилгээнд хамрагдсан хувь – >90%	<b>Хүртвэр:</b> Бүх насны өрхийн хавьтлаас туберкулины арьсны сорил эсвэл IGRA шинжилгээнд хамрагдсан тоо <b>Хуваарь:</b> Бүх өрхийн хавьтлын тоо	СҮ-11 СҮ-12 (TUBIS)	+	+	-
21	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээний хамралт - >90%	<b>Хүртвэр:</b> Урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдсан өрхийн хавьтлын тоо <b>Хуваарь:</b> Өрхийн нийт хавьтлын тоо	СҮ-11 СҮ-20 (TUBIS)	+	+	+
<b>Зарчим-7: Сүрьеэтэй өвчтөн бүрийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулж, эерэг тохиолдолд РВЭЭ, КУС эмчилгээнд хамруулж, бүртгэх</b>						
22	ХДХВ-ийн халдварын статус нь мэдэгдэж байгаа сүрьеэтэй өвчтөний эзлэх хувь – 100%	<b>Хүртвэр:</b> ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний хариутай өвчтөний тоо <b>Хуваарь:</b> Бүртгэгдсэн нийт өвчтөний тоо	СҮ-1 СҮ-2 СҮ-7 (TUBIS)	+	+	-
<b>Зарчим-8: Сүрьеэгийн эмийн зохистой менежмент: нэгж бүрд эмийн зохих нөөцтэй байх</b>						
23	Эмийн нөөцийн хүрэлцээтэй сар - >1 сар	Тухай үеийн нөөцийг сарын хэрэгцээнд нь хуваана	Үйл ажиллагааны	+	+	-

№	Шалгуур, зорилт	Тооцох арга	Эх сурвалж	ХШҮ-ний түвшин		
				ХӨСҮТ	НЭ, ЭМТ	Ерх сумын ЭМТ
			эмийн тайлан			
<b>Зарчим-9: Мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах</b>						
24	Тасралтгүй сургалтад хамрагдсан сүрьеэгийн эмчийн эзлэх хувь - >80%	<b>Хүртвэр:</b> Тухайн жилд тасралтгүй сургалтад хамрагдсан эмчийн тоо <b>Хуваарь:</b> Нийт сүрьеэгийн эмчийн тоо	үйл ажилла гааны тайлан	+	+	-
<b>Зарчим-10: Хяналт-Шинжилгээ, үнэлгээг системтэй хийх</b>						
25	Дэмжлэгт хяналтын хамралт - >70%	<b>Хүртвэр:</b> Тухайн жилд дэмжлэгт хяналт хийгдсэн нэгжийн тоо <b>Хуваарь:</b> Нийт нэгжийн тоо	Үйл ажилла гааны тайлан	+	+	+



## **Сүрьеэгийн дэгдэлтийг тандах, хянах, хариу арга хэмжээг зохион байгуулах журам**

### **1. Нийтлэг үндэслэл**

Сүрьеэгийн дэгдэлтийг тандах, хянах, хариу арга хэмжээг системтэй төлөвлөх, түүний бэлэн байдлыг хангах, дэгдэлтийг таслан зогсоох зорилгоор дэгдэлтийн эх уурхайг тодорхойлох, идэвхтэй сүрьеэгийн болон халдвар авсан бүх тохиолдлыг илрүүлж, цаг алдахгүй эмчлэх үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулж, сүрьеэгийн өвчлөл, эндэгдэл, нийгэмд учрах хохирлыг бууруулахад оршино.

### **2. Сүрьеэгийн дэгдэлтийн тархварзүйн нэр томьёо**

#### **2.1 Сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй**

Тухайн орон зай буюу хүн амын дунд ердийн үетэй харьцуулахад илүү олон идэвхтэй сүрьеэгийн тохиолдол илрэхийг хэлнэ.

#### **2.2 Сүрьеэгийн дэгдэлт**

Нэг жилийн хугацаанд тухайн орон зай буюу нэг голомтоос тархварзүйн холбоотой 2 ба түүнээс дээш тооны идэвхтэй сүрьеэгийн тохиолдол илэрсэн тохиолдлыг хэлнэ.

#### **2.3 Тархварзүйн холбоо**

Дэгдэлтээр илэрсэн тохиолдлууд нь тархвар зүйн хувьд холбоотой байдгаараа бусад (өвчлөл өндөр бүс нутаг, хүн ам, эрсдэлт бүлэг) өвчлөлөөс ялгаатай. Энэ нь сүрьеэгийн нянгийн халдвар хэзээ, хаана дамжин тархсаныг тайлбарлахуйц үзүүлэлт бөгөөд дараах ойлголтыг агуулна. Үүнд:

2.3.1 Цаг хугацаа (эх уурхайн халдвартай байсан хугацаа, хавьтлын халдварт өртсөн хугацааны давхцал)

2.3.2 Халдварт өртсөн газар (нэг анги танхим, сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, ажлын байр, эмнэлэг, дотуур байр, цэргийн анги, хорих анги гэх мэт)

2.3.3 Ижил шинж чанартай хүмүүс (сурагчид, цэргүүд, оюутнууд, ажилчид, өвчтөнүүд, хоригдлууд гэх мэт)

2.3.4 Эмэнд тэсвэржилт ижил

2.3.5 Үүсгэгчийн генийн хэв шинж ижил байх.

#### **2.4 Тархвар судлалын заалт**

Сүрьеэгийн голомтод сүрьеэгийн өвчлөлийг бууруулах, тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зайлшгүй арга хэмжээний үндэслэлийг хэлнэ.

#### **2.5 Идэвхтэй сүрьеэ**

Сүрьеэгийн микобактерийн халдварын улмаас тухайн хүнд үүссэн эмгэг байдал юм. Энэ үед сүрьеэгийн шинж тэмдэг, өөрчлөлтүүд илэрдэг учир сүрьеэгийн халдварлагдсан байдлаас ялгаатай.

#### **2.6 Индекс тохиолдол**

Тухайн өрх, түүнтэй адилтгах орон байр, анги танхим, ажлын байр, асрамжийн газар, хорих анги гэх мэт газраас сүрьеэтэй илэрсэн эхний тохиолдлыг хэлнэ.

#### **2.7 Халдварын эх уурхай**

Бусдад сүрьеэгийн халдварыг анхлан тараасан гэж үзэж буй сүрьеэтэй өвчтөнийг хэлнэ.

#### **2.8 Халдвартай байсан хугацаа**

Сүрьеэ өвчин оношлогдохоос өмнөх 3 сарын хугацааг хэлнэ.



## **2.9 Халдварт өртсөн хугацаа**

Сүрьеэтэй өвчтөний халдвартай байх хугацаанд нь түүнтэй хамт (нэг агаартай) өнгөрүүлсэн хугацааг хэлнэ.

### **2.10 Өртсөн газар**

Эх уурхай, индекс тохиолдол халдвартай байх хугацаандаа амьдарч буюу ажиллаж байсан орон зай, байршлыг (эмнэлэг, хорих анги, цэргийн анги, асрамжийн газар, сургууль, цэцэрлэг, дотуур байр, ажлын байр гэх мэт) хэлнэ.

### **2.11 Хавьтал**

Сүрьеэтэй өвчтөний халдвартай байх хугацаанд нь түүнтэй хамт (нэг агаартай) байснаар *M.tuberculosis* нянгийн халдварт өртсөн хүнийг хэлнэ.

### **2.12 Ойрын хавьтал**

Өрхийн хавьтал биш боловч индекс тохиолдлын халдвартай байх хугацаанд эмнэлэг, хорих анги, цэргийн анги, асрамжийн газар, сургууль, цэцэрлэг, дотуур байр, ажлын байр гэх мэт газарт хамт байсан хүнийг хэлнэ.

### **2.13 Бичиглэл судалгаа**

"Хэн, хэзээ, хаана" гэсэн асуултад хариулах замаар хүн амын дунд тохиолдож буй өвчлөлийн байдлыг дүрслэн харуулдаг судалгааны загвар юм. Энэ судалгаанд үндэслэн нөөц хуваарилах, дэгдэлтийн хариу арга хэмжээг төлөвлөхөөс гадна өвчнийг тодорхойлогч хүчин зүйлс (дэгдэлт мөн эсэх, эх уурхай гэх мэт)-ийн талаар таамаглал дэвшүүлнэ.

### **2.14 Дэгдэлтийн үеийн илрүүлэх үзлэг, шинжилгээ**

Эмнэлзүйн үзлэг, асуумж, халдварлагдсан эсэхийг илрүүлэх (туберкулины арьсны сорил, IGRA гэх мэт), цээжний рентген болон лабораторийн шинжилгээг ашиглан идэвхтэй сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх зорилгоор зохион байгуулж буй системтэй үзлэг, шинжилгээг хэлнэ. Энэхүү үзлэг шинжилгээг 6 сар тутамд давтан хийх бөгөөд өмнөх үзлэгээр арьсны сорил сөрөг тохиолдлуудад сорилыг давтан хийнэ. Дэгдэлт гарсан голомтын 2-5 жилийн хугацаанд идэвхтэй тандалтыг хийнэ.

### **2.15 Дэгдэлт зогсох /намжсан/ байдал**

2 удаагийн дараалсан сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээгээр нян судлалаар батлагдсан болон эмнэлзүйгээр оношлогдсон тохиолдол илрэхгүй байх нөхцөлийг хэлнэ.

Сүрьеэгийн дэгдэлтийн үед илрүүлэх үзлэгт хамруулах үйлчлүүлэгсдийг дараах тохиолдлын тодорхойлолтын дагуу эрэмбэлэн ангилна. Үүнд:

### **2.16 Болзошгүй тохиолдол**

Эмнэлзүйн шинж тэмдэгтэй, тархварзүйн холбоотой, багажийн шинжилгээнд өөрчлөлттэй боловч нян судлалын шинжилгээгээр батлагдаагүй тохиолдлыг хэлнэ. (Хүснэгт 7).

### **2.17 Батлагдсан тохиолдол**

Нян судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдлыг хэлнэ.

### **2.18 Дэгдэлтийн бус тохиолдол**

Идэвхтэй сүрьеэ илэрсэн боловч тархварзүйн холбоо хамааралгүй тохиолдлыг хэлнэ.

### **2.19 Сүрьеэгүй**

Эмнэлзүйн шинж тэмдэггүй, багажийн шинжилгээнд өөрчлөлтгүй, нян судлалын шинжилгээ болон туберкулины арьсны сорил ба/эсвэл интерферон гамма (IGRA) тодорхойлох шинжилгээ сөрөг тохиолдлыг хэлнэ.

### **2.20 Сүрьеэгийн халдварлагдсан**

Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан ч эмнэлзүйн ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй хүнийг хэлнэ. Энэ тохиолдолд туберкулины арьсны сорил ба/эсвэл интерферон гамма

(IGRA) тодорхойлох шинжилгээ эерэг байх боловч багажийн болон нян судлалын шинжилгээнд өөрчлөлтгүй байгаа тохиолдлыг хэлнэ.

**Хүснэгт 6. Сүрьеэгийн дэгдэлтийн үеийн тохиолдлын тодорхойлолт, шалгуур, арга хэмжээ**

Эмнэлзүй /шинж тэмдэг	Багажийн шинжилгээ	Нян судлал	Тархвар-зүйн холбоо	Туберкулин сорил/ IGRA	Тохиолдлын тодорхойлолт	Арга хэмжээ
+	+	-	+	+/-	Болзошгүй	Сүрьеэгийн эмчилгээ хийх
+/-	+/-	+	+	+/-	Батлагдсан	
+/-	+/-	+	-	+/-	Дэгдэлтийн бус	
-	-	-	+/-	+	Сүрьеэгийн халдвар	урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх
-	-	-	+/-	-	Сүрьеэгүй	Хянах

### 3. Сүрьеэгийн дэгдэлтийг илрүүлэх

3.1 Сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлэхдээ олон нийт болон хувь хүний оролцоог дэмжих зарчмыг баримтлан дараах мэдээллийн эх сурвалжид үндэслэн илрүүлнэ.

3.2 Сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор аймаг, дүүргийн сүрьеэгийн алба/диспансер нь сар бүрийн эхний 7 хоногт багтаан тохиолдлын бүртгэлээс тухайн үеийн болон түүнээс өмнөх 1 жилийн хугацааны сүрьеэгийн өвчлөлийг эргэн нягтлах замаар сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн эсэхийг тодруулна. Сүрьеэ хариуцсан тархвар судлаач эмч хариуцан ажиллана.

3.3 Хэрэв сүрьеэгийн ойрын хавьтлын дундах сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээгээр 2-оос дээш тооны идэвхтэй сүрьеэгийн тохиолдол илэрсэн бол дэгдэлт байж болзошгүй гэж үзэж хавьтлын үзлэг, шинжилгээг зохион байгуулна.

3.4 Дэгдэлт байж болзошгүй тохиолдолд эх уурхайг илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулна. Хүүхдийн сүрьеэгийн халдварын эх уурхай нь өрхөөс тогтоогдоогүй үед ойрын хавьтал буюу сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид, ангийн хүүхдүүдийг сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулна. Энэхүү үзлэг шинжилгээгээр 2-оос дээш тооны идэвхтэй сүрьеэгийн тохиолдол илэрсэн бол ХӨСҮТ-ийн СТСА-нд цаг алдахгүй мэдээлнэ.

3.5 ХӨСҮТ-ийн СТСА нь сүрьеэгийн цахим бүртгэл, мэдээллийн систем (TUBIS)-ийн өвчлөл болон лабораторийн шинжилгээ хэсгээс аймаг, дүүргийн түвшинд сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн эсэхийг илрүүлэх тандалтыг сар тутам хийнэ. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд тогтмол тандалт хийнэ.

3.6 Сүрьеэгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлэг нь сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдал илрүүлсэн бол ХӨСҮТ-ийн СТСА-нд 48 цагийн дотор утсаар болон цахим хаягаар мэдээлнэ.

### 4. Сүрьеэгийн дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ

#### 4.1 Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ


Дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдал илэрснийг мэдээлсэн тохиолдолд дараах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ. (Хүснэгт 8). Үүнд:

- 4.1.1 Сүрьеэгийн дэгдэлт байж болзошгүй нөхцөл байдлыг баталгаажуулах, дэгдэлтийн тохиолдлыг тодорхойлж, жагсаалт гаргах
- 4.1.2 Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийг бүрдүүлж, хариу арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах
- 4.1.3 Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулах
- 4.1.4 Дэгдэлтийн үеийн эмнэлзүйн менежментийн арга хэмжээг зохион байгуулах
- 4.1.5 Урьдчилсан үр дүнг солилцох, тайлагнах
- 4.1.6 Дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх
- 4.2 Дэгдэлтийн үед сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах хүрээ**
- 4.2.1 Дэгдэлтийг илрүүлэх үед сүрьеэгийн өвчлөл нь тухайн голомт дахь нийт хүн амын 1%-с давсан тохиолдолд нийт (жишээ нь: сургуулийн бүх сурагчид, ажилчид, багш нарыг хамарсан)-ийг хамарсан илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулна.
- 4.2.2 Харин 1%-д хүрээгүй бол сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг хязгаарлагдмал хүрээ (зөвхөн өвчлөл бүртгэгдсэн анги, ажлын байр, салаа, дотуур байр гэх мэт)-ний хүн амыг хамруулан зохион байгуулна.

**Хүснэгт 7. Сүрьеэгийн дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээ, хариуцах байгууллага, мэргэжилтэн**

№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хариуцагч
1	Сүрьеэгийн дэгдэлтийг баталгаажуулах, тохиолдлын жагсаалт гаргах	1) Дэгдэлтийн тохиолдлын болон ойрын хавьтлын жагсаалтыг гаргана. - Индекс тохиолдлын халдвартай байсан хугацаа - Хавьтлуудын халдварт өртсөн хугацаа - Өртсөн газар - Тархвар зүйн холбоог үнэлнэ. 2) Өөрийн аймаг, дүүргийн тохиолдлын бүртгэлээс одоогийн болон өмнөх 1 жилийн өвчлөлийг харьцуулж, дүгнэлт хийнэ. 3) Улсын хэмжээний тохиолдлын бүртгэлээс одоогийн болон өмнөх 1 жилийн өвчлөлийг харьцуулж, дүгнэлт хийнэ. 4) Дээрх мэдээллийг ашиглан бичиглэл судалгааг (цаг хугацаа, орон зай, хүн) хийж, дүгнэнэ. 5) Дэгдэлт мөн эсэхэд үнэлгээ өгнө. 6) Шуурхай эргэн мэдээлж, дэгдэлтийн хариу арга хэмжээ авах эсэхийг тодорхойлно.	Мэдээлсэн байгууллагын тархвар судлаач, сүрьеэгийн эмч           ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач, хяналтын эмч
2	Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийг бүрдүүлэх, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах	1) Орон нутгийн удирдлагад сүрьеэгийн дэгдэлт болж байгаа талаар танилцуулах 2) Зохион байгуулалтын болон талбарт ажиллах /дэгдэлтийн хариу арга хэмжээ авах баг/ багийг томилох, мэргэжил арга зүйгээр хангах 3) Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, шуурхай хэрэгжүүлэх 4) Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, санхүүжилтийг бүрдүүлэх, баталгаажуулах	Аймаг, нийслэлийн ЭМГ, дэгдэлтийн хариу арга хэмжээний баг, Энэрэл, Хорих, СЭМҮТ, дэгдэлтийн хариу арга хэмжээний баг
3	Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулах	1) Дэгдэлтийн цар хүрээг тодорхойлж, илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулбал зохих хүмүүсийн жагсаалтыг боловсруулах 2) Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний аргыг сонгож, зохион байгуулах <ul style="list-style-type: none"> <li>• Эмнэлзүйн бодит үзлэг</li> <li>• Асуумж судалгаа</li> <li>• Туберкулины арьсны сорил</li> <li>• Цээжний рентген зураг авалт</li> </ul> 3) Холбогдох шинжилгээг хийж, оношийг баталгаажуулна. Үүнд:	Аймаг, нийслэлийн ЭМГ, дэгдэлтийн хариу арга хэмжээний баг Энэрэл, Хорих, СЭМҮТ, дэгдэлтийн хариу арга хэмжээний баг

№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хариуцагч
		<ul style="list-style-type: none"> <li>• Цэрний түрхэц</li> <li>• Молекулын түргэвчилсэн арга (Xpert MTB/RIF)</li> <li>• IGRA шинжилгээ</li> <li>• Өсгөвөрлөх шинжилгээ зэрэг бол эмэнд тэсвэржилт тодорхойлох шинжилгээ</li> <li>• Өсгөвөрлөх шинжилгээ зэрэг бол MIRU-VNTR эсвэл геномын дараалал тогтоох шинжилгээ</li> </ul> <p>4) Дэгдэлт зогсох хүртэлх хугацаанд сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг давтан зохион байгуулах.</p> <p>Давтамж:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Насанд хүрсэн хүн: 6 сар тутамд Зураг 2-д заасан алгоритмын дагуу хийнэ.</li> <li>- Хүүхэд: асуумж, эмнэлзүйн үзлэгийг сар тутамд, цээжний рентген шинжилгээг 6 сар тутамд Зураг 3-д заасан алгоритмын дагуу хийнэ.</li> </ul> <p>5) Илрүүлэх үзлэгийн тайланг гаргах, мэдээлэх</p>	
4	Дэгдэлтийн үеийн эмнэлзүйн менежментийн арга хэмжээ	<p>1) Дээрх үзлэг, шинжилгээгээр илэрсэн идэвхтэй сүрьеэгийн тохиолдлыг энэ зааврын холбогдох хавсралтад заасны дагуу бүртгэж, эмчилгээ хяналтад хамруулна.</p> <p>2) Сүрьеэгийн халдварлагдсан тохиолдлыг энэ зааврын холбогдох хавсралтад заасны дагуу бүртгэж, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулна.</p> <p>3) Илрүүлэх үзлэгээр идэвхтэй сүрьеэ болон халдварлагдсан тохиолдол илрээгүй хүмүүст шинж тэмдгийн тандалтыг тогтмол /дэгдэлт зогсох хүртэлх хугацаанд сар тутам/ хийнэ.</p> <p>4) Цээжний рентген шинжилгээ, эмнэлзүйн үзлэгт өөрчлөлттэй боловч нян судлалаар батлагдаагүй тохиолдлыг "Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн"-өөр хэлэлцэж, эмчилгээ хяналтын асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>5) Эмчилгээ хяналтын үзлэг, шинжилгээг хийх</p>	Аймаг, нийслэлийн ЭМГ, дэгдэлтийн хариу арга хэмжээний баг Энэрэл, Хорих, СЭМҮТ дэгдэлтийн хариу арга хэмжээний баг
5	Үр дүнг солилцох, тайлан	<p>1) Дэгдэлтийн үед талбарт авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 7 хоног бүр дээд шатны болон хамтрагч байгууллагуудад мэдээлэх</p> <p>2) Дэгдэлтийн хариу арга хэмжээ авах баг нь дэгдэлт гарахад нөлөөлсөн хүчин зүйлс, эх уурхайн талаарх мэдээллийн нууцыг хадгалж ажиллана.</p> <p>3) Эрсдэлийн үеийн мэдээлэл харилцааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх</p>	Аймаг, нийслэлийн ЭМГ, Энэрэл, Хорих, СЭМҮТ дэгдэлтийн хариу арга хэмжээний баг
6	Дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг дүгнэх	<p>1) Сүрьеэгийн дэгдэлтийн үед авч хэрэгжүүлсэн шуурхай хариу арга хэмжээний байдалд ХӨСҮТ-ийн СТСА нь үнэлгээ, дүгнэлт өгнө.</p> <p>2) Үнэлгээний уулзалтыг зохион байгуулах</p> <p>3) Үр дүнг тайлагнах</p>	Аймаг, нийслэлийн ЭМГ, Энэрэл, Хорих, СЭМҮТ дэгдэлтийн хариу арга хэмжээний баг ХӨСҮТ-ийн СТСА



Зураг 2. Дэгдэлтийн үед насан хүрэгсдийг сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах алгоритм



**Зураг 3. Дэгдэлтийн үед 15 ба түүнээс доош насны хүүхдийг сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах алгоритм**

### **5. Дэгдэлтийн үеийн лабораторийн шинжилгээ**

Сүрьеэгийн лаборатори нь сорьц цуглуулж, холбогдох шинжилгээг хийж, үр дүнг мэдээлэх, тайлагнах үүргийг гүйцэтгэнэ. Дэгдэлтийн үеийн талбарын баг нь сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулахын өмнө лабораторийн шинжилгээний аргыг сонгож, бэлтгэл хангуулна.

#### **5.1 Дэгдэлтийн үед эмнэлзүйн шинжлэгдэхүүн цуглуулах, хадгалах, тээвэрлэх**

5.1.1 Цэрний шинжлэгдэхүүн цуглуулах: Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлоос 2 удаагийн /тухайн үеийн болон маргааш өглөөний/ цэрний шинжлэгдэхүүн цуглуулна. Хөдөө орон нутагт 3 хоногийн дотор, нийслэлд 1 хоногийн дотор лабораторид хүргэнэ.

5.1.2 Бусад төрлийн шинжлэгдэхүүн цуглуулах: Булчирхайн эд, плеврийн шингэн, идээ, шээс, өтгөн, нугасны ус гэх мэт шинжлэгдэхүүнийг холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулна. Нэг хоногийн дотор лабораторид хүргэнэ.

5.1.3 Цуглуулсан шинжлэгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх: Цуглуулсан шинжлэгдэхүүнийг хүйтэн хэлхээний горимын дагуу (+2 - +8°C)-нд хадгалж, тээвэрлэнэ.

## **5.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн лабораторид хийгдэх нян судлалын шинжилгээ**

Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлоос цуглуулсан цэрний шинжлэгдэхүүнд түрхцийн болон молекулын түргэвчилсэн шинжилгээ (XpertMTB/RIF) хийнэ.

## **5.3 ХӨСҮТ-ийн СҮЛЛ-д хийгдэх шинжилгээ**

Сүрьеэгийн дэгдэлтийн үед талбарт нян судлалаар батлагдсан тохиолдлын өсгөвөрлөх болон эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээг гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд (судалгаа шинжилгээний зорилгоор) микобактерийн сэлгэн давтагдах нэгж-тандемийн хувирамтгай тоот давтамж (MIRU-VNTR), геномын бүрэн дараалал тогтоох шинжилгээг (Next Genome Sequencing-NGS) олон улсын лавлагаа лабораторитой хамтран гүйцэтгэнэ. Нэг эх уурхайтай дэгдэлтийн үед үүсгэгчийн генотип болон эмэнд тэсвэржилт нь өөр хоорондоо таарч байдаг. Генотипын мэдээлэл байхгүй тохиолдолд тархвар зүйн бусад холбоо хамааралд үндэслэн тогтооно.

## **5.4 Сүрьеэгийн халдварыг илрүүлэх шинжилгээ**

Сүрьеэгийн халдварыг илрүүлэх зорилгоор интерферон гамма тодорхойлох шинжилгээ (IGRA) эсвэл туберкулины (Mantoux аргаар) арьсны сорилыг ашиглана.

# **6. Сүрьеэгийн дэгдэлтийн үеийн үйл ажиллагаа**

## **6.1 Ерөнхий хэсэг**

6.1.1 Сүрьеэгийн дэгдэлт гарсан үед сүрьеэгийн дэгдэлтийг судлах, хянах, таслан зогсоох үүрэг бүхий "Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг", "Талбарын баг"-ийг томилон ажиллуулна.

6.1.2 Дэгдэлтийн цар хүрээ, газарзүйн тархац, тухайн онцлог, нөхцөл байдлыг харгалзан холбогдох байгууллага, албадыг татан оролцуулж багийг өргөжүүлж болно.

6.1.3 Дарга нь хариу арга хэмжээ авах багийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой гаргаж танилцуулна.

6.1.4 Дэгдэлтийн судалгаанд оролцох мэргэжилтэн бүр гүйцэтгэх үүргийн талаар нэгдсэн ойлголттой байж, бүхий л үйл ажиллагаанд цагийг үр ашигтай зарцуулах шаардлагатай.

6.1.5 Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийн томилгоо, нарийвчилсан төлөвлөгөөг урьдчилан боловсруулж, жил бүр тодотгол хийж, баталгаажуулж ажиллана.

6.1.6 "Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг", "Талбарын баг" нь холбогдох ёс зүйн удирдамжийг мөрдөж ажиллана.

## **6.2 "Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг"-ийн бүрэлдэхүүн, үүрэг**

Хөрөнгө нөөцийг дайчлах, бүрдүүлэх, удирдан зохион байгуулах, хувь хүн, иргэн, байгууллага, харилцагч талуудын хамтын үйл ажиллагааг зохицуулах үүргийг хүлээнэ. Сүрьеэгийн дэгдэлтийг илрүүлж, өвчилсөн тохиолдлуудыг богино хугацаанд эмчилгээнд хамруулж, халдварын гинжин хэлхээг таслан зогсооход үйл ажиллагааг чиглүүлнэ. Үүнд:

6.2.1 Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийг бүрдүүлэх, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулна.

6.2.2 Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт, үзлэгийг зохион байгуулна.

6.2.3 Дэгдэлтийн үеийн тохиолдол бүрийг судална.

6.2.4 Урьдчилсан үр дүнг солилцох, тайлагнана.

6.2.5 Дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээг дүгнэнэ.

"Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг"-ийн бүрэлдэхүүн, тэдний гүйцэтгэх үүргийг Хүснэгт 9-д заав.

Хүснэгт 8. "Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг"-ийн бүтэц, гүйцэтгэх үүрэг

Чиглэл	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
Дарга	Аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга	<ul style="list-style-type: none"> <li>• "Дэгдэлтийн хариу арга хэмжээний баг"-ийг Засаг даргын захирамжаар томилуулах</li> <li>• Дэгдэлтийг тандах, хянахад тулгамдсан асуудлыг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх</li> <li>• Талбарын багийг чиглүүлж, бодлогын дэмжлэг үзүүлэх</li> <li>• Дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах нөөц бүрдүүлэх</li> <li>• Санхүүгийн болон мэргэжлийн тусламжийн талаар зөвлөлдөж, төсөв, санхүү, нөөцийг шийдвэрлэх</li> <li>• Багийн гишүүдийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, танилцуулах</li> <li>• Талбарын багийг хүний нөөцөөр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх</li> <li>• Дэгдэлтийн талаарх албан ёсны мэдээллийг олон нийтэд хүргэх</li> <li>• Үйл ажиллагааны болон дэгдэлтийн явцын тайланг хэлэлцэх, хянан баталгаажуулах</li> <li>• Шуурхай хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>• Хурлыг удирдан зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх</li> </ul>
Нарийн бичгийн дарга	Аймгийн нийгмийн мэндийн дарга ЭМГ-ын эрүүл мэндийн албаны дарга Дүүргийн ЭМТ-ийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>• Багийн гишүүдэд зар хүргэх, хурал зохион байгуулах бэлтгэл хангах</li> <li>• Хурлын тэмдэглэл хөтлөх баталгаажуулах</li> <li>• Талбарын багийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах</li> <li>• Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийн үйл ажиллагааны явцын болон эцсийн тайланг нэгтгэн бичиж, хянуулах</li> <li>• Мэргэжил арга зүйн зөвлөмжийг багийн гишүүдийн хамт боловсруулах</li> </ul>
Гишүүд	Аймаг, нийслэлийн ЭМГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын байцаагч	<ul style="list-style-type: none"> <li>• Дэгдэлт гарсан байгууллагын орчны эрүүл ахуйн нөхцөл байдалд үнэлгээ хийх, дүгнэлт гаргах</li> <li>• Ялангуяа байгалийн агааржуулалт (хөндлөн, босоо агааржуулалт)-ын хэвийн үйл ажиллагаанд хяналт хийх</li> <li>• Хүн амын нягтаршил, стандарт нормтой харьцуулалт хийх</li> <li>• Эрүүл ахуйн бусад арга хэмжээ: гар угаах, бие засах нөхцөлийг үнэлэх</li> <li>• Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан эсэхийг тодруулах</li> <li>• Бусад</li> </ul>
	Аймаг, дүүргийн санхүүгийн мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>• Талбарын багийн ахлагчтай хамтран төсөв, төлөвлөлт хийх</li> <li>• Шуурхай хариу арга хэмжээ авахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх</li> <li>• Санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж авах ажлыг зохион байгуулах</li> <li>• Гэнэтийн дэгдэлтийн үед зарцуулах хөрөнгө нөөцийн сантай байх асуудлыг шийдвэрлэх</li> </ul>
	Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ-ийн тархвар судлаач	<ul style="list-style-type: none"> <li>• Сүрьеэгийн дэгдэлтийг баталгаажуулах, дэгдэлтийн тохиолдлын жагсаалт гаргах</li> <li>• Шуурхай хариу арга хэмжээ авах "Талбарын баг"-ийн ахлагчаар ажиллах, түүнд заагдсан үүргийг гүйцэтгэх</li> <li>• Талбарын багийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тухай бүрд танилцуулах</li> </ul>



Чиглэл	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
	Дэгдэлт гарсан байгууллагын удирдлагын төлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>▪ Дэгдэлтийн урьдчилсан болон эцсийн дүгнэлт зөвлөмжийг хэлэлцүүлэх</li> <li>▪ Шуурхай хариу арга хэмжээ авах "Талбарын баг"-ийг тухайн байгууллагад ажиллах нөхцөлийг бүрдүүлэх</li> <li>▪ Талбарын багийн ахлагчтай нягт хамтран ажиллах ба шаардлагатай мэдээ, мэдээллийг шуурхай гаргаж өгөх</li> <li>▪ Тухайн байгууллагад "Талбарын баг" ажиллахад шаардлагатай өрөө, тасалгаа, гэрэл цахилгаан, дулаан, цэвэр ус зэрэг дэд бүтцийн бүх асуудлыг шийдвэрлэх</li> <li>▪ Тухайн байгууллагад дэгдэлтийг хариуцаж ажиллах албан тушаалтныг томилгох</li> <li>▪ Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт, үзлэг шинжилгээнд хамрагдах хүмүүсийг бүрэн хамруулах арга хэмжээ авах</li> <li>▪ Сүрьеэтэй илэрсэн хүмүүсийг (ажилтан, албан хаагч, суралцагч, хоригдол) эмчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээг авах</li> <li>▪ Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдах шаардлагатай хүмүүсийг бүрэн хамруулах, эмчилгээний явцын хяналт хийх</li> <li>▪ Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх арга хэмжээ авах</li> <li>▪ Хувь хүний нууцыг чандлан хадгалах</li> <li>▪ Байгууллагад гарсан үйл явдлын талаар мэргэжлийн байгууллагатай хамтран үнэн зөв мэдээлэл өгөх, аливаа цуурхлаас урьдчилан сэргийлэх</li> </ul>
	Аймаг, дүүргийн олон нийттэй харилцах хэвлэлийн ажилтан	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, гарсан үр дүнг багийн бүх гишүүдэд өдөр тутам илгээх, цаашдын чиглэлийг боловсруулах</li> <li>▪ Дэгдэлт гарсан байгууллагын ажилтан, албан хаагч, суралцагч, хүмүүжигч зэрэг зорилтот бүлгийн мэдлэгийн түвшинг тогтоох, хэрэгцээг гаргаж, шаардлагатай мэдээллээр хангах</li> <li>▪ Мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн боловсруулж, хүн амд оновчтой хувилбараар хэрхэн хүргэх талаар багийн хурлаар хэлэлцүүлэх</li> <li>▪ Үүссэн нөхцөл байдалтай холбоотой олон нийтийн санаа бодлыг сонсох, иргэдэд тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл цуглуулах, эргэн мэдээллээр шуурхай хангах</li> <li>▪ Хүн ам, хамтран ажиллагч түншүүдийг нэг эх үүсвэрээр, нэгдсэн мэдээллээр хангах</li> </ul>
	Аймаг, дүүргийн боловсролын газрын мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбарын багийн ахлагчтай нягт хамтран ажиллах ба шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах</li> <li>▪ Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт, үзлэг шинжилгээнд хамрагдах хүмүүсийг бүрэн хамруулах арга хэмжээнд хяналт тавих</li> <li>▪ Байгууллагад гарсан үйл явдлын талаар мэргэжлийн байгууллагатай хамтран үнэн зөв мэдээлэл өгөх, аливаа цуурхлаас урьдчилан сэргийлэх</li> </ul>

Эрсдэл өндөртэй байгууллагад (эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэргийн анги, хорих анги, асрамжийн газар гэх мэт) сүрьеэгийн дэгдэлт бүртгэгдсэн үед салбар дундын хамтарсан баг ажиллана. Дээрх дэгдэлтийн хариу арга хэмжээний болон талбарын багийн гишүүдийн албан тушаалтай дүйцэхүйц удирдлага, эмч, мэргэжилтэн, бусад албан тушаалтан багийн бүрэлдэхүүнд ажиллана. Тухайн байгууллагын нутаг дэвсгэрт байрлах эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж, ХӨСҮТ нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

### 6.3 Талбарын багийн бүрэлдэхүүн, бүтэц, гүйцэтгэх үүрэг

Сүрьеэгийн дэгдэлтийн үед талбарт шуурхай арга хэмжээг авч ажиллана. Энэхүү баг нь дэгдэлтийн судалгаа, хариу арга хэмжээг зохион байгуулахад дараах үйл ажиллагааг зохицуулна.

6.3.1 Дэгдэлтийн тухай мэдээллийг тухайлбал тохиолдлын тодорхойлолт, тохиолдлын жагсаалт, бичиглэл судалгаа, мэдэгдэж буй хавьтлуудын мэдээлэл, шинжилгээний үр дүнгүүдийг шалгана.

6.3.2 Эх уурхай буюу индекс тохиолдлын халдвартай байсан хугацааг тодорхойлно.

6.3.3 Хавьтлын хүрээг тодорхойлно.

6.3.4 Эрсдэл өндөртэй байгууллагад (анги танхим, сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, ажлын байр, эмнэлэг, дотуур байр, цэргийн анги гэх мэт) дэгдэлт гарсныг тандана.

6.3.5 Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний төлөвлөгөөг боловсруулж, зарцуулагдах санхүүжилтийн тооцоог гарна.

6.3.6 Лабораторийн шинжилгээний арга болон лабораторийг сонгож, бэлтгэл хангуулна.

6.3.7 Сүрьеэтэй өвчтөнийг тусгаарлан эмчлэх, халдвар хяналтын дэглэм зэрэг авах хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.8 Дэгдэлтийн хариу арга хэмжээний чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллага болон ХӨСҮТ-ийн СТСА-тай хамтарч ажиллана.

6.3.9 Тухайн дэгдэлтийн үеийн тулгамдаж буй асуудал болон явцын талаарх мэдээллийг дэгдэлтийн хариу арга хэмжээний багтай солилцох хурлыг зохион байгуулна.

6.3.10 "Дэгдэлтийн судалгааны тайлан" бичиж, Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ-ийн СТСА-нд хүргүүлнэ.

6.3.11 ХӨСҮТ-өөс мэргэжлийн баг урих зэрэг нэмэлт туслалцаа авах эсэхийг шийдвэрлэнэ "Талбарын баг"-ийн бүрэлдэхүүн, тэдний гүйцэтгэх үүргийг Хүснэгт 10-д заав.

#### Хүснэгт 9. Талбарын багийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг

Бүрэлдэхүүн	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
Багийн ахлагч	Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ-ийн тархвар судлаач	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбарын ажлыг зохион байгуулах, хяналт тавих</li> <li>▪ Талбарт ажиллахаас өмнө багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг танилцуулах</li> <li>▪ Дэгдэлт гарсан газрын удирдлагатай хамтран ажиллах</li> <li>▪ Талбарт цугларсан мэдээллийн чанарт хяналт тавих</li> <li>▪ Дэгдэлтийн хариу арга хэмжээний багийг мэдээллээр хангах</li> <li>▪ Талбарт ажиллаж урьдчилсан болон эцсийн дүгнэлт гаргаж хэлэлцүүлэх</li> <li>▪ Талбарын тайлан бичих</li> </ul>

Бүрэлдэхүүн	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
Гишүүд	Аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Асуумж авах</li> <li>▪ Эмнэлзүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд эмнэлзүйн эмч нарын багийн хурлыг зохион байгуулах</li> <li>▪ Эмнэлзүй, лабораторийн шинжилгээ, цээжний рентген зураг, туберкулины арьсны сорилын үр дүн зэрэгт үндэслэн тухайн оролцогчийг сүрьеэтэй эсэх дүгнэлт гаргах</li> <li>▪ Тохиолдлын тодорхойлолтын дагуу ангилах</li> <li>▪ Цаашдын эмчилгээ, хяналтын асуудлын талаар шийдвэр гаргах</li> </ul>
	Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Эмнэлзүйн үзлэг хийх, нарийн мэргэжлийн бусад эмч нартай хамтран ажиллах</li> <li>▪ Эмнэлзүй, лабораторийн шинжилгээ, цээжний рентген шинжилгээ, туберкулины арьсны сорилын үр дүн зэрэгт үндэслэн тухайн оролцогчийг сүрьеэтэй эсэх дүгнэлт гаргах</li> <li>▪ Тохиолдлын тодорхойлолтын дагуу ангилах</li> <li>▪ Цаашдын эмчилгээ, хяналтын асуудлын талаар шийдвэр гаргах</li> </ul>
	Аймаг, дүүргийн дүрс оношилгооны эмч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбарт цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг хянан ажиллах</li> <li>▪ Цээжний рентген шинжилгээ хийх бэлтгэл хангах</li> <li>▪ Цээжний рентген шинжилгээний дүгнэлт гаргах</li> <li>▪ Цэрний шинжилгээ авах хүмүүсийг тодорхойлох</li> <li>▪ Маягтуудыг бүрэн хөтлөх</li> <li>▪ Оролцогчдод шаардлагатай зөвлөгөө өгөх</li> <li>▪ Талбарт ажилласан тайлан бичих</li> </ul>
	Аймаг, дүүргийн лабораторийн эмч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбараас ирүүлсэн шинжлэгдэхүүнийг хүлээж авах, хадгалах, боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх</li> <li>▪ Шаардлагатай шинжилгээ хийж, дүгнэлт гаргах (түрхэц, молекулын түргэвчилсэн шинжилгээ (Xpert MTB/RIF)</li> <li>▪ ХӨСҮТ-ийн СҮЛЛ-т илгээх шинжлэгдэхүүнийг журмын дагуу хүргүүлэх</li> <li>▪ Дэгдэлтийн үед лабораторийн мэдээллийн менежментийг хариуцах</li> <li>▪ Лабораторид шаардлагатай урвалж бодис, оношлуур хэрэгслийн жагсаалтыг гаргаж, багийн ахлагчид танилцуулах</li> <li>▪ Лабораторид биоаюулгүй ажиллагааны журмыг баримтлан ажиллах</li> <li>▪ Дэгдэлтийн үед ажилласан ажилчдын илүү цагийн бүртгэл хийх</li> <li>▪ Явцын болон эцсийн тайлан бичиж багийн ахлагчид өгөх</li> </ul>
	Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан	<ul style="list-style-type: none"> <li>▪ Илрүүлэлтэд оролцогчдоос асуумж авах</li> <li>▪ Илрүүлэлт болон сүрьеэ өвчний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах</li> </ul>

Бүрэлдэхүүн	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
		<ul style="list-style-type: none"> <li>▪ Тухайн байгууллагад сүрьеэгийн дэгдэлт гарахад нийгмийн талаас нөлөөлсөн байж болох хүчин зүйлийг илрүүлэх, дүгнэлт гаргах</li> </ul>
	Дэгдэлт гарсан байгууллагын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбарын багийн ахлагчийн өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах</li> <li>▪ Илрүүлэлт эхлэхээс өмнө талбарын багийн ажиллах өрөө тасалгааг бэлтгэх</li> <li>▪ Оролцогчдыг тогтоосон хуваарийн дагуу илрүүлэлтэд хамрагдахыг зохицуулах</li> <li>▪ Нэг газар хэт бөөгнөрөл үүсэхээс сэргийлэх</li> <li>▪ Илрүүлэлтийн талаар оролцогчдод зөвлөгөө, мэдээлэл өгөх</li> <li>▪ Илрүүлэлтэд хамрагдаагүй оролцогчийг байгууллагын удирдлагад танилцуулах, бүрэн хамруулах арга хэмжээ авах</li> </ul>
	Аймаг, дүүргийн боловсролын газрын мэргэжилтэн (боловсролын байгууллагад дэгдэлт гарсан үед)	<ul style="list-style-type: none"> <li>▪ Илрүүлэлт, үзлэг зохион байгуулах байгууллагын удирдлагатай холбогдох, хамтарч ажиллах</li> <li>▪ Илрүүлэлт, үзлэг зохион байгуулах байгууллагын бэлэн байдалд хяналт тавих</li> <li>▪ Талбарын багийн ахлагчийн өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах</li> </ul>
	Аймаг, дүүргийн рентген техникч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг баримтлан ажиллах</li> <li>▪ Зөөврийн рентген аппаратын хэвийн ажиллагааг хангах</li> <li>▪ Цээжний рентген зургийг чанарын өндөр түвшинд авах</li> <li>▪ Талбарт авсан бүх зургийг тусгай хавтас үүсгэж цахим хэлбэрээр хадгалах</li> <li>▪ Илрүүлэлтэд оролцогчдын зураг алдагдахаас сэргийлэх</li> <li>▪ Бүх цээжний рентген зургийг хатуу дискт хуулж, багийн ахлагчид өгөх</li> <li>▪ Зөөврийн рентген аппаратыг ачиж, угсрах болон бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллана</li> </ul>
	Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборант	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүн цуглуулахад шаардлагатай материал бэлтгэх</li> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүн цуглуулах талаар оролцогчид нарийвчилсан зөвлөгөө өгөх</li> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүн цуглуулах</li> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүнийг хүйтэн хэлхээний горимын дагуу хадгалах, тээвэрлэх</li> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүнийг хуваарийн дагуу лабораторид зөөвөрлөх</li> <li>▪ Лабораторийн маягтуудыг бүрэн хөтлөх</li> <li>▪ Цэрний шинжлэгдэхүүн өгөөгүй оролцогчийн талаар тухай бүр багийн ахлагчид мэдээлэх</li> <li>▪ Талбарт хог хаягдлыг зааврын дагуу устгах</li> </ul>

Бүрэлдэхүүн	Албан тушаал	Гүйцэтгэх үүрэг
	Аймаг, дүүргийн сүрьеэгийн сувилагч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Туберкулины арьсны сорилыг хүйтэн хэлхээний горимын дагуу тээвэрлэх, хадгалах</li> <li>▪ Илрүүлэлтэд оролцогчдод туберкулины арьсны сорилын талаар мэдээлэл өгөх</li> <li>▪ Туберкулины арьсны сорил тавих, хэмжилт хийх, дүгнэлт гаргах</li> <li>▪ Маягтуудыг бүрэн гүйцэд хөтлөх</li> <li>▪ Туберкулины арьсны сорил тавиулаагүй эсвэл хэмжилт хийлгээгүй оролцогчийн талаар багийн ахлагчид мэдээлэх</li> <li>▪ Үлдэгдэл туберкулины арьсны сорилыг зааврын дагуу устгах, тэмдэглэл хөтлөх</li> <li>▪ Талбарт ажилласан тайлан бичих</li> </ul>
	Аймаг, дүүргийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	<ul style="list-style-type: none"> <li>▪ Явуулын болон зөөврийн рентген аппаратын хэвийн үйл ажиллагааг хангах</li> <li>▪ Нэмэлт засвар үйлчилгээг цаг тухай бүр хийж байх</li> <li>▪ Талбарт орчны болон ажлын байрны цацрагийг хэмжиж хянах, тэмдэглэл хөтлөх</li> </ul>
	Аймаг, дүүргийн жолооч	<ul style="list-style-type: none"> <li>▪ Талбарын багийн ахлагчийн өгсөн үүргийн дагуу ажиллах</li> <li>▪ Цацраг үүсгүүрийг тээвэрлэх журмыг баримтлах</li> <li>▪ Автомашиныг бэлэн байдалд байлгах засвар үйлчилгээ</li> <li>▪ Шатахуун, тослох материал</li> <li>▪ Зөөврийн рентген аппарат болон лабораторийн хэрэгслийг ачиж буулгах, зөөх, угсрах зэрэгт туслах</li> <li>▪ Багийн гишүүдийн зам, тээврийн аюулгүй байдлыг хангах</li> </ul>

## Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөний журам

### 1. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь эмнэлзүйгээр илэрсэн болон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн, тэдний хавьтлыг эмчилгээнд хамруулах, эмчилгээний горим солих, эрчимт шатны эмчилгээнээс үргэлжлэх шатанд шилжүүлэх, эмчилгээний үр дүнг тооцох зэрэг асуудлыг шийдвэрлэх үндэсний болон аймаг, дүүргийн түвшний эмч нарын зөвлөгөөний багийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулна.

Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөнийг зохион байгуулах багийг Үндэсний түвшинд ХӨСҮТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал; аймгийн түвшинд нэгдсэн эмнэлэг, нийслэлд дүүргийн эрүүл мэндийн төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тус тус ахалж ажиллана.

### 2. Үндэсний түвшинд зохион байгуулах эмч нарын зөвлөгөөний бүрэлдэхүүн

Дарга:

- ХӨСҮТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд захирал

Нарийн бичиг:

- ХӨСҮТ-ийн СТСА-ны ЭТС-ийн асуудал хариуцсан эмч

Гишүүд:

- ХӨСҮТ-ийн СТСА-ны дарга
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникийн зөвлөх эмч
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникийн ЭТС-ийн тасгийн эрхлэгч
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникийн хүүхдийн тасгийн эрхлэгч
- ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач
- ХӨСҮТ-ийн СҮЛЛ-ийн эмч
- ХӨСҮТ-ийн СТСА-ны сүрьеэгийн эм хариуцсан эмч
- ХӨСҮТ-ийн СТСА-ны хяналтын эмч
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникийн ЭТС-ийн тасгийн эмч
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиникийн ЭТС-ийн тасгийн эмч
- ХӨСҮТ-ийн дүрс оношилгооны эмч
- ХӨСҮТ-ийн чанарын албаны менежер
- Харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерын эмч
- Шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн эмч

### 3. Аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулах эмч нарын зөвлөгөөний бүрэлдэхүүн

Дарга:

- Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн ЭМТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичиг:

- Сүрьеэгийн зохицуулагч эмч

Гишүүд:

- Чанарын албаны дарга, менежер
- Сүрьеэгийн эмч нар

- Тархвар судлаач
- Дүрс оношилгооны эмч
- Лабораторийн эмч

Шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн эмч, мэргэжилтэн

#### **4. Үндэсний түвшинд зохион байгуулах эмч нарын зөвлөгөөний үйл ажиллагаа**

4.1 Үндэсний түвшинд ОЭТС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөнийг зохион байгуулж өвчтөн төвтэй сүрьеэгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх үндсэн үүрэгтэй байна.

4.2 Үндэсний түвшинд ажиллах эмч нарын зөвлөгөөнийг ажлын долоо хоног бүрийн Пүрэв гарагт 10:00 цагт цахим болон танхимаар зохион байгуулна.

4.3 Үндэсний түвшинд рифампицины тэсвэржилт орсон бүх төрлийн эмийн тэсвэржилт болон бусад нэгдүгээр эгнээний эмэнд тэсвэртэй хүнд хэлбэрийн сүрьеэтэй, хавсарсан эмгэгтэй, эмчилгээ тохирохгүй байгаа сүрьеэгийн тохиолдол, хавьтлуудыг хэлэлцэнэ.

4.4 Аймгуудын олон эмэнд тэсвэртэй оношлогдсон өвчтөнийг эмчилгээнд оруулах, эмчилгээний горим солих асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөөнийг цахим хурал хэлбэрээр зохион байгуулна.

#### **5. Аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулах эмч нарын зөвлөгөөний үйл ажиллагаа**

5.1 Аймаг, дүүргийн түвшинд сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх зөвлөгөөнийг зохион байгуулж өвчтөн төвтэй сүрьеэгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх үндсэн үүрэгтэй байна.

5.2 Аймаг, дүүргийн түвшинд ажиллах эмч нарын зөвлөгөөний хуралдах өдөр цагийг нь тухайн байгууллагын дотоод журмаар зохицуулан товлон.

5.3 Аймаг, дүүргийн түвшинд ажиллах эмч нарын зөвлөгөөнөөр сүрьеэгийн дэгдэлт, идэвхтэй илрүүлэлт, хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдан эмнэлзүй, бодит үзлэг, дүрс оношилгоонд өөрчлөлттэй боловч нян судлалаар батлагдаагүй тохиолдлын эмчилгээ болон сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээ, тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлыг хэлэлцэнэ.

5.4 Сүрьеэгийн эмчилгээ хийлгэх явцад гарсан гаж нөлөөний өөрчлөлтийн үед авах арга хэмжээ, эмийн эмчилгээний дараах мэс заслын тусламж үйлчилгээ шаардлагатай зэрэг тохиолдлыг хэлэлцэнэ.

5.5 Аймаг, дүүргийн багийн зөвлөгөөний шийдвэрийг сүрьеэгийн цахим бүртгэл, мэдээллийн систем (TUBIS)-д бүртгэж мэдээлнэ.

5.6 ХӨСҮТ-ийн СТСА-ны хяналтын эмч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавьж хамтран ажиллана.

5.7 Хамтран ажилладаг байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, ажлын үр дүнг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

#### **6. Үндэсний болон аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулах эмч нарын зөвлөгөөний бүрдүүлэх материал**

Сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх зорилгоос хамааран дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

6.1 Зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх үндэслэл, эмнэлзүй, бодит үзлэгийн дүгнэлт, өвчний түүх болон холбогдох шинжилгээний хариу, хавсарсан өвчин зэрэг холбогдох мэдээлэл бүхий танилцуулга

6.2 Эмчилгээний эхэнд болон явцад хийгдсэн сүрьеэгийн лабораторийн шинжилгээний хариу (түрхэц, өсгөвөр, молекулын түргэвчилсэн шинжилгээ (XpertMTB/RIF), эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ гэх мэт)

- 6.3 Цээжний рентген шинжилгээ (хиймэл оюунд суурилсан технологи бүхий)
- 6.4 Урьдчилан сэргийлэх эмчилгээний асуудал хэлэлцэх тохиолдолд сүрьеэгийн халдвар илрүүлэх шинжилгээ (Интерферон гамма тодорхойлох шинжилгээ (IGRA), туберкулины арьсны сорил )
- 6.5 Бусад шинжилгээ (Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ (Элэгний үйл ажиллагаа, креатинин, кали зэргийг үзсэн байна), шээсний ерөнхий шинжилгээ, бамбай булчирхайн дааврын шинжилгээ, хараа зүйн үзлэгийн дүгнэлт, зүрхний цахилгаан бичлэг, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил гэх мэт)
- 6.6 Бусад бүрдүүлэх материал (Өвчний түүх, холбогдох анхан шатны маягтууд, өмнөх эмчилгээний түүх, эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ хийлгэж горим сольсон, үр дүнгүй, дахисан зэрэг тохиолдолд хийгдэж байсан эмчилгээг түүхчлэн бэлтгэж ирнэ.)
- 6.7 Хавьтлын дэлгэрэнгүй мэдээлэл (хавьтлын овог, нэр, нас, хүйс, урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлт, эмчилгээ)
- 6.8 Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх эмчилгээнд оруулахад өвчтөн болон гэр бүлийн гишүүн нь эмчилгээтэй танилцан, эмчилгээ хийлгэхийг зөвшөөрсөн, тодорхой харьяалалтай байх шаардлагатай.

## **7. Эмч нарын зөвлөгөөний гишүүдийн үүрэг хариуцлага**

- 7.1 Дарга:
- 7.1.1 Зөвлөгөөнийг удирдан шийдвэр гаргах
- 7.1.2 Зөвлөгөөний багийн гишүүдэд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан үүрэг даалгавар өгөх
- 7.1.3 Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих
- 7.1.4 Хамтрагч байгууллагуудтай ажиллахад дэмжлэг үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллахад туслалцаа үзүүлэх
- 7.1.5 Зөвлөгөөний тэмдэглэлтэй танилцах баталгаажуулах, биелэлтийг нарийн бичгийн даргаар гаргуулах
- 7.1.6 Зөвлөгөөний шийдвэрийг санал хураалтын зарчмаар гаргах ба нийт зөвлөгөөний багийн гишүүдийн 50 хувиас дээш нь дэмжсэн шийдвэрийг хүчинтэйд тооцно.
- 7.2 Зөвлөгөөний нарийн бичгийн дарга
- 7.2.1 Зөвлөгөөний бэлтгэлийг ханган, хэлэлцэх асуудлын хөтөлбөр, ирцийн бүртгэл, тэмдэглэл, шаардлагатай баримт бичгийг хөтлөн явуулах
- 7.2.2 Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлыг даргаар баталгаажуулж гишүүдэд тараах
- 7.2.3 Зөвлөгөөнд бэлтгэх, шаардлагатай баримт материалыг цуглуулах, архив үүсгэх хөтлөх
- 7.2.4 Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх
- 7.2.5 Зөвлөгөөний шийдвэрийн биелэлтийг хангах, энэ чиглэлээр зөвлөгөөний гишүүдэд үүрэг чиглэл өгөх, хамтран ажиллах, зөвлөгөөний даргад танилцуулах
- 7.3 Чанарын албаны дарга, менежер
- 7.3.1 Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай танилцан хэлэлцэж саналаа өгөх
- 7.3.2 Зөвлөгөөний дарга байхгүй тохиолдолд зөвлөгөөнийг удирдах
- 7.3.3 Зөвлөгөөнөөр хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж сүрьеэгээс бусад шаардлагатай нэмэлт шинжилгээ оношилгоо, эмчилгээний асуудлыг зохицуулах
- 7.4 Сүрьеэгийн эмч нар
- 7.4.1 Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай танилцан хэлэлцэж саналаа өгөх
- 7.4.2 Зөвлөгөөнөөр хэлэлцэх тохиолдлын эмчилгээний түүх, өмнөх шинжилгээний дүгнэлт, цээжний рентген зураг зэрэг шаардлагатай мэдээллийг бэлтгэх, танилцуулах, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлэх
- 7.4.3 Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн өөрт холбогдолтой хэсгийг тэмдэглэлд заасан хугацаанд биелүүлэх, эргэн мэдээлэх



- 7.4.4 Шаардлагатай үед үйлчлүүлэгчтэй биечлэн уулзаж үзлэг шинжилгээ хийх, эмнэлзүйн зөвлөгөө өгөх, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх
- 7.4.5 Хариуцсан алба/диспансер, өрх, сум тосгоны ЭМТ, сум, хорооны засаг захиргаатай уулзах, зохион байгуулалттай холбоотой бэлтгэл ажлыг хангахад оролцох
- 7.4.6 Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн дагуу тохиолдлыг эмчилгээнд хамруулах эмчилгээний үр дүнг тооцох, тайлан мэдээг гаргах, танилцуулах
- 7.5 Тархвар судлаач
  - 7.5.1 Сүрьеэгийн дэгдэлт, идэвхтэй илрүүлэлт, хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдан эмнэлзүй, бодит үзлэг, дүрс оношилгоонд өөрчлөлттэй боловч нян судлалаар батлагдаагүй тохиолдлын талаар мэдээлэл өгөх
  - 7.5.2 Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөн, тэдний хавьтлын үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэлт, авах арга хэмжээний мэдээлэл өгөх, хэлэлцүүлэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих
- 7.6 Дүрс оношилгооны эмч
  - 7.6.1 Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай танилцан хэлэлцэж саналаа өгөх
  - 7.6.2 Зөвлөгөөнөөр хэлэлцэх тохиолдлын рентген зурагт дүгнэлт гаргах, танилцуулах,
  - 7.6.3 Шаардлагатай тохиолдолд дэгдэлт, идэвхтэй илрүүлэлтийн үед дүрс оношилгооны эмчид мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх
- 7.7 Бусад мэргэжлийн эмч мэргэжилтэн
  - Шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн эмч, мэргэжилтэн зөвлөгөөнд оролцож холбогдох үзлэг шинжилгээ хийлгэх, дүгнэлт, зөвлөгөө өгөх

## Сүрьеэгийн эм бэлдмэл, урвалж бодис, халдварын сэргийлэлт, хяналтын хэрэгслийн ханган нийлүүлэлтийн журам

### 1. Нийтлэг үндэслэл

Монгол улсад сүрьеэ өвчнийг оношлох, илрүүлэх, эмчлэх зэрэг сүрьеэгийн тусламж үйлчилгээнд шаардагдах чанартай урвалж бодис, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, халдварын сэргийлэлт, хяналтын хэрэгслийн бүтээгдэхүүнийг ил тод, оновчтой байдлаар ханган нийлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

- Сүрьеэгийн оношлуур, урвалж бодис, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг тооцоолох
- Боломжийн үнэтэй, чанартай эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь ханган нийлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад тохиромжтой тоо хэмжээгээр нь хуваарилж, түгээх
- Нэгжүүдэд тохиромжтой хадгалалт түгээлтийн тогтолцоог бий болгох
- Нөөцийг хянах, мэдээллийн тогтвортой урсгал бүхий тайлангийн тогтолцоог бүрдүүлэх
- Ханган нийлүүлэлтийн санхүүжилтийг цаг тухайд нь шийдвэрлэх, хуваарилах.

### 2. Сүрьеэгийн эм, урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгох

Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль, тушаал, заавар, стандартын дагуу ДЭМБ-ын жагсаалтад багтсан эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрээс нь чанарын шаардлага хангасан, эмчилгээний горимд нийцсэн тун хэмжээтэй сүрьеэгийн эсрэг эм, урвалж бодис, халдвар хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэрэгцээнд тохируулан сонгоно.

#### 2.1 Сүрьеэгийн эсрэг эмийн тооцоолол

Улсын хэмжээнд шаардлагатай сүрьеэгийн эсрэг эмийн тооцооллыг өмнөх оны өвчлөл, эсвэл тооцоолсон өвчлөлийн мэдээлэл, агуулахын нөөц, байвал зохих нөөц, аюулгүйн нөөц, өмнөх батлагдсан захиалгад тулгуурлан ХӨСҮТ-ийн СТСА-ны эм хариуцсан эмч нь эмийн нэр төрөл, тоо ширхэг тус бүрээр тооцоолж гаргана. Гарсан тооцооллыг сүрьеэгийн эмийн менежментийн багт танилцуулж баталгаажуулна. Сүрьеэгийн эсрэг хосолсон болон дан найрлагатай эмүүдээс сонгон хэрэглэх бөгөөд ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу сүрьеэгийн эсрэг нэгдүгээр эгнээний эм 100 хувь 6 сарын аюулгүйн нөөцтэй байх шаардлагатай.

#### 2.2 Урвалж бодис, оношлуурын тооцоолол

Ихэвчлэн бодит хэрэглээнд тулгуурладаг тул оношлуур, бусад бүтээгдэхүүний дуусах хугацаа, шаардлага хангахгүй болох зэрэг хүчин зүйлтэй уялдуулж шаардлагатай урвалж, оношлуурын төрөл, хэмжээ, бодит хэрэглээг тодорхойлж тооцно.

#### 2.3 Хувийн хамгаалах хэрэгслийн тооцоолол

Улсын хэмжээнд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслийн тооцооллыг сүрьеэгийн өвчлөл, тухайн үеийн агуулахын үлдэгдэлд үндэслэн бодно.

### 3. Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага эм, оношлуур захиалах

3.1 ХӨСҮТ-ийн СТСА нь дараах бичиг баримтын дагуу сүрьеэгийн эсрэг эм, урвалж бодис, халдвар хяналтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жилийн ханган нийлүүлэлтийн хүсэлтийг бэлтгэнэ. Ханган нийлүүлэлтийн хүсэлтэд ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө, урьдчилсан тооцоолол, бүтээгдэхүүний төрөл, түүний үзүүлэлт, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, олон улсад баримталж буй нэгж үнийг тусгасан байна.

3.2 ХӨСҮТ-ийн СТСА нь ХӨСҮТ-ийн тендерийн үнэлгээний хороо, Олон улсын эм хангамжийн байгууллага, Глобаль сангийн хөтөлбөр зохицуулах нэгж зэрэг байгууллагад улсын хэмжээнд хэрэглэх сүрьеэгийн эмийн баталгаажсан захиалгыг санхүүжилтийн эх үүсвэрт тохируулан илгээж эмийг захиална.

3.3 ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиник, аймаг, дүүргийн сүрьеэгийн алба/диспансер, СЭМҮТ, ШШГЕГ-ын харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Энэрэл эмнэлгийн эм хариуцсан эмзүйч нь сүрьеэгийн өвчлөл, өөрийн агуулахын үлдэгдэлд тулгуурлан байвал зохих нөөцийг үндэслэн батлагдсан хуудасны дагуу эм, оношлуурыг захиална.

3.4 Захиалгыг сүрьеэгийн зохицуулагч, тасгийн эрхлэгч, албаны дарга баталгаажуулна.

#### **4. Эм, урвалж, оношлуурыг тээвэрлэх, хүлээн авах**

4.1 Тээвэрлэлт хийхэд холбогдох стандартад заагдсан нөхцөлийг баримтална.

4.2 Үндэсний түвшинд ХӨСҮТ-ийн сүрьеэгийн эм зүйч, ахлах лаборант, агуулахын менежер эсвэл нягтлан бодогч зэрэг хоёроос дээш хүний бүрэлдэхүүнтэй баг нь бараа бүтээгдэхүүнийг хүлээн авна.

4.3 Ханган нийлүүлэлтийн стандартад заасны дагуу бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, шалгах хуудсыг бөглөж, агуулахад хадгална.

4.4 Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь захиалсан барааны тоо ширхэг, үзүүлэлтийн дагуу бүтээгдэхүүн хүлээж авсан тэмдэглэл хөтлөн зориулалтын өрөөнд хадгална.

#### **5. Эм, оношлуур, халдвар хяналтын хэрэгслийн зарцуулалтын тайлан мэдээ**

Сүрьеэгийн эсрэг эм, урвалж бодис, халдвар хяналтын хэрэгслийн зарцуулалтын тайланг батлагдсан маягтын дагуу ХӨСҮТ-ийн СТСА, СҮЛЛ-д сар бүрийн эхний 10 хоногт багтаан цаасан болон цахим хэлбэрээр илгээнэ.

#### **6. Агуулах болон нөөцийн менежмент**

6.1 Сүрьеэгийн эсрэг эм, оношлуур, халдвар хяналтын хэрэгслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын дагуу хадгална.

6.2 Сүрьеэгийн эсрэг эмийн нөөцийг үндэсний түвшинд 50-100%-ийн аюулгүйн нөөцтэй, аймгийн түвшинд улирал, дүүргийн түвшинд сарын нөөцтэй байхаар тооцоолж бүрдүүлнэ.

#### **4. Сүрьеэгийн эсрэг эм, оношлуур, халдвар хяналтын хэрэгслийн чанарын хяналт**

7.1 Бараа бүтээгдэхүүн хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор бүтээгдэхүүн бүрээс санамсаргүй түүвэрлэлтийн аргаар дээжийг сонгон, бүтээгдэхүүний нэр, үйлдвэрлэгч, гарал үүсэл, серийн дугаар зэрэг мэдээллийг хавсарган, эмийн лабораторид шинжилгээнд илгээнэ.

7.2 Эмийн лаборатори нь эмийн чанарын шинжилгээг хийх ДЭМБ болон ISO/IEC 17025-ийн сертификаттай байна.

7.3 Шаардлагатай тохиолдолд олон улсын лавлагаа лабораторид хяналт хийлгэж болно.